



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА

(Судалгааны тайлан)



Улаанбаатар  
2023 он

Энэхүү судалгааг Дэлхийн банкны санхүүжилттэйгээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд гүйцэтгэв.

## БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА

(Судалгааны тайлан)

**Захиалагч:** “Боловсролын чанарын шинэчлэл” төсөл

Боловсрол, шинжлэх ухааны яам

### **Гүйцэтгэгч судалгааны баг:**

*Судалгааны багийн ахлагч:*

Х. Отгонбаатар БСҮХ-ийн Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрхлэгч, доктор

*Судалгааны багийн гишүүд:*

Б. Лхамцэрэн БСҮХ-ийн Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, доктор  
У. Мягмаржав БСҮХ-ийн Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан  
Б. Эрдэнэчимэг БСҮХ-ийн Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан  
О. Цоморлиг БСҮХ-ийн Боловсролын бодлого, төлөвлөлтийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан  
П. Нямсүрэн ШУТИС-ийн МХТС-ийн Холбооны салбарын ахлах багш, доктор  
Б. Буяндэлгэр БСҮХ-ийн Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн секторын эрхлэгч, доктор  
Б. Нямсүрэн БСҮХ-ийн Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан  
Б. Баярмаа БСҮХ-ийн Хүний хөгжлийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан  
С. Батхуяг МУБИС-ийн Багшийн сургуулийн Математик, байгалийн ухааны тэнхимийн багш, доктор

*Зөвлөх багийн гишүүд:*

М. Итгэл БСҮХ-ийн захирал, доктор  
С. Санжаабадам БСҮХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор  
Г. Бямбацэрэн МУБИС-ийн Багшийн сургуулийн захирал, доктор

*Техникийн редактор*

Х. Цэцэгжаргал Судлаач  
Б. Баярмаа БСҮХ-ийн Хүний хөгжлийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан

## АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт .....	4
Зургийн жагсаалт .....	4
Товчилсон үгийн жагсаалт .....	6
УДИРТГАЛ.....	8
НЭГ. БАГШ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	12
1.1. Багш боловсролын бодлого, эрх зүй .....	12
1.2. Багшийн мэргэжлийн статус, нөлөөлөх хүчин зүйлс .....	13
1.3. Дээд боловсролын сургалтын хөтөлбөр.....	21
ХОЁР. БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭЖ БУЙ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ .....	33
2.1. Бага боловсролын багш бэлтгэж буй үндэсний их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хийсэн судалгааны үр дүн.....	33
2.2. Бага боловсролын багш бэлтгэж буй гадаадын их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээний үр дүн .....	70
2.3. Гадаадын улс орнуудын багш бэлтгэх туршлага .....	96
2.3.2. АНУ-ын багш бэлтгэх туршлага .....	97
2.3.3. Английн багш бэлтгэх туршлага.....	99
2.3.4. Ирландын багш бэлтгэх туршлага .....	100
2.3.5. Канадын багш бэлтгэх туршлага.....	100
2.3.6. Шинэ Зеландын багш бэлтгэх туршлага .....	102
2.3.7. Финляндын багш бэлтгэх туршлага.....	103
2.3.8. Шведийн багш бэлтгэх туршлага.....	104
2.3.9. Нидерландын багш бэлтгэх туршлага .....	105
2.3.10. Эстонийн багш бэлтгэх туршлага .....	105
2.3.11. Өмнөд Солонгосын багш бэлтгэх туршлага .....	106
2.3.12. Сингапурын багш бэлтгэх туршлага.....	107
2.3.13. Японы багш бэлтгэх туршлага .....	108
2.3.14. Испанийн багш бэлтгэх туршлага.....	109
Улс орнуудын багш бэлтгэх үйл явцын тойм .....	109
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ .....	115
ХАВСРАЛТ .....	122
НОМ ЗҮЙ.....	117

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны үе шат.....	10
Хүснэгт 2. Дэлхийн улс орнуудын бага боловсролын чанарын индекс (2017-2018).....	11
Хүснэгт 3. Мэргэжлийн статусын рейтинг.....	16
Хүснэгт 4. Хүн амын өсөлт, 2018 оныхтой харьцуулснаар.....	20
Хүснэгт 5. Шаардлагатай бага боловсролын багшийн тоо, прогноз (2018-2030).....	20
Хүснэгт 6. Төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардал (2016-2018 он) (ЮНЕСКО, Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019).....	30
Хүснэгт 7. Ерөнхий суурь хичээлийн заавал судлах хичээлийн харьцуулалт.....	42
Хүснэгт 8. Ерөнхий суурь хичээлийн сонгон судлах хичээл.....	42
Хүснэгт 9. Мэргэжлийн суурь хичээлийн заавал судлах хичээл.....	43
Хүснэгт 10. Багш боловсролын суурь хичээл харьцуулалт.....	43
Хүснэгт 11. Мэргэжлийн заавал судлах хичээл.....	44
Хүснэгт 12. Мэргэшүүлэх хичээлийн сонгон судлах хичээл.....	44
Хүснэгт 13. Багшлах дадлагын харьцуулалт (2011-2021).....	44
Хүснэгт 14. Сургалтын төлөвлөгөөний нийт кредитийн харьцуулалт (2000-2021 он).....	45
Хүснэгт 15. Их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлийн тоо.....	46
Хүснэгт 16. Хичээлийн хөтөлбөрийн бүтэцийн жишээ.....	46
Хүснэгт 17. Их дээд сургуулиудын ашигладаг сургалтын аргууд.....	47
Хүснэгт 18. Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага.....	49
Хүснэгт 19. Анги, кабинетийн нэр.....	50
Хүснэгт 20. Элсэгчдэд тавих шаардлага.....	52
Хүснэгт 21. Сонгон шалгаруулалтад орох багшид тавих шаардлага.....	55
Хүснэгт 22. Төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага.....	57
Хүснэгт 23. Суралцагчийн үнэлгээ.....	60
Хүснэгт 24. Суралцагчийн тоон болон үсгэн үнэлгээ.....	62
Хүснэгт 25. Их, дээд сургуулиудын хамтын ажиллагаатай байгууллагууд.....	66
Хүснэгт 26. Австралийн Багшийн мэргэжлийн стандарт.....	96
Хүснэгт 27. Калифорнийн багшийн мэргэжлийн стандарт.....	97
Хүснэгт 28. Вашингтон мужийн боловсролын стандарт.....	98
Хүснэгт 29. Английн багш нарын стандарт.....	99
Хүснэгт 30. Багшлах мэргэжлийн дадлагын Онтариогийн стандарт.....	101
Хүснэгт 31. Шинэ Зеландын сургууль төгсөх багш нарын стандарт.....	102
Хүснэгт 32. Улс орнууд дахь багшийн стандарт, багш бэлтгэл, багшлах эрх.....	109
Хүснэгт 33. Улс орнууд дахь багшийн стандарт, багш бэлтгэл, багшлах эрх.....	110

## Зургийн жагсаалт

Зураг 1. Багшийн статусын индекс.....	15
Зураг 2. 2018 оны багшийн статусын индекс (2015 оны PISA-гийн үзүүлэлтээр).....	16
Зураг 3. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн насны байдал, 2017.....	17
Зураг 4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид.....	18
Зураг 5. Багшийн мэргэжлээр суралцагчид.....	19
Зураг 6. Бага боловсролын багшийн тоо, хангалтын хувь.....	20
Зураг 7. Үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулах загвар (Бадарч, Д. ба бусад, 2017).....	22

Зураг 8. Сургалтын хөтөлбөрийн боловсруулах загвар .....	24
Зураг 9. Монгол улсын төрийн өмчийн их сургуулийн орлогын бүтэц .....	29
Зураг 10. Их дээд сургуулийн хөтөлбөр боловсруулахад ашиглаж буй баримт бичгийн ашиглалтын давтамж .....	37
Зураг 11. Ерөнхий суурь хичээлийн багц цагийн эзлэх хувь .....	40
Зураг 12. Мэргэжлийн суурь хичээлийн багц цагийн эзлэх хувь.....	40
Зураг 13. Мэргэжлийн хичээлийн багц цагийн эзлэх хувь .....	41
Зураг 14. Нийт багц цагийн харьцуулалт .....	41
Зураг 15. Элсэгчдэд тавих шаардлага тус хамаарах шаардлага .....	54
Зураг 16. Үнэлгээний хэлбэр.....	62
Зураг 17. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалттай холбоотой судалгааны ажлууд .....	63
Зураг 18. Харилцаа хамтын ажиллагаатай байгууллагын тоо, түүний эзлэх хувь .....	65
Зураг 19. Багш бэлтгэх боловсрол эзэмших хугацаа, боловсролын түвшнээр (2021) .....	111
Зураг 20. Багш бэлтгэх боловсролын талаар шийдвэр гаргахад талуудын үүрэг, оролцоо ...	114
Зураг 21. Дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн төлөөх боловсролыг бодлого, сургалтын хөтөлбөр, багш боловсрол, үнэлгээнд тусгах байдал (2020) .....	115

## Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ББ	Бага боловсрол
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
БХИС	Батлан хамгаалахын их сургууль
БШУ	Боловсрол, Шинжлэх ухаан
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БХ	Боловсролын хүрээлэн
ДБ	Дээд боловсрол
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
ДИБ	Дэлхийн иргэний боловсрол
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕХ	Европын Холбоо
ЗГ	Засгийн Газар
ИДС	Их, дээд сургууль
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУ	Монгол улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
СУИС	Соёл, урлагийн их сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТХ	Тогтвортой хөгжил
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УБ	Улаанбаатар

УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ЭЭШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
ЮНИСЕФ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сан
PISA	Programme for International Student Assessment
ARWU	Academic Ranking of World Universities
RUR	Round University Ranking
QS	Quacquarelli Symonds
RAEX	Expert Rating Agency
STEM	Science, Technology, Engineering and Mathematics
R&D	Research & Development

## УДИРТГАЛ

Бүх шатны боловсролын чанарт нөлөө үзүүлдэг хүчин зүйлсээс хамгийн эерэг нөлөөтэй нь мэргэжлийн чадамжтай багшийн нөөц гэдэгтэй судлаачид санал нийлдэг. 1996 оны Делорын илтгэлд тусгагдсан чухал үзэл баримтлалуудын нэг болох *суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчим*д тусгасан боловсролд нэгдмэл хандах санаа нь боловсролын бодлого, багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг асуудлаар дэлхийн олон оронд явагдаж байгаа хэлэлцүүлэгт ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээнд (2019) “БНСУ-ын Инчон хотноо 2015 оны 5-р сард болсон Дэлхийн боловсролын чуулга уулзалтад оролцогчид Тогтвортой хөгжлийн зорилтын хүрэн дэх боловсролын ерөнхий хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдийн хүрээг тогтоохдоо “Боловсролын бүх түвшинд үр өгөөжтэй суралцахад багш болон багшлахуйн онцгой чухал үүрэг гүйцэтгэх”-ийг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн. Багшлах боловсон хүчний бодлогыг боловсролын бүх түвшинтэй (бага насны хүүхдийн, бага, дунд, бүрэн дунд, МБС, дээд), мөн хувьсан өөрчлөгдөж буй тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулж чадвал боловсролын тулгамдсан хэрэгцээний нарийн холбоо хамаарлыг хангаж, амжилттай хэрэгжих боломжийг нэмэгдүүлнэ” хэмээн дурдсан байна.

Монгол Улсын хувьд Боловсролын тухай хуулийн 28.1.8-д боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах тухай зааснаас гадна Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)”-д багш мэргэжилтний тасралтгүй хөгжлийг боловсролын чанарыг сайжруулах тулгуур зорилт болгожээ. Түүнчлэн суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангах чиглэлээр 2.1.34-д “Багш бэлтгэх сургалтын чанарын баталгаажуулалтын тусгай шалгуур үзүүлэлт бий болгож, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, сургалтын байгууллагад багшлах эрхийн баталгаажуулалтыг үе шаттай хийдэг тогтолцоог бэхжүүлнэ”, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-ний 4.2.4.-т “Шинэ багшийг бэлтгэх, хөгжүүлэх, нийт багш нарын мэргэжлийн болон сургалтын арга зүйг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж, ... судалгааны ур чадвараа нэмэгдүүлэх нөхцлийг сайжруулна” хэмээн тусгажээ. Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Чадварлаг багш” хөтөлбөр нь багш бэлтгэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, багшийн ажлын нөхцөл, цалин хөлсийг сайжруулах, ажиллах нөхцөл боломж, чадвар, чадамжийг дээшлүүлэх, багшийн хөгжилд анхаарч байгаагаараа онцлог юм. Төлөвлөгөөнд “багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг нэг түвшинд хүргэх, түүний чанар, нийцийг албан ёсоор баталгаажуулж, магадлан итгэмжлэх, багшийн мэргэжлийн нэр хүндийг өсгөх зорилгоор нэгдсэн стандарттай болгоно” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайланд (2019) “Монгол Улсад ...1990-ээд оны сүүлчээр ...боловсролын, түүний дотор суралцахуйн төлөвлөлтийг оролтод бус гаралтад баримжаалан тодорхойлсон боловсролын стандарт, сургалтын нээлттэй хөтөлбөрүүд, сонголттой сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт нь “шинжлэх ухааны бэлэн мэдлэг дамжуулдаг багш төвтэй арга зүй”-гээс “суралцагчдын бүтээлч үйлээр шинэ мэдлэг бүтээлгэх суралцагч төвтэй арга зүйд шилжих шинэчлэлийг шаардсан. Өөрөөр

хэлбэл, багшийн албан тушаалын үндсэн чиг үүрэг, багшлах үйлийн агуулга, зарчим, хөдөлмөрийн харилцааг цоо шинээр авч үзэж, шийдвэрлэх хүндхэн сорилтыг бий болгосон юм” гэж дурдаад, “Боловсролын бүх түвшний сургалтад мөрдөх сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, үнэлгээний журам нь ойр ойрхон үндэслэл султай өөрчлөгдөж байгаа нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж байна. ...Тухайлбал, олон улсад өргөн хэрэглэж буй “action oriented”, “competence/competency based” ба “learning outcomes” гэсэн нэр томъёо, тэдгээрийн агуулгыг манай улсын СӨБ-д “үйл ажиллагаанд суурилсан”; бага, дунд боловсролд “цогц чадамжид суурилсан”; МСҮТ-д “чадамжид суурилсан”; их дээд сургуульд “хөтөлбөр ба хичээлийн суралцахуйн үр дүнд суурилсан” гэж янз бүрийн нэр томъёо хэрэглэн хууль, тогтоомжид тусгаж албажуулсан нь нэгдмэл нэг үзэл баримтлал бүхий суралцахуйн гаралтын үр дүнд суурилсан төлөвлөлтийн үзэл санааг боловсролын түвшин бүрд ялгаатай өөрчлөлт явагдаж байгаа мэт зөрүү ойлголтыг хүмүүст төрүүлж, түвшин хоорондын залгамж холбоог бүдгэрүүлэх хандлагатай байгааг анхаарах хэрэгтэй.” мөн “...багшийг их дээд сургуулиудаар бэлтгэх тогтолцоотой боловч төрийн болон хувийн хэвшлийн 40 гаруй их дээд сургуулиуд багш бэлтгэх магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрүүдээр сургалт явуулж байгаа нь бэлтгэж буй багшийн чанарт сөргөөр нөлөөлөхөд хүргэж болзошгүй юм. Иймд багш бэлтгэхдээ үндэсний хэмжээний багш мэргэжлийн үйлийн хүрээг багш бэлтгэх мэргэжлийн хослол, индекс ба ЕБС-ийн зураглал (байршил, хэмжээ, хэв шинж), сургалтын төлөвлөгөөний бүтэц, агуулгын нийцлийг бүрэн хангаж чадахаар боловсруулж батлах хэрэгтэй байна. Шинэчлэн батлах үйлийн хүрээгээ үндэслэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх замаар суралцахуйн оролтын тэгш боломжийг хангах, улмаар багш мэргэжлээр төгсөгчдийн суралцахуйн гаралтын үр дүнг харьцуулан хөтөлбөрүүд тасралтгүй сайжирч байх хүчин зүйлс болох байгууллагын ба хүний нөөцийг чадавхыг бэхжүүлж байх шаардлага байна” гэж зөвлөмжилсөн байна. Энэ талаар Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээнд (2019) “Багш бэлтгэх салбарт төрийн болон хувийн өмчийн нийт 40 ИДС үйл ажиллагаа явуулж байгаагаас 14 нь (орон нутагт 4, төрийн өмчийн 3) бага боловсролын багш бэлтгэж байна. Гэсэн хэдий ч МУБИС дангаараа бага боловсролын багшийн 50-иас илүү хувийг бэлтгэж байна. Эдгээр олон тооны ИДС-ийн бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд нь үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдээгүй<sup>1</sup>, сургууль хооронд ялгаатай байгаа нь өөр хоорондоо зохицон нийцээгүй хөтөлбөрүүдээр бэлтгэгдсэн багшлах боловсон хүчин бий болж, мэргэжлийн чанар, цаашлаад тэгш боломжид нөлөөлж болох юм. Иймд бага боловсролын багш бэлтгэдэг бакалаврын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахын тулд үндэсний болон гадаадын улс орны ижил чиглэлийн хөтөлбөрийг харьцуулан судлах шаардлага бий болж байна.

*Судалгааны зорилго:* Бага боловсролын багш бэлтгэж буй дотоод, гадаадын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулахад оршино. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэв. Үүнд:

- Багшийн статус, багш бэлтгэх тогтолцоо, хөтөлбөрийн сайжруулалтын талаар эрх зүй болон бодлогын баримт бичигт туссан байдлыг тодруулах;

---

<sup>1</sup>Өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд таван их, дээд сургуулийн бага боловсролын багш бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөр БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн байна.

- Бага боловсролын багш бэлтгэж буй дотоодын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн дээд боловсролын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг биелэлтийг тодруулах;
- Бага боловсролын багш бэлтгэж буй гадаадын улс орны их сургуулийн сургалтын хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээ хийх;
- Харьцуулсан шинжилгээний үр дүнд үндэслэн бага боловсролын багш бэлтгэх жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулах.

*Судалгаа арга, аргачлал:* Тус судалгаа нь бүхэлдээ үндэсний болон олон улсын эрх зүй, бодлогын баримт бичиг, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт суурилан хийгдэв. Үүний тулд Ажлын хуудас 1: МУ-ын болон гадаадын улс орны их, дээд сургуульд хэрэгжиж байгаа бага боловсролын багш бэлтгэж буй сургалтын хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээ хийх аргачлалыг боловсруулан ашиглав. Тус ажлын хуудас нь сургалтын хөтөлбөрийн бүтэц, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хөтөлбөрийн агуулга, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, мэргэжлийн зарим хичээлийн хөтөлбөрийн бүтэц, агуулга зэрэг үзүүлэлтийг агуулсан болно.

*Баримт бичгийн судалгаанд:*

- Монгол улсын хууль
- Улсын их хурлын тогтоол
- Засгийн газрын тогтоол
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал
- Бага боловсролын багш бэлтгэж буй их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрүүд

*Олон улсын баримт бичиг*

- ЮНЕСКО, ЭЗХАХБ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагаас гаргасан санамж, зөвлөмж, баримт бичиг

*Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл*

- Судалгаа, төслийн тайлан
- Судлаачдын бүтээл: нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл

*Хүснэгт 1. Судалгааны үе шат*

№	Судалгааны үе шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1.	Судалгааны бэлтгэлийг хангах	- Хамрах хүрээг тодорхойлох, - Ажлын хуудас 1 боловсруулах, - Ажлын хэсгийн судлаачдаар хэлэлцүүлэх, - Сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл цуглуулах хуваарилалтыг хийх.
2.	Судалгааны мэдээлэл цуглуулах	- 17 улсын 30 сургалтын хөтөлбөрийн мэдээллийг цуглуулах - Ажлын хуудас 1-ийн дагуу мэдээллийг шивэх, бааз үүсгэх.
3.	Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнг нэгтгэх	- Нэгтгэсэн судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, - Тайлан бичих.

*Гадаадын улс орнуудыг сонгосон үндэслэл:*

Гадаадын улс орнуудын их, дээд сургуульд хэрэгжиж байгаа бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг харьцуулан шинжлэх, олон улсын туршлагыг өргөн хүрээнд авч үзэхийн тулд дараах зүйлсийг харгалзан улс орнуудыг сонгов. Үүнд:

- Тухайн улс орнууд өөр өөр соёл, ялгаатай боловсролын загваруудад хамаардаг байх.

- Тухайн улс орнууд нь боловсролын чанараараа төлөөлж буй боловсролын загвартаа төдийгүй олон улсад тэргүүлэгч байх.
- Тухайн улс орнуудын бага боловсролын чанарын индексийн үзүүлэлтээр тэргүүлдэг байх (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Дэлхийн улс орнуудын бага боловсролын чанарын индекс (2017-2018)*

*(Department, 2022)*

Улс орон	Финлянд	Швейцар	Сингапур	Нидерланд	Эстон	Бельги	Шинэ Зеланд	Ирланд	Канад	Кагар	АНУ	Норвеги	Малта	Япон	Ливан	Англи	Исланд	Австрали	Тайван	Герман
Индекс (1=маш муу, 7=маш сайн)	6.7	6.2	6.2	5.9	5.8	5.7	5.7	5.6	5.6	5.6	5.5	5.5	5.5	5.4	5.4	5.4	5.4	5.4	5.4	5.3

*Судалгаанаас хүлээгдэж буй үр дүн*

Бага боловсролын багш бэлтгэж буй их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт гаргах.

## НЭГ. БАГШ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 1.1. Багш боловсролын бодлого, эрх зүй

Багш боловсролын бодлого, эрх зүй нь Монгол улсад багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэхтэй холбоотой бодлого, хууль, эрх зүйг хамаарна. Монгол Улсад багш боловсролын талаар 2002 онд батлагдсан Бага, дунд боловсролын тухай хууль, 2008 онд батлагдсан Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон 2018 онд батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиар тус тус зохицуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн багшийг Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “багш бэлтгэдэг их сургууль, дээд сургууль, коллежид бэлдэнэ” гэж заасны дагуу бэлтгэж байна. Энэ нь Монгол Улс багшийг их сургуульд суурилсан багш бэлтгэх бодлого хэрэгжүүлдэг болохыг илтгэж байна. Түүнчлэн хуулийн энэ хэсэгт багшийг зөвхөн их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрөөс гадна коллежид буюу дипломын сургалтаар бэлтгэж болох боломжийг тусгажээ. Гэсэн хэдий ч өнөөдрийн байдлаар багшийг дипломын сургалтаар бэлтгэхээ больж бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэж байна. Багш мэргэжилд элсэхийн тулд иргэд бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх бөгөөд бусад мэргэжлээр элсэгчийн нэгэн адил элсэлтийн ерөнхий шалгалт өгч тэнцсэн байх шаардлагатай юм. Өмнө нь 2013 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас батлагдсан “Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ын дагуу багш мэргэжлээр төгсөгч нь мэргэжлийн шалгалт өгч, тэнцсэнээр багшлах эрхтэй болдог байсан бол 2018 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр 2019 оноос эхлэн багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байхаар болсон юм. Харин багш бус мэргэжил эзэмшсэн иргэн багш мэргэжлээр суралцах бол Бага, дунд боловсролын тухай болон Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу заах арга зүйн сургалтад хамрагдаж, шалгалт өгсний дараа багшлах эрхтэй болохоор зохицуулжээ.

Багш мэргэжлээр төгсөгч нь ажлын байранд гарсны дараа түүний мэргэжлийн тасралтгүй хөгжилд төрөөс дэмжлэг үзүүлэхээр хууль тогтоомжийн хүрээнд зохицуулсан байдаг. Тухайлбал, Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн заах арга, мэргэжлийн ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтыг төвлөрсөн, бүсчилсэн болон зайны хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана”, Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ” гэж тус тус заасан нь төрөөс багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжсэн зохицуулалт болно. Багшийн мэргэжил дээшлүүлэхтэй холбоотойгоор өмнө нь “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг БШУЯ-аас 2013 онд батлан хэрэгжүүлж ирсэн боловч 2017 оноос эхлэн хэрэгжилт нь түдгэлзэж, улмаар хүчингүй болсон байна. Өнөөдрийн байдлаар багшийн мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой зохицуулсан журам байхгүй байгаа хэдий ч хамгийн сүүлд БШУ-ны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих

үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ын дагуу багшийн мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлж байна. Энэхүү зааврын дагуу багшийн хөгжлийг дэмжих сургалт үйл ажиллагааг багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт, багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа гэсэн чиглэлээр зохион байгуулахаар зохицуулжээ.

Дээрх хууль тогтоомжоос гадна багш боловсролын талаар төрөөс тодорхой бодлого боловсруулсан байна. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Зорилт 2.1. -д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилт тавьсан байна. Энэхүү зорилтод хүрэхийн тулд 2021-2030 онд багш бэлтгэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах чиглэлээр хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр бодлогын баримт бичигт тусгажээ. Тухайлбал, 2.1.35.-д “Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай бага ангийн, тусгай хэрэгцээт болон мэргэжлийн багш нарыг бэлтгэж, мэргэжлийг нь тогтмол дээшлүүлнэ”, 2.1.37.-д “Багш бэлтгэх сургалтын чанарын баталгаажуулалтын тусгай шалгуур үзүүлэлт бий болгож, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, сургалтын байгууллагад багшлах эрхийн баталгаажуулалтыг үе шаттай хийдэг тогтолцоог бэхжүүлнэ”, 2.1.34.-д “Багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа, холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана”, 2.1.44.-д “Багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл, харилцаа, холбооны технологийн сургалтын агуулга, стандартыг олон улсын түвшинд хүргэж суралцагчдад цахим бичиг үсгийн боловсрол олгох, цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар олгох, иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагын оролцоог хангана” гэх зэргээр багш боловсролтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорьж байна.

## **1.2. Багшийн мэргэжлийн статус, нөлөөлөх хүчин зүйлс**

Судалгааны олонх үр дүнд дурдсанаар дэлхий нийтээр багшийн мэргэжил эзэмшсэн хүний тоо хангалттай боловч боловсролын чанарыг сайжруулах, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг нь багшлахад тохирох хүнийг энэхүү мэргэжилд татах явдал хэмээн үзсэн байна. Багш мэргэжилд чадварлаг, сайн элсэгчдийг татаж, элсүүлэхэд анхаарал хандуулах явдал нь олон улсын туршлагаар нотлогдоод буй багшийн чанар, сурагчийн сурлагын амжилт (мөн багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил болон сургалтын үр дүн) хоёр хоорондоо эерэг харилцан хамааралтай нь илэрхий байна гэсэн дүгнэлттэй тохирч байна (БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО, 2019).

Орчин үеийн багшийн нийгмийн статуст нөлөөлж буй хүчин зүйлсийн тогтолцоо, холбоо хамаарал, эдийн засаг, санхүүгийн байдалдаа сэтгэл ханамжгүй байдал, нийгэмд өөрийгөө үнэлэгдэхгүй байгааг мэдрэх мэдрэмж, мэргэжлийн тасралтгүй хөгжил зэрэг өргөн хүрээнд

судалгааны ажлууд хийгдсэн байдаг. Эдгээр судалгаанд багшийн нийгмийн статусыг бүрдүүлэгч хэсэгт эдийн засгийн (хувь хүний ажил, амьдралдаа сэтгэл хангалуун байдал, нийгмийн статусыг тодорхойлогч хүчин зүйлс хамаарагддаг эдийн засгийн байдал, хөдөлмөрийн хөлсний хэмжээ), нийгэм-мэргэжлийн (боловсролын түвшин, мэргэшлийн чиглэл), хөдөлмөрийн (хөдөлмөрийн нөхцөл, ажлын ачаалал) норм, эрх мэдлийн статус (нийгмийн талаас багшийн гүйцэтгэх үүргийн хүрээ) зэргийг хамруулан тодорхойлжээ. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас хэрэгжүүлдэг TALIS судалгаа, Дэлхийн банкны санхүүжилттэй хэрэгждэг SABER судалгаануудыг нэрлэж болно. TALIS (OECD, TALIS 2018 Results (Volume I, II), 2018) судалгаа нь багшлахуйн арга зүй, сургалтын байгууллагын орчин дахь хөдөлмөрийн нөхцөл байдал, түүнтэй холбоотойгоор улс орнуудад тулгардаг бэрхшээлийг илрүүлдэг. Тус судалгаанд 2013 онд 37 улс орны боловсролын тогтолцоог хамарч байсан бол 2018 онд 49 улс орныг хамруулсан байна. 2013 оны судалгааны үр дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал: БНХАУ-ын Шанхай хотод багш нарын цалинг 10.0 хувь нэмсэн; Мексик улс багшийн цалинг 25.0 хувь хүртэл нэмэх боломж бүрдүүлсэн; Австрали улс Бага ангийн багш бэлтгэдэг бакалаврын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх, элсэгчдээс тусгайлан шалгалт авах, төгсөгчдийн мэдлэг ур чадвар нь тухай ажлын байрны тодорхойлолттой нийцэж буй талаас нь хянаж, үнэлэх болсон; Итали улс багшийн нийгмийн болон эдийн засгийн асуудлыг оновчтой шийдвэрлэх зорилго бүхий “Сайн сургууль” хөтөлбөр хэрэгжүүлэх болсон; Япон улс багшийн хүрэлцээ хангамжид тулгамдсан асуудлаа олж харснаар багш бэлтгэх асуудлыг нэн чухал тэргүүлэх чиглэлд оруулсан; Англи улс багшийн цагийн ачаалал өндөр байгааг олж харсан, багшийн цагийн ачаалал бууруулах чиглэл барьж буй зэргийг дурдаж болно.


Дэлхийн банк нь улс орны хэмжээнд боловсролын салбарын тогтолцоог шинэчлэх, дэлхийн түвшинд боловсролын шинэчлэлд өндөр чанарын мэдээллийн баазыг бий болгон ажиллаж байна. Боловсролын үр дүнг дээшлүүлэх тогтолцооны нэгэн арга болох SABER (Worldbank) хөтөлбөр нь Дэлхийн банкинд энэхүү зорилгоо хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг бөгөөд улс орнуудын боловсролын тогтолцооны бодлого, байгууллагуудын харьцуулсан өгөгдлийн санг бага насны хүүхдийн хөгжил, боловсролын удирдлагын мэдээллийн систем, боловсролын тогтвортой байдал, хувийн хэвшлийн түншлэл, өмч ба хамрах хүрээ, мэдээлэл, харилцаа холбооны технологи; сургуулийн бие даасан байдал ба хариуцлага; сургуулийн санхүү; сургуулийн эрүүл мэнд, сургуулийн хоол тэжээл; сурагчийн үнэлгээ; багш; дээд боловсрол; ажиллах хүчний хөгжил зэрэг чиглэлээр бүрдүүлж, сайн туршлагаудтай харьцуулдаг.

ОХУ-ын Москвагийн Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны их сургуулиас явуулсан судалгаанд багшийн нийгмийн статусыг хэмжих судалгааны загварыг ашигласан бөгөөд дараах үндсэн элементийг илрүүлжээ. Тухайлбал, нийгмийн нэр хүнд (нийгэмд багшийн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх байдал, нийгмийн нэр хүндийн шатлалд багшийн эзлэх байр суурь, бусад мэргэжилтэй харьцуулсан байдал, хөдөлмөрийн хөлсний хэмжээ); эцэг эх болон сурагчдын зүгээс үзүүлэх хүндэтгэл; багш өөрийн мэргэжлийн үйл ажиллагааны янз бүрийн аспектэд сэтгэл хангалуун байдал: хөдөлмөрийн үр дүн, мэргэжлийн сонголт, чөлөөт цаг, өөрийгөө бүтээлчээр харуулах зэрэг юм. Багш өөрийн мэргэжлийн статусыг сөргөөр хүлээж авах үндсэн шалтгаануудад эдийн засгийн хувьд хангалтгүй нөхцөл байдал, багшийн халаа, солио; сургуулийн бюрократ удирдлагын тогтолцоо; хэтэрхий их ачаалал, сургуулийн дээд удирдлагын өмнө хүчин мөхөс байдал; стандарчилал, багшийн өөрийгөө илэрхийлэх

боломж, бүтээлч эрх чөлөөг боогдуулах байдал; багшийн сөрөг дүрийг бий болгох; багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагуудын нэр хүндгүй байдал; нийгэм дэх боловсролын үнэ цэнийн уналт зэргийг авч үзсэн байна. Судалгаанд оролцогчдын 91 хувь нь ажлын байрандаа сэтгэл хангалуун байгаа бол үлдсэн 10 хүрэхгүй хувь нь ажлаа солих, өөр салбарт ажиллах хүсэлтэй байсан бөгөөд нь энэ 5 жил хүртэл ажиллаж байгаа залуу багш нар юм. Багшийн статусыг доогуур мэдэрч байгаа гол шалтгаануудад чөлөөт цаг бага, нийгэмд багшийн ажлын нэр хүнд доогуур байдал гэжээ. Харин сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны бие хүний сонголттой холбоотой эерэг хүчин зүйлд “мэргэжил сонголтондоо сэтгэл хангалуун байдал”, “өөрийн хөдөлмөрийн үр дүнд сэтгэл хангалуун байдал”, “бүтээлчээр өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх байдал” зэрэг багтжээ (Хуснутдинова, 2017).

Дэлхийн олон улс оронд багш мэргэжлийн нэр хүнд эрс унаж байгаа хандлага ажиглагдаж байна. Их Британийн судлаачид 1967-2003 онд багшийн статус, мэргэжлийн тухай ойлголт хэрхэн өөрчлөгдсөн талаар судалгаа хийжээ. 1967 онд багшийн мэргэжил 4.2, 1979 онд 3.7, 1988 онд 2.9, 1997 онд 2.4, 2003 онд 2.2 оноогоор тус тус үнэлэгджээ. Энэхүү судалгаагаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зөвхөн олон нийт төдийгүй багшид өөрт нь шийдвэрлэх нөлөөг авч үзжээ. Судалгааны үр дүнд орчин үеийн багш нь өөрийн мэргэжлийн имидж, нэр хүнд төлөвшихөд багш өөрөө идэвхтэй оролцох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрчээ. “Багшийн статусын глобал индекс” төслийн хүрээнд Их Британийн эрдэмтэд дэлхийн 21 орны багшийн нийгмийн статусын эрэмбийг тогтоожээ (foundation, 2013).

Зураг 1. Багшийн статусын индекс



Эх сурвалж: (What is the Social Status of Teachers, 2020) <https://soapboxie.com/>

Эрэмбийн үнэлгээнд бага, дунд, ахлах сургуулийн багшийн статусыг зарим мэргэжлүүдтэй харьцуулсан байдал; багшийн мэргэжлийн эрэлт нь эцэг, эх, сурагчдын дунд ирээдүйн мэргэжил болох; сурагчийн зүгээс хүлээсэн хүндлэл зэрэг хувьсагчийг ашигласан бөгөөд БНХАУ-д багшийн статус хамгийн өндөр, харин Израйл, Бразилд хамгийн бага байв.

2015 онд ЮНЕСКО-оос гаргасан “Боловсролын тухай дахин эргэцүүлэх нь” бүтээлд үндэсний удирдах байгууллагуудтай холбогдох асуудлуудыг хөндсөн. Үүнд: багшлах бүрэлдэхүүний насжилт, багшийн хүрэлцээгүй байдал, залуу багш нарыг мэргэжлээр нь ажиллахад тулгарч буй асуудал, бэрхшээл, цаашлаад боловсролын бүхий л түвшин дэх

боловсон хүчний бүрэлдэхүүн дэх хүйсийн ялгаатай байдал зэрэг олон хүчин зүйлийг хамруулжээ. Эдгээр асуудлуудаас хамгийн хурцаар тавигдаж байгаа асуудал бол Европын улс орнуудын тэн хагаст нь тулгарч байгаа багшийн хүрэлцээгүй байдал юм. Хэдийгээр суралцагчдыг багшийн мэргэжилд татах янз бүрийн сэдэл, идэвхжүүлэх арга хэрэгслийг хэрэглэж байгаа ч энэ нь шийдлийг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа юм. Хангалттай тооны оюутнуудыг бага боловсролын багшийн мэргэжлээр суралцуулахаар элсүүлж буй хэдий ч тэдгээр суралцаж буй оюутнууд өөр мэргэжлээр суралцах, сургуулиа орхих зэрэг олон асуудлууд тулгарч байна. 2014 онд явуулсан нэгэн судалгаанд Европын холбооны орнуудын 3 багш тутмын нэг нь багшийн хомсдолтой сургуульд ажиллаж байгаа үр дүн гарчээ. Ялангуяа боловсролын тусгай хэрэгцээт сурагчидтай ажиллах мэргэжлийн багш нар дутагдалтай байгааг дурджээ. Европын холбооны багш нарын 81 хувь нь өөрсдийгөө нийгэмд үнэ цэнэгүй, хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаагаар мэдэрдэг гэсэн дүн гарчээ.

### Багш мэргэжлийн нийгмийн рейтинг


Багшийн статусыг суралцагчдын амжилт (PISA) болон багшийн хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр хэмждэгээрээ чухал ач холбогдолтой. Багш мэргэжлийн нийгмийн статусыг тодорхойлохын тулд дэлхийн 35 улс орныг оролцуулсан судалгаанд бусад 14 мэргэжилтэй харьцуулан үзэхэд бага боловсролын багшийн мэргэжил 11-р байр эзэлжээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Мэргэжлийн статусын рейтинг

Occupation	Average Rank (with 14 being the highest and 1 being the lowest)
Doctor	11.6
Lawyer	9.5
Engineer	9.1
Head Teacher	8.1
Policeman	7.8
Nurse	7.4
Accountant	7.3
Local Government Manger	7.3
Management Consultant	7.1
Secondary School Teacher	7.0
Primary School Teacher	6.4
Web Designer	5.9
Social Worker	5.8
Librarian	4.6

Эх сурвалж: Global teacher status index 2018, Varkey Foundation

Зураг 2. 2018 оны багшийн статусын индекс (2015 оны PISA-гийн үзүүлэлтээр)



Эх сурвалж: Global teacher status index 2018, Varkey сан


Харин багшийн мэргэжилтэй ойролцоо статустай мэргэжлийг нэрлэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь нийгмийн ажилтан мэргэжлийг нэрлэжээ. Малайз, БНХАУ, ОХУ зэрэг улс оронд багшийн мэргэжлийг эмчийн мэргэжилтэй дүйцүүлж байсан бол Испани, Франц, Унгар зэрэг улс орны хувьд номын санч мэргэжилтэй, Португали, Шинэ Зеланд, Япон зэрэг улсуудад сувилагчийн мэргэжилтэй эн зэрэгцэхүйцээр үнэлжээ. Мөн багшийн мэргэжилд илүү хүндэтгэлтэй ханддаг улс орнуудад хөдөлмөрийн хөлснөөс үл хамааран эцэг, эхчүүд хүүхдээ багшийн мэргэжлээр суралцуулахыг ихээхэн дэмждэг байна. Европын

холбооны улс орнуудыг бодвол Ази, Африк, Ойрх Дорнодын улс орнуудад багшийн мэргэжилд илүү хүндэтгэлтэй ханддаг байна. Зураг 2-оос харахад багшийн статус нь PISA-гийн оноо, суралцагчдын амжилтаар тодорхойлогдож буй хэдий ч яг бодит байдал илүү нарийн төвөгтэй байна. Өөрөөр хэлбэл, багшийн статус өндөр байгаа нь хөдөлмөрийн хөлс өндөр байгаатай хамааралгүй, харин тухайн улс үндэстний соёлын өвөрмөц онцлог, уламжлалтай холбоотой ажээ.

### **Багш мэргэжлийн сонирхол татах байдал**

Европын холбооны зарим улс орнууд сайн төгсөгчдийг багш мэргэжилд татах, суралцуулахаар дэмжлэг үзүүлж байна. Финлянд улсад багш мэргэжлээр суралцах, ажиллах сонирхол өндөр байдаг. Европын холбооны 11 улс оронд багшлах бүрэлдэхүүний насжилт тулгамдсан асуудлын нэг болж байгаа бөгөөд ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нийт багш нарын дөнгөж 7 хувь нь 30 хүртэлх насных, 36 хувь нь 50 түүнээс дээш насныхан байна (Зураг 3.). Итали улсад маш ноцтой нөхцөл байдал үүссэн нь нийт багш нарын 53.0 хувь нь 50 түүнээс дээш насных, 17.0 хувь нь 60 түүнээс дээш насныхан байна. Багшлах нөөцийн хувьд хамгийн өндөр насжилттай улсаар Литва-50.0 хувь бүртгэгдсэн бол Эстон-49.0 хувь, Болгар-48.0 хувь, Грек-47.0 хувь, Латви-46.0 хувьтай байна. Бельги, Болгар, Франц, Румын, Швед, Их Британи зэрэг улс орнуудад залуу багш нарыг мэргэжлээр нь тогтвортой ажиллуулахад ихээхэн хүндрэл учирч байгаа нь багш мэргэжлийн нэр хүнд, мэргэжлээрээ цаашид өсөн дэвших боломж хязгаарлагдмал, хөдөлмөрийн хөлс, ачаалал гэх мэт хүчин зүйлүүдтэй нягт холбоотой гэжээ. Иймд Европын улс орнуудад багшийн мэргэжлийн нэр хүндийг өргөх, суралцагчдыг багш мэргэжлээр суралцахад татах бодлогын түвшинд улс төрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ажээ.

Зураг 3. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн насны байдал, 2017



Эх сурвалж: *Teachers in the EU, Eurostat, 2017*

2013 онд Европын Холбооноос (Commission, Study on Policy Measures to improve the Attractiveness of the Teaching Profession in Europe, 2013) багш мэргэжлийн сонирхол татах байдлыг сайжруулах бодлогын арга хэмжээний талаар судалсан нэгэн судалгаа хийгдсэн. Энэхүү судалгааны зорилго нь багш мэргэжилд хамаарах “Боловсрол ба мэргэжлийн бэлтгэлжилт-2020” хөтөлбөрийн хүрээнд Европын комисс болон гишүүн орнуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих байв. Европын улс орнууд дахь багш мэргэжлийн нэр хүнд, сонирхол татах байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх, улмаар тэдгээр хүчин

зүйлс нь улс төрийн болон бодлогын ямар нэгэн санаачлагад нөлөө үзүүлсэн, үзүүлж болох юм гэж үзжээ. Судалгааны зорилгын хүрээнд хэд хэдэн зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Багш мэргэжлийн нэр хүнд, сонирхол татах байдалд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийг илрүүлэх, эдгээр хүчин зүйлс нь улс төрийн ямар нэгэн санаачлагад нөлөө үзүүлсэн, үзүүлж болох бөгөөд улс орнуудын соёлын өвөрмөц онцлогтой уялдуулах;
- Европын орнуудад багш мэргэжлийн өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийх;
- 34 улс орны багш мэргэжлийн сонирхол татах байдалд нөлөөлж байгаа бодлогын арга хэмжээнүүдэд шинжилгээ хийх;
- Бодлогын түвшинд орон нутаг, бүс нутаг, үндэсний болон европын улс орнуудын түвшинд илүү үр ашигтайгаар хэрэгжүүлэх чухал арга хэмжээнүүдийг багтаасан зөвлөмж гаргах байв.

Судалгаа нь баримт бичгийн судалгаа, 31 улс оронд явуулсан онлайн асуулга судалгаа, 20 улсын боловсролын салбарын дээд удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлага гэсэн 3 үе шаттай явагдсан. Судалгааны үр дүнд багш мэргэжлийн сонирхол татах байдалд нөлөөлдөг олон элементүүдийг тодруулсан бөгөөд ажлын байранд гарсан эхний жилүүдэд үзүүлэх дэмжлэгийг сайжруулах, газар зүйн байршлын болоод мэргэжлийн хувьд хөрвөх байдлыг сайжруулах, багшийн гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээг боловсронгуй болгох, багшид тавигдах шаардлагыг эргэн харах, багш мэргэжлийн нийгэм дэх нэр хүндийг сайжруулах, цалин хөлс, ажиллах орчныг сайжруулах гэх мэт олон чиглэлээр шийдвэр гаргах түвшинд зөвлөмж боловсруулагдсан байна.

Монгол улсын хувьд багш мэргэжлийн сонирхол татах байдал харьцангуй тааруу байгааг бага ангийн багшийн ажлын ачаалал, ангийн хүүхдийн тоо их байх, цалин хөлс, үнэлэмжийн асуудалтай холбон тайлбарладаг.

Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын багш мэргэжлээр суралцагчдын тоо тасралтгүй нэмэгдэж байгаа статистик тоо байгаа хэдий ч бага боловсролын чиглэлээр суралцаж буй оюутны тоо нийт суралцагчдын 9.0 хувийг, багш боловсролын бусад мэргэжлийн суралцагчдын дунд 17.2 хувийг эзэлж байгаа (Зураг 4,5) нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд хангалтгүй үзүүлэлт юм.


Зураг 4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид



Дээд боловсрол эзэмшихээр суралцагчдад үзүүлдэг төрөл бүрийн тэтгэлгүүд байдгийн дотор Монгол Улсын Засгийн газрын 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам” (тогтоол, Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2021) -ыг 2014 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн нь багш мэргэжлээр элсэн суралцагчдын тоо, чанарт томоохон түлхэц болсон бодлогын шийдвэр болсон юм. Энэхүү журмын 4.1.5.-д “Төрийн өмчийн их, дээд

сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь хичээлийн жилийн эхний улиралд; суралцагч 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь олгоно” гэж заасан байдаг.

Зураг 5. Багшийн мэргэжлээр суралцагчид



Журам хэрэгжиж эхэлснээс хойш МУБИС-д 2014-2022 онд 7609 оюутан элсэн суралцсан бөгөөд тэдгээрийн 93.0 хувь нь сургуулиа амжилттай төгсөж, 74.0 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна (Алтангоо, 2022). Судалгаагаар багш мэргэжлээр төгсөгчдийн 68.0 хувь нь мэргэжлээрээ 15.0 хувь нь боловсролын бусад байгууллагад ажиллаж, үлдсэн хэсэг мэргэжлийн бус ажил хийж байна. Орчин үеийн хувьсаж буй хөдөлмөрийн зах зээлийн болон боловсролын чиг хандлагаар мэргэжлийн бус ажил хийх нь шүүмжлэх өнцөг биш болсон бөгөөд хүн өөрийн эзэмшсэн мэдлэг, чадварыг ашиглан амьдралаа авч явах чадварыг чухалчилж байгаа билээ.

#### Монгол улсын бага боловсролын багшийн эрэлт хэрэгцээний нөхцөл байдал

Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” (тогтоол, Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай, 2020) 70 дугаар тогтоолоор Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн баталсан бөгөөд зүй ёсоор “Багш, бага боловсрол” мэргэжил багтсан. Энэхүү тэргүүлэх мэргэжлийн жагсаалт салбарын бодлого боловсруулах төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөцийн талаарх санал, салбарын бодлого төлөвлөлтөд үндэслэн гардаг.

Боловсролын дэд салбаруудын төсөөллийн тоон шинжилгээнээс үзэхэд Монгол Улсын нийт иргэдийн тоо 3.238.479 бөгөөд үүний 46.0 хувь буюу 1.491.375 нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна. Хүн амын насаар нь ангилсан өсөлтийн 2030 он хүртэлх таамаглалыг Үндэсний Статистикийн Хорооноос тооцоолж гаргасан (Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019) тооцооллоор 2018 оны мэдээтэй харьцуулсан хүн амын өсөлтийн тоо, хувийг тоймлон харуулбал 2025 он гэхэд бага сургуулийн насны сурагчдын тоо өнөөгийн түвшнээс 14.0 хувь, 2030 он гэхэд 18.0 хувиар өсөх төлөвтэй байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүн амын өсөлт, 2018 оныхтой харьцуулснаар

Сургалтын түвшин		2019	2020	2025	2030
ЕБС	Бага боловсрол	358321	371142	389702	403922
	Өсөлтийн хувь	5.0	9.0	14.0	18.0

Эх сурвалж: Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019

Харин ЕБС-д шинээр ажилд авах шаардлагатай багшийн тоо 31284 байгаагаас бага ангийн багш 5457 (17.4хувь) байна. (Хүснэгт 5)


Хүснэгт 5. Шаардлагатай бага боловсролын багшийн тоо, прогноз (2018-2030)

Хичээл	2018			2020		2025		2030	
	Одоо	Нийт	Шинэ	Нийт	Шинэ	Нийт	Шинэ	Нийт	Шинэ
Бага анги	10397	10759	362	11727	1590	12265	3428	12696	5158
Нийт	29940	34323	4383	38355	9163	49025	23576	53082	31284

Эх сурвалж: Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019

2025 он гэхэд 23576 багшийг шинээр бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд тэдгээрийн 14.5 хувь (3428) нь бага боловсролын багш байна. 2030 он гэхэд ЕБС-д шаардлагатай багш нарын тоо 53082 хүрэх төлөвтэй байгаа бөгөөд үүний 24.0 хувь (12.735) нь бага боловсролын багш байна. Одоогоор хөдөлмөрийн зах зээлд ажиллаж байгаа бага боловсролын багш нарын 1508 нь дипломын, 8137 нь бакалавр, 873 нь магистрын, 4 нь докторын зэрэгтэй; насны хувьд 2966 нь 30 хүртэлх, 3051 нь 30-39, 3359 нь 40-49, 1255 нь 50-59, 118 нь 60-аас дээш насныхан байна. 2000 оноос хойш бага боловсролын багшийн хангалт 95.0 хувиас дээш байсан. Харин 2009-2015 онуудад багшийн хангалт 99.0-100.0 хувь байсан ч 2016 оноос буурсан үзүүлэлттэй байна (Зураг 6).

Зураг 6. Бага боловсролын багшийн тоо, хангалтын хувь



Эх сурвалж: Боловсролын салбарын өгөгдөл, мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019 он

### 1.3. Дээд боловсролын сургалтын хөтөлбөр

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар авч үзсэн тодорхойлолтыг авч үзвэл, сургалтын хөтөлбөр гэж суралцагч ямар агуулгыг, хэзээ, ямар зорилгоор, хэрхэн судлахыг системтэй бөгөөд зорилготойгоор тодорхойлсон баримт бичгийг хэлнэ (UNESCO I. , 2013); тодорхой нэг мэргэжлээр суралцан төгсөхөд шаардлагатай багц хичээлийн тогтолцоо; ажил мэргэжлийн салбарт хөл тавихад нь шаардлагатай мэргэжил эзэмшүүлэн баталгаажуулахын тулд сургалтын байгууллагаас суралцагчдад санал болгож буй сургалтын агуулга болон хэрэглэгдэхүүнийг багтаасан ерөнхий төлөвлөгөө (VETP-1, 2018) гэжээ. Энэхүү боловсрол судлалын ухагдахуун нь ямар утгыг илэрхийлж байгааг үгийн язгуур утга, үндсээр нь үзвэл Curriculum гэсэн үг нь Run Course буюу сургалтыг явуулах гэсэн утга санааг агуулдаг учраас зөвхөн сургалтын агуулгаас гадна сургалтын үйл явцыг чухалчилсан утгыг илэрхийлж байна (Орхон, 2018). Сургалтын хөтөлбөр нь нийгэм ба суралцагчийн сурах хэрэгцээ, түүний үзэл хандлага, зорилго, зорилт, агуулга ба судлагдахуун, арга зүй, сурах орчин, үнэлгээний тогтолцоо гэсэн тодорхойлолтуудаар хэмжигддэг (Null, Curriculum: From Theory to Practice, 2011).

Хөтөлбөр нь хоорондоо холбоо бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа) тодорхой шатны боловсролын зэрэг (degree) олгоход нийцүүлсэн оюутны суралцах хөтөлбөр гэжээ (БШУЯ, 2014).

Дээд боловсролын зорилго, зорилтот үр дүн, гарц, боловсруулах үйл явцаас хамаарч сургалтын хөтөлбөрийг хэд хэдэн төрөл, хэлбэрээр авч үзсэн байдаг. Тухайлбал, Wesley Null “Хөтөлбөр” (Null, Curriculum: From Theory to Practice, 2011) хэмээх бүтээлдээ *либерал хөтөлбөр (liberal curriculum)* (Хичээл хоорондын сэдвүүдэд илүү анхаарч, оюун санааг чөлөөлөх арга барилыг баримталснаар илүү, ухаалаг эргэцүүлэл хийх чадвар олгодог гэж үздэг. Асуудалд олон талаас нь алсын бодолтой хандаж, өөрсдийн үзэл бодлыг илэрхийлдэг); *системт хөтөлбөр (systematic curriculum)* нь системт хандлагаар сургалтын маш өндөр зохион байгуулалтын бүтэцтэйгээр, цогц тогтолцоогоор нь авч үзэхийг зорьдог; *экзистенциалист хөтөлбөр (existentialist curriculum)* -өөр суралцагч өөрт нь шийдвэр гаргах боломжийг олгох хэрэгтэй. Хэрэв хүн сурах зорилго, чиглэлээ өөрөө сонгохгүй бол хэзээ ч хүн болон бүрэн төлөвшихгүй гэж үздэг. Суралцагч ямар чиглэлийн асуудлыг судлахыг хүсч байна түүнийгээ сонгохыг нь зөвшөөрдөг бөгөөд суралцагчдад сонирхол татахуйц, сургалтын агуулгыг орчин нөхцөлтэй нь уялдуулан боловсруулах арга замыг санал болгодог; *радикал хөтөлбөр (radical curriculum)*: хөтөлбөрийн агуулгаас илүү хэн гэсэн ухагдахууныг хөтөлбөр боловсруулагчид анхаарах ёстой гэж үзсэн байна; системтэй сэтгэгчид үр ашгийг онцолж, экзистенциалистууд хувийн эрх чөлөөг чухалчилдаг бол радикалууд эсэргүүцэл, хувьсгал, улс төрийн үзэл баримтлал, бодлогыг чанд баримтлах зэрэгт анхаарлаа хандуулдаг; *прагматик хөтөлбөр (pragmatic curriculum)*: суралцагчийг сорилт, туршилт, алдаагаа ашиглах, замаар асуудлыг өөрсдөө шийдвэрлэх, шийдлийг өөрсдөө олох тийм нөхцөл байдалд авчирдаг. Прагматик үзэлтнүүд үр дүнг тодорхойлохдоо эмпирикийн нотолгоог ашиглан асуудлыг шийдвэрлэх нийтлэг арга барилтай байдаг; *зөвлөлдөх хэлэлцэх хөтөлбөр (deliberative curriculum)* нь хуулийн салбарт түгээмэл хэрэглэгддэг. Хөтөлбөрийг төлөвлөхдөө багш, хөтөлбөр боловсруулагч нар нь зөвлөлдөж аль болох олон сонирхогч, оролцогч талуудын оролцоонд анхаардаг. Тухайлбал эцэг, эх, бизнесийн төлөөлөгч, улс төрч,

багш нар, захиргааны ажилтнууд, ажил олгогч болон бусад сонирхогч талуудын төлөөлөл байж болно.

Сургалтын хөтөлбөрийг ямар арга зүйгээр боловсруулснаас хамаарч салбарын дундын (interdisciplinary), үр дүнд суурилсан (outcome-based), агуулгад суурилсан (content-led planning), асуудалд суурилсан (problem-based), суралцагч төвт хөтөлбөр (learner-centered) зэрэг олон загварыг нэрлэж болно. Эдгээр загвараас үр дүнд суурилсан загварын талаар товчхон өгүүлбэ. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт гарч байгаа гол хандлага бол багш төвтэй сургалтаас оюутан төвтэй сургалт руу аажмаар шилжиж байгаа үйл явц юм. Оюутан төвтэй сургалтын онцлог нь юуны өмнө тухайн сургалтын хөтөлбөрийг дүүргэсний эцэст оюутан хүн юу хийж чаддаг болсныг тодорхойлоход орших бөгөөд энэ арга барилыг үр дүнд чиглэсэн хандлага гэдэг. Өөрөөр хэлбэл, тухайн мэргэжлийн хөтөлбөрийн дагуу боловсрол олох үйл ажиллагааны эцсийн үр дүнг эхэлж тодорхойлоод түүнд чиглүүлэн сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалтын менежментэд бусад шаардлагатай нөөцөд (багшлах хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн гэх мэт) анхаарч хөтөлбөрийг боловсруулдаг аргыг үр дүнд суурилсан боловсрол гэж хэлдэг байна. Үр дүнд суурилсан боловсролын үндсэн дөрвөн зарчим (Бадарч, Д., Очирбат, Б., Намнан, Т., Мөнххүж, Б., 2017) нь:

1. Гол анхаарлаа сурах үйл ажиллагааны үр дүнд төвлөрүүлэх. Өөрөөр хэлбэл, тухайн хөтөлбөр, хичээлийг дүүргээд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг олж авахад нь оюутанд бүх талаар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
2. Илүү өргөн боломж олгох. Оюутанд сурах арга барилаа сонгох боломжийг олгох хэрэгтэй. Бүх оюутныг нэг арга барилаар сургахыг оролдох нь төлөвлөсөн үр дүнд хүргэхгүй. Энэ бол оюутан төвтэй сургалтыг хэрэгжүүлэх зарчим юм.
3. Бүх оюутанд төгсөөд амжилтад хүрэх итгэл үнэмшлийг төрүүлэх. Хэрэв оюутан бүрд сурах боломжийг нь олговоос дийлэнх оюутан өндөр үр дүнд хүрч чадна.
4. Сургалтын төлөвлөгөөг урвуу дарааллаар боловсруулах. Сургалтын төлөвлөгөөг зохиохдоо эхлээд түүний эцсийн үр дүнг урьдчилан харж тодорхойлоод түүнд хүрэх заах арга барил, сургалтын хэлбэрүүд, үнэлгээний аргуудыг сонгодог байна. Ингэхдээ тухайн сургалтын байгууллагын эрхэм зорилго, алсын харааг энд бас бодолцох ёстой. Мөн тухайн мэргэжлийн үндсэн зорилго, шаардлагыг ажил олгогч, төгсөгчид, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тодорхойлно. Энэ бүхэн бол тухайн мэргэжлээр олж авах боловсролын эцсийн үр дүнг тодорхойлоход тус дэм болно. Түүний дараа тухайн сургалтын төлөвлөгөөнд орсон хичээл бүрээр олж авах үр дүн болох мэдлэг чадвар, хандлагыг тодорхойлох ёстой. Үүнийг суралцахуйн үр дүн гэдэг.

Зураг 7. Үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулах загвар (Бадарч, Д. ба бусад, 2017)



Дээд боловсролын сургалтын байгууллагын урт хугацааны төлөвлөлт, алсын хараа, эрхэм зорилгыг хангахад тухайн хөтөлбөр өөрийн үүргээ хэрхэн гүйцэтгэж, ямар чадамжтай,

хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн төгсөгч бэлтгэх ёстойг тодорхойлно гэсэн үг юм.

#### *Дээд боловсролын сургалтын байгууллагын алсын хараа, эрхэм зорилго*

Аливаа их сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүн нь алсын хараа, эрхэм зорилгод агуулагддаг. Энэхүү төлөвлөлт нь сургуулийн хөгжлийн зураглал, урт, дунд хугацааны төлөвлөгөө (стратегийн, мастер төлөвлөгөө)-өөр хэрэгжих бөгөөд улс орны хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн чиг хандлага, үндэсний болон дэлхийн түвшний технологийн хөгжил, чиг хандлага, орчин үеийн мэргэжилтний зайлшгүй эзэмших цогц чадамж зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан хийгдсэн байдаг. Сүүлийн үед үндэсний болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын алсын хараа, эрхэм зорилгоо томъёолохдоо олон улсын, глобал түвшинд тодорхойлох болсон. Энэ нь үндэсний дээд боловсролын үр нөлөөг сайжруулах, интернациональчлалын бодлогыг хэрэгжүүлэх, авьяасын төвлөрлийг бий болгох, зэрэг олон хүчин зүйлсээр нөхцөлдөж байна. Тухайлбал, Монгол улсын төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагууд алсын хараагаа томъёолсон байдлыг авч үзье.

- МУИС – "Дэлхийн түвшний их сургууль" болоход оршино. Үүний дүнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно.
- ШУТИС – Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ.
- АШУҮИС – Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болно.
- МУБИС – Багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх.
- ХААИС – Бүс нутгийн шилдэг их сургуулиудын эгнээнд хүрэх.
- СУИС – Бүс нутгийн шилдэг их сургуулиудын эгнээнд багтсан соёл, урлагийн төрөлжсөн их сургууль болно.
- ДХИС – Шударга ёсыг дэлгэрүүлэгч, Азийн тэргүүлэх их сургуулийн жишигт хүрнэ.
- БХИС – Аюулгүй байдал, батлан хамгаалахын боловсрол, судалгаа боловсруулалтын ажил, үйлчилгээг олон улсын нийтлэг жишигт хүргэх зэргээр томъёолсон байна.

Үндэсний томоохон их сургуулиудын алсын хараа нь бүс нутаг, олон улсад өрсөлдөхүйц, чанартай боловсролыг эзэмшсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх сургалт, судалгаа эрхлэх гэсэн өргөн утгыг агуулж байгаа юм. Энэ нь хөтөлбөрийн зорилго, хэрэгцээг тодорхойлох гол үндэслэл болох учиртай.


#### *Дээд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулалт*

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах асуудал нь уламжлал, тухайн мэргэжлийн хөгжлийн чиг хандлага, хөтөлбөрт хамаарах багшлах хүний нөөцийн чадамж, мэргэшсэн байдал, хөтөлбөрийн суралцахуйн орчин, хэрэглэгдэхүүний нөөц зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж үзэхээс эхлэнэ.

Lattuca, Stark (Lisa R. Lattuca, Joan S. Stark, 2009) нарын санал болгосон Зураг 8-д үзүүлсэн загвар нь хөтөлбөр боловсруулалтын үйл явцыг бүхэлд нь багтаасан байдаг. Энэхүү загварыг дээд боловсрол судлаач Г. Орхон (Орхон, 2018) нэмэн дэлгэрүүлсэн бөгөөд сургалтын хөтөлбөрийн зорилгын доор төгсөгчийн жишиг загварыг тодорхойлох, үүнээс үүдэн суралцахуйн зорилгот үр дүнг тодорхойлохыг нэмж оруулжээ. Хөтөлбөр боловсруулалтыг зөвхөн төлөвлөлтөөр хязгаарлах бус, үйл явц, үнэлгээ, сайжруулалтыг

цогцоор нь тусгаснаараа давуу талтай гэж үздэг. Өөрөөр хэлбэл, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа нийгмийн захиалга, нийгэм-соёлын орчин, хамтын ажиллагаа, түншлэлийн түвшин, оролцогч талуудыг харгалзах хэрэгтэйг харуулсан.

Зураг 8. Сургалтын хөтөлбөрийн боловсруулах загвар



Эх сурвалж: (Lattuca & Stark, 2009, p.6) Academic plans in Sociocultural context.

Зураг 8-д үзүүлсэн загвараас харахад сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын эхний шат нь хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн жишиг загварыг тодорхойлох юм. Гадаад хүчин зүйлд багшийн нийгмийн статус, нийгмийн захиалга, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтний ур чадварын хэрэгцээ, шаардлага, хомсдлыг ажил олгогчийн болон төгсөгчдийн хэрэгцээний судалгаагаар илрүүлдэг.

Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагуудын хувьд сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц мэргэжлийн тэнхим, профессорын багт тулгуурлан хийгддэг. БШУС-ын 2014 оны А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэсэгт сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хэд хэдэн судалгаа, шинжилгээний үндсэн дээр дүгнэх ёстой талаар тусгасан. Үүнд: сэтгэл ханамжийн үнэлгээ (оюутан, төгсөгч), явцын үнэлгээ (оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ), гүйцэтгэлийн үнэлгээ (мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх), хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ, үнэлгээ, хөтөлбөрийн чанарын үнэлгээ журмыг батлах зэрэг болно. БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдэж байгаа сургалтын хөтөлбөрүүд болон судалгаанд ашиглагдаж байгаа бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байдлыг харахад хөтөлбөрийн боловсролын зорилт, хүрэх үр дүнг (PEO, PLO) тодорхойлохдоо тухайн мэргэжлийн орчин үеийн хөгжлийн чиг хандлага, нийгмийн захиалга, эрэлт хэрэгцээ, ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ, мэргэжлийн салбар дахь нөлөөллийн үнэлгээнд тэр бүр ач холбогдол өгөхгүй байгаа нь ажиглагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хүрэх үр дүнгээ тодорхойлоход оролцогч бүх талууд бүхлээрээ, цогцоор ажиллах соёл, хандлага дутагдалтай байна. Дотоод хүчин зүйлд сургуулийн өөрийн нөөц, чадамжид суурилсан зүйлсийг авч үздэг. Тухайлбал, сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх түлхүүр нөхцөл нь санхүүгийн чадавх юм.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцлүүдийн нэг нь санхүүжилтийн асуудал байдаг. Дэлхийн улс орнууд дээд боловсролын салбарт санхүүгийн нөөцийг чөлөөтэй удирдах, санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг татах эрх чөлөөг хэрэгжүүлэх стратегийг түлхүү олгох бодлого баримталж байна. Их сургуулийн ялгаатай байдал, зориулалт, инновац, нийгмийн боловсролын хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж их сургууль, төр хоорондын харилцааг шинэ шатанд гаргах нийгмийн хэрэгцээ бий болжээ. Энэ тохиолдолд төр дээд боловсролын хөгжлийн ерөнхий чиглэлийг тодорхойлох, санхүүжилтийн тодорхой хувийг шийдвэрлэх, орлогын бүтцийг солонгоруулах эрхийг олгох тухай яригдах болсон (Kaiser, F., Maassen, P., Meek, L., Vught, F.van, Weert, E.de., Goedegebuure, L., 2014). Барууны эрдэмтдийн олон судалгаанд их сургуулийн санхүүгийн бие даасан байдал болон түүний үр нөлөөтэй байдлын талаарх үр дүн нилээд дурдагдсан байдаг (Aghion, Philippe, Mathias Dewatripont, Caroline Hoxby, Andreu Mas-Colell, and Andru Sapir., 2010).

Дээд боловсролын санхүүжилтийн хэд хэдэн хувилбарыг авч үзье. Хувь хүн, төрийн бус байгууллага, дээд боловсролын салбарын төрийн бус өмчийн байгууллагууд, сангаас хөрөнгө татахад улс орнууд төрөл бүрийн санхүүгийн болон санхүүгийн бус арга хэрэгслийг ашиглах замаар *нөөцийг хуваарилах* инновацийн загварыг ашиглахыг зорьж байна. Тухайлбал, Нэгдсэн Вант улсад хувь хүний амьдралынхаа туршид авсан тэтгэлэг, амжилт бүтээлийн талаарх (lifelong learning accounts) (Ministry of Housing, 2021) мэдээллийг нэг дор багтаасан Хувийн хуудсыг бий болгох боломж байдаг. Энэхүү загвар нь хувь хүний тасралтгүй суралцах, хөгжих стратегийг дэмждэг. Австрали улсад дээд боловсролын салбарт хувь хүний хөгжилд шууд хөрөнгө оруулалт хийх гэрээ түгээмэл байдаг. Энэхүү гэрээгээр хөрөнгө оруулагч оюутны сургалтын төлбөрийг төлдөг бөгөөд оюутан сургуулиа төгссөний дараа ирээдүйд авах орлогын тодорхой хувийг өгөх бөгөөд энэ нь албан ёсны хүрээнд зохицуулагддаг. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар санхүүжилтийн энэхүү загвар нь дээд боловсролын зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлдэг гэжээ. БНХАУ хөгжлийн тэргүүлэх чиглэлээр (батлан хамгаалах, сурган хүмүүжүүлэх ухаан, анагаах ухаан, хөдөө аж ахуй) суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс даах бөгөөд сургуулиа төгссөний дараа мэргэжлийнхээ дагуу дор хаяж 5-6 жилээс багагүй хугацаагаар ажиллах үүрэг хүлээдэг. Мөн БНХАУ-ын Сангийн яам 2002 онд “Үндсэн зардлын төсөв”, “Төслийн төсөв”-д суурилсан их сургуулийн санхүүжилтийн загварыг боловсруулсан. Үндсэн зардлын төсөвт үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сургуулийн өдөр тутмын зардал хамаарах бол төслийн төсөвт илүү хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал хамаардаг ажээ (Де Мартино, М., Ткач, Г.Ф., Коваленко, С.А., 2020).

Монгол улсын БШУЯ-ны харьяа Боловсролын зээлийн сангаар дамжуулан дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч тодорхой шалгуур (ЭЕШ-ын дундаж оноо, оюутны сурлагын голч дүн, бусад) хангасны үндсэн дээр оюутны хөгжлийн зээл авах боломжтой. МУ-ын Засгийн газрын 2021 оны 275-р тогтоол “Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”, “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалт тэтгэлэг олгох журам”-аар (тогтоол, Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2021) дотоодын болон гадаадын их сургуульд ("Times Higher Education World University Rankings" болон "Academic Ranking of World Universities" байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 100 их, дээд сургууль) суралцаж буйг нэрлэж болно.

*Засгийн газрын зорилтот, үр дүнд суурилсан санхүүжилт* – үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гэрээт ажлыг (төрийн) үр дүнтэй гүйцэтгэхэд чиглэсэн санхүүжилт юм. Санхүүжилтийг олгохдоо хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг тооцдог. Тухайлбал, их сургуулийн суралцагчийн тоо, төгсөгчийн тоо, судалгааны нөөц, судалгааны идэвх, гадаад оюутан, багш, судлаачийн тоо, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, туршилт судалгааны лабораторийн нөөц, их сургуулийн нийгмийн үнэлэмж (нэр хүнд, нөлөө), патентын тоо, үндэсний болон олон улсын их сургуулийн чансаа тогтоох системд эзэлж байгаа байр зэргийг нэрлэж болно. Эдгээр үзүүлэлтийг Европын холбооны 21 орны их сургуулийн ерөнхийлөгчдийн үндэсний чуулганы хүрээнд тодорхойлжээ (Балацкий, 2014). Түүнчлэн үндэсний хэмжээний зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд их сургуулийн оролцоог хангадаг тогтолцоо бий. Тухайлбал, Нэгдсэн Вант улс сурагчдад зориулсан STEM төвүүдийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр идэвхтэй хэрэгжиж байна. Цаашлаад боловсролын байгууллагуудын хамтарсан санхүүжилтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцохыг дэмждэг. Чех улсад боловсролын стратегийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төрийн дэмжлэгийг чухлаар авч үздэг (Салми, Д., Шадрикова, А.П., 2016).

Европын Холбоо болон БНХАУ, БНСУ, ОХУ зэрэг улс орон их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны чадавх, үр дүнг сайжруулах зорилгоор үндэсний хэмжээний томоохон хөтөлбөр, төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Европын Холбооны “Horizon-2020” (Commission, Horizon-2020, 2018), БНХАУ-ын “985” (Han Zhang, Donald Patton, Martin Kenney, 2013), “211” хөтөлбөр, АНУ-ын “National Nanotechnology Initiative” (Government, 2021) төсөл, БНСУ-ын “National R&D program” (Unu-Merit, Universiteit Maastricht, 2005), ОХУ-ын “Стратегия инновационного развития РФ на период до 2020 года” (Федерации, 2011) зэргийг нэрлэж болно. “Horizon-2020” төслийн стратегийн 5 үндсэн зорилтын нэг нь төрийн ба хувийн секторуудын аль алиных нь хөрөнгө оруулалтын түвшинг ДНБ-ний 3 хувьд хүргэн нэмэгдүүлэх замаар судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) нөхцлийг сайжруулах явдал байв. Дээр нэрлэсэн үндэсний хөтөлбөр, төсөл нь ихэнхдээ улс орны засгийн газрын тусгай санхүүжилтээр хэрэгждэг. Олон улсын практикаас харахад их сургуулиуд төсвийнхөө 30.0-50.0 хувийг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орлогоосоо бүрдүүлдэг бөгөөд энэ нь улсын захиалгат судалгаа, судалгааны саналын өрсөлдөөнт санхүүжилт, судалгааны тэтгэлэг, хувийн секторын захиалгат судалгаа зэрэг олон эх үүсвэртэй байдаг. ОХУ-ын Санкт-Петербургийн Политехникийн их сургуулийн орлогын бүтцийг үзвэл төрийн санхүүжилт (60.0 хувь), сургалтын төлбөр (53 хувь), захиалгат судалгаа (23 хувь), гадаад харилцаа (14 хувь), бусад төсөл хөтөлбөр (12 хувь), ОХУ-ын Үндэсний Судалгааны Эдийн Засгийн Их Сургууль (НИУ ВШЭ) нь 2021 оны байдлаар 130 суурь судалгаа, 500 орчим хавсарга судалгаа, ОХУ-ын ШУ-ны сангийн 300 орчим төслөөс судалгааны санхүүжилтийг бүрдүүлсэн байна. Монгол улсын төрийн өмчит нэгэн их сургуулийн орлогын бүтцийг харахад 2021 оны байдлаар сургалтын төлбөр (70 хувь), гэрээт ажил (793,4 сая.төг), гадаад харилцаа (1.160.0 сая төг.), улсын захиалгат төсөл (361,5 сая төг.) байгаа бөгөөд гэрээт ажил, захиалгат судалгаанаас орсон орлого нь ихэнхдээ сургуулийнх бус судлаач, багшийн нэмэгдэл орлого болсон байдаг.

*Эндаумент, зорилтот хөрөнгө оруулалт.* Энэхүү хэлбэр нь дээд боловсролын байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үр нөлөөтэй санхүүжилтийн хэлбэр юм. Эндаумент нь мөнгө, үнэт цаас, үл хөдлөх болон бусад хөрөнгөн хэлбэртэй байдаг. Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, профессор багш, суралцагчдад боломж олгож, санхүүгийн олон талт эх үүсвэр бүрдүүлж, эрдмийн эрх

чөлөөг хангаж өгдөг ач холбогдол бүхий филантроп хандлагад суурилсан санхүүжилтийн загвар. Филантроп хандлага нь нийгмийн сайн сайхны төлөө, шударга зарчимд тулгуурладаг бөгөөд байгууллага, олон нийт, хувь хүмүүсийн үйл ажиллагааны чанарт нөлөөлөх, асуудлын үндсэн шалтгаан, нөхцлийг шийдвэрлэх бодит хандив, тусламж хэлбэрээр хэрэгждэг. Тухайлбал, Харвардын их сургуулийн 2011-2012 оны хичээлийн жилийн нийт орлогыг авч үзвэл, сургалтын төлбөр – 20.0 хувь, эндаумент орлого – 32.0 хувь, засгийн газрын тэтгэлэг, гэрээт ажил – 18.0 хувь, бусад орлого – 26.0 хувийг эзэлж байна (University N. , 2012). Стэнфордын их сургуулийн 2013-2014 оны хичээлийн жилд 28.1 хувь – судалгааны орлого, засгийн газрын санхүүжилт – 83.0 хувь, эндаумент орлого – 21.0 хувь, сургалтын төлбөр – 16.0 хувь байна (University S. , 2014). ХБНГУ-ын эртний, тэргүүлэх их сургуулиудын нэг болох Гейдельбергийн их сургуулийн (Heidelberg University) хувьд төрийн санхүүжилт – 61.0 хувь, ХБНГУ-ын Судалгааны сангаас – 14.6 хувь, үйлдвэрлэгчдийн хөрөнгө оруулалт – 5.7 хувь эзэлсэн байна. Мюнхений Техникийн их сургуулийн нийт орлогын 53.5 хувийг төрөөс, 4.2 хувийг сургалтын төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 8.5 хувь, гуравдагч этгээдээс орсон орлого 32.4 хувь, ХБНГУ-ын Судалгааны сангаас 10.7 хувь, хувийн сектороос 6.4 хувийн орлогыг бүрдүүлжээ. Монгол улсын дээд боловсролын системд анхны хэмээн тооцогддог профессорын эндаумент сан АНУ-ын бизнесмен Зак Тейлорын гэр бүл, АНУ-ын Азийн сан, Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Билл Инфанте, МУИС-ийн Экологийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Болдгив нарын хүчин чармайлтаар 2008 онд байгуулагдсан гэж үздэг. Гэсэн хэдий ч дээд боловсролын салбарт эндаумент сан байгуулах асуудал нь шинэ тутам яригдаж байгаа бөгөөд боловсролын шинэчилсэн хуулийн төсөлд тусгах, их, дээд сургуулиуд эндаумент сантай болох чиглэлээр салбарын яам санаачлан бэлтгэл ажил хийж байна. Гэхдээ энэхүү хандлага нь тухайн улс орны хөгжлийн түвшин, шинжлэх ухаан, дээд боловсролын салбарын олон зуун жилийн хөгжил, тэдэнд итгэх итгэл зэрэг олон хүчин зүйлээр нөхцөлдөн бий болдог соёл ажээ.

*Гадаад харилцаа, хамтын ажиллагааны санхүүжилт.* Дээд боловсролын сургалтын байгууллагын орлогын багагүй хувийг бүрдүүлэх эх үүсвэрийн нэг нь интернациональчлалд суурилсан санхүүжилт юм. Энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн, судлаач, шинжээчийг ажиллуулах, тэргүүн туршлага бүхий их, дээд сургуулиудтай хамтарсан судалгаа, хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын чансаа тогтоох эрэмбийн тогтолцооны үнэлгээ, олон улсын мэргэжлийн нийгэмлэг, холбоодын сүлжээнд хамтран ажиллах, дээд боловсролын хөтөлбөрийн болон байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг олон хэлбэрээр хөгжиж байдаг. Дэлхийд оюутны тоо 1970 онд 28.5 сая байсан бол 2025 онд 262 сая болох төлөвтэй байна. Бүс нутгийн түвшинд үзвэл, оюутны тоо Азид хамгийн өндөр үзүүлэлттэй гарчээ. 2000 онд 41 сая байсан оюутны тоо 2012 он гэхэд 105 сая буюу 155 хувиар өссөн байдаг. Түүний араас 117 хувийн өсөлттэй Латин Америк, 92 хувийн өсөлттэй Африк орно. Харин Европын бүс нутгийн орнуудад дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо хамгийн бага өсөлттэй буюу сүүлийн 12 жилийн хугацаанд 27 хувиар өссөн байна (ЮНЕСКО, Коммюнике, Всемирная конференция по высшему образованию 2009 г. Новая динамика развития высшего образования и исследований в целях социальных изменений и развития , 2009). Дээд боловсролын интернациональчлалын хөгжилд нөлөөлөх олон хүчин зүйл байгаагийн дотор тухайн улс орны болон сургалтын байгууллагын эдийн засгийн чадавх юм. Тухайлбал, сургалтын байгууллагын нэр хүнд (үндэсний, дэлхийн брэнд их сургууль); цагаачлалын

бодлого, байнгын оршин суух боломж; сургалтын зээл тэтгэлэгт хамрагдах боломж; нээлттэй боловсролын нөөц; ажиллаж амьдрах таатай орчин; нэмэлт орлоготой байх боломж, нөхцөл; бизнесийн харилцаа, түншлэлээ хөгжүүлэх сонирхол, боломж; хөдөлмөрийн зах зээлийн өргөн боломж (Лхамцэрэн, 2017) зэргийг дурдаж болно.

*Орлогын бусад эх үүсвэр.* Их сургуулиуд сургалт, судалгааны үндсэн чиглэл, нөөцдөө тулгуурлан санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлдэг. Тухайлбал, их сургуулийн эмнэлэг, студи, телевиз, радио, үйлдвэрлэл, сургалт, судалгааны үндсэн болон тэргүүлэх чиглэлээр мэргэжлийн болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, урт богино хугацааны сургалт, оношилгоо, татвар, төлбөр, хураамж, хүүгийн болон түрээсийн орлого зэрэг олон эх үүсвэрийг нэрлэж болно (Бадарч, Дээд боловсролын онол, арга зүй: Хүний капитал, судалгаа шинжилгээ, бодлого санхүүжилт, 2021).

Монгол улсын төрийн өмчийн их сургуулиудын удирдлагууд тулгамдаж байгаа санхүүгийн асуудлыг дараах хүрээнд тодорхойлсон (Төрийн өмчийн их сургуулиудын санхүү хариуцсан захирал, 2022). Үүнд: их сургуулийн засаглал, удирдлага бусад үйл ажиллагаан дахь улс төрийн нөлөө, оролцоо их; удирдах зөвлөлийн бүтэц, төлөөллийг эргэн харах; сургалтын төлбөр хэт бага, тогтмол санхүүжилт зогссон, боловсролын шинэ хуулийн төслүүдэд төрийн өмчийн их сургуулийн статусыг салаа утгагүйгээр маш тодорхой тусгах; үндсэн үйл ажиллагааны чиглэлээр ашиг, орлого олох хууль, эрх зүйн орчин нөхцлийг бүрдүүлэх; зардлын зарцуулалтад төрөөс хатуу хяналт тавихгүй байх; санхүүгийн эрх чөлөөг өгөх, их сургуулийн зарим зардалд (эрдэм шинжилгээний ажил, хүний нөөцийн хөгжлийг дэмжих г.м.) төрөөс 30-40 хувийн санхүүжилт олгох (Сүхбаатар, 2018) (шинэчилсэн хуулинд тодорхой заалтаар тусгах) зэргийг дурдсан.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чансаа тогтоох үнэлгээний (Times Higher Education, QS World University Rankings, RUR, ARWU, Multirank ба бусад) шалгуур үзүүлэлт ч мөн адил их сургуулийн өрсөлдөх чадвар, сургалт судалгааны чанар, үр дүн (research), орчин, хүний нөөцийн чадавх (teaching), гадаад харилцаа (international diversity), эдийн засгийн тогтвортой байдлаас ихээхэн шалтгаалдаг. Тухайлбал, RUR үнэлгээний системээр их сургуулийг 4 хэсгийн 20 үзүүлэлтээр (багшлахуй - 40 хувь, судалгаа - 40 хувь, гадаад харилцаа - 10 хувь, санхүүгийн тогтвортой байдал - 10 хувь) үнэлдэг. Санхүүгийн тогтвортой байдал хэсэгт: 1. Их сургуулийн орлого, багшийн харьцаа, 2. Их сургуулийн орлого, оюутны харьцаа, 3. Судалгааны орлого, хэвлэгдсэн бүтээлийн харьцаа, 4. Судалгааны орлого, багш, судлаачийн харьцаа, 5. Байгууллагын нийт орлого, судалгааны орлогын харьцааг авч үздэг.


ОХУ-ын RAEX (“Эксперт РА”) (Плеханова, 2021) үнэлгээгээр их сургуулийн санхүүгийн хэд хэдэн үзүүлэлтийг гаргасан байна. Үүнд: төсвийн болон бусад эх үүсвэрийн санхүүжилтийн хэмжээ; эндаумент сангийн хөрөнгийн хэмжээ; хувь хүн, хуулийн этгээдээс их сургуульд үнэ төлбөргүй үзүүлэх санхүүгийн тусламжийн хэмжээ; сургалтын төлбөрийн хэмжээ; Туршилт, зохион бүтээлт, эрдэм шинжилгээний ажлын орлогын хэмжээ; сүүлийн 5 жилийн хугацаанд ОХУ-ын суурь судалгааны сан, шинжлэх ухааны сангийн тэтгэлгийн санхүүжилт зэргийг багтаажээ. Эдгээрээс дүгнэхэд дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн чадавх, санхүүжилтийн эх үүсвэрээс сургалт, судалгааны чанар, хүртээмж, элсэгч, төгсөгчийн чанар, сургалтын орчин, хөтөлбөр, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар, авьяастай хүний нөөцийн төвлөрөл, сэтгэл ханамж, тогтвортой байдал, засаглалын тогтолцоо зэрэг олон зүйл шууд хамаарна.


Монгол улсын дээд боловсролын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл, Боловсролын тухай хуулийн 40.2-т “Төрийн өмчит бүх шатны сургуулийн тогтмол зардал, ...

улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ”, 43.2.4.-д зааснаар “оршин суудаг газраасаа өөр аймаг, хотод суралцаж байгаа оюутны жилд 2 удаа орон нутагтаа ирж, очих зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөх”, Дээд боловсролын тухай хуулийн 18.4-д “Зайлшгүй шаардлагатай зарим мэргэжлээр гадаадад мэргэжилтэн бэлтгэх сургалтын зардлыг жил бүр улсын төсвөөс санхүүжүүлж болох бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хэрэгцээг үндэслэн төрөөс суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилан зохицуулна”, 19.2-т “Өнчин, тахир дутуу болон амьжиргааны баталгаат төвшнөөс доогуур орлоготой өрхийн болон бусад шаардлагатай суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, сургалтын төлбөрт зориулан хөнгөлттэй зээл олгоно”, “Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийн хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөхүүлэн дэмжинэ” гэжээ. Түүнчлэн багшлахуй, сувилахуйн чиглэлээр суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харгалзан тэтгэлэг олгохоор зохицуулалт хийсэн.

Гадаадын улс орнууд санхүүгийн эх үүсвэрийг зохицуулах янз бүрийн арга хэрэгсэл, механизм ашиглан төсвийн хүндрэлийг арилгахыг эрэлхийлэн нөөцийг бүрдүүлж байна. Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн санхүүжилтийн 80.0-90.0 хувийг суралцагчийн сургалтын төлбөр эзэлдэг (Зураг 9).

Зураг 9. Монгол улсын төрийн өмчийн их сургуулийн орлогын бүтэц





Эх сурвалж: Монголын их сургуулиудын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, үнэлгээний тайлан, 2018.

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын орлогын 70-85 хувийг сургалтын төлбөр, 30-15 хүртэл хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс дээд боловсролын салбарт зарцуулж байсан цөөн санхүүжилтийн нэг нь Боловсролын тухай хуулийн 40.2-т төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардлыг төрөөс санхүүжүүлнэ хэмээн заасны дагуу олгогддог санхүүжилт юм. Тогтмол зардал нь их, дээд сургуулийн орлогын бүтцийн дунджаар 5.0-6.0 хувийг тогтмол зардал эзэлдэг (Хүснэгт 6.) байсан бөгөөд 2019 оноос тус санхүүжилтийг зогсоосон.

Хүснэгт 6. Төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардал (2016-2018 он) (ЮНЕСКО, Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019)

№	Сургуулийн нэр	2016		2017		2018	
		Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага	Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага	Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага
1	МУИС	1,100,000.00	866,263.10	882,983.40	1,082,752.59	350,000.00	1,799,421.59
2	МУБИС	870,000.00	1,469,677.10	1,367,413.40	1,843,196.73	412,749.36	3,045,441.71
3	ХААИС	580,000.00	719,639.60	1,128,241.00	470,642.00	200,000.00	1,213,158.00
4	ШУТИС	1,375,647.90	1,204,983.40	966,363.90	1,597,833.87	400,000.00	2,639,119.06
5	Соёл урлагийн их сургууль	218,335.00	(12,856.30)	115,000.00	76,681.10	90,000.00	223,543.73
6	АШУҮИС	992,786.80	988,878.20	1,212,554.50	943,691.53	300,000.00	1,469,949.85
7	Дорнод их сургууль	112,519.70	(13,230.60)	-	67,601.92	50,000.00	109,648.65
8	Ховд их сургууль	643,404.00	731,417.00	874,797.30	490,834.84	200,000.00	940,171.61
9	Дархан-Уул ХААИС	170,093.40	(17,957.70)	-	80,099.40	25,631.80	96,371.80
10	Худалдаа үйдвэрэлтийн их сургууль			43,580.40	(11,143.58)	40,000.00	92,990.40
11	Улаанбаатарын их сургууль			67,447.10	(2,928.08)	40,000.00	11,085.70
	<b>Нийт дүн</b>	<b>6,062,786.80</b>	<b>5,936,813.80</b>	<b>6,658,381.00</b>	<b>6,639,262.31</b>	<b>2,108,381.16</b>	<b>11,640,902.08</b>

Тогтмол зардал нь их, дээд сургуулийн хувьд санхүүгийн бодитой, үр дүнтэй санхүүжилт болсон эсэх талаар судлаачид янз бүрээр байр сууриа илэрхийлдэг ч их сургуулийн зардалд тодорхой хэмжээнд дэмжлэг болж байсныг онцлон дурдаж байв (Төрийн өмчийн их сургуулиудын санхүү хариуцсан захирал, 2022). Иймээс сургалтын төлбөрийн орлогоор амьдарч буй их, дээд сургуулийн хувьд аль болох олон төрлийн хөтөлбөрөөр, аль болох олон оюутныг татах бодлого барихаас аргагүй юм.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хэд хэдэн түвшинд явагддаг гэж үздэг. Сургалтын байгууллага (оюутан, тэнхим, профессорын баг, бүрэлдэхүүн сургууль, их сургууль)-ын, үндэсний, олон улсын түвшинд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанар чансааг үнэлэх тогтолцоо бүрдсэн байдаг. Тухайлбал,

- Сургалтын байгууллагын түвшинд оюутан, суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, суралцагчийн явцын үнэлгээ, багш, ажилчдын сэтгэл ханамжийн үнэлгээгээр хэрэгждэг.
- Үндэсний түвшинд: Дэлхийн ихэнх улс орон боловсролын магадлан итгэмжлэлийн чиг үүргийн зөвлөл, байгууллагатай байдаг. АНУ-ын багш бэлтгэх сургалтын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийг нэрлэж болно (Бадарч, Дээд боловсролын чанар , 2018). Чадварлаг багш бэлтгэх зорилгоор 1954 онд байгуулагдсан энэхүү зөвлөл нь АНУ-ын их, дээд сургуулиудын багш бэлтгэдэг салбар сургууль, нэгжүүдийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилж, багш бэлтгэх чанарын өндөр түвшинг хангаж байдаг. 5 жил тутам шалгуур үзүүлэлт, стандартаа шинэчилдэг ажээ. Монгол улсын хувьд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь сургалтын байгууллага, суралцагч, дэмжигч байгууллага, төр ба олон нийт, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан боловсролын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг. Сургалтын хөтөлбөрийг үнэлж, магадлан итгэмжлэхдээ БМИҮЗ-өөс тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргадаг. Өнөөгийн байдлаар магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын хөтөлбөр 299 (БМИҮЗ, 2022) байгаагаас төрийн өмчийн 4 сургууль (МУБИС, МУИС-ийн Дорнод, Ховд салбар сургууль, МУБИС-ийн Баян-Өлгий салбар сургууль), төрийн бус өмчийн 1 сургуулийн (Дархан дээд сургууль) “Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөр байна.
- Олон улсын түвшинд магадлан итгэмжлэх шалгуур, стандартыг боловсруулан, шинжээчийн баг томилон, уг шалгуур стандартыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийх үндэсний эсвэл бүс нутгийн, төрийн, төрийн бус боловсролын агентлаг, холбоо, нийгэмлэг, зөвлөл, комисс үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь боловсролын үйлчилгээний чанарыг үнэлдэг, эрэмбэлдэг системүүд нь нэг талаас тухайн байгууллагуудын боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; сургалтын байгууллагууд өөрсдийн чанар чансааг мэдэх, харьцуулах, нөгөө талаас тодорхой чиглэлээр суралцахаар элсэгчдэд, элсэхийг хүсэгчдэд, суралцагчдад зориулан шилдэг сургууль, сургалтын хөтөлбөрийг таниулах, сурталчлах олон талын ач холбогдолтой байдаг. Тухайлбал, дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын олон улсын сүлжээг (INQAАНЕ, 2022) нэрлэж болно. 1991 онд байгуулагдсан энэхүү байгууллага нь дээд боловсролын чанарыг сайжруулах, үнэлэх чиглэлээр гарч буй онол практикийн мэдээллийг цуглуулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой бөгөөд өнөөдөр 80-аад орны 300 гишүүнтэй, 21 стратегийн түнштэй болж бэхжиж, дээд боловсролын чанарын талаар хамтын ажиллагааг дэмжлэг байгууллага болон өсжээ. Чанарын баталгаажуулалтын талаар тэргүүний сайн туршлагад үндэслэн магадлан итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлбэл зохих зөвлөмжийг агуулсан гарын авлагыг БМИҮЗ-өөс боловсруулдаг. Түүнээс гадна чанарын талаар судалгаа хийх, сургалт явуулах, чанар, соёлыг түгээх чиглэлээр үйл

ажиллагаагаа явуулдаг. Түүнчлэн 2000 онд байгуулагдсан Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын Европын холбоо (ENQA) нь чанарын баталгаажуулалтын чиглэлээр 8 төрлийн үнэлгээг хийдэг. Үүнд, хичээл, хөтөлбөр, сургалтын байгууллага, үйлчилгээний төрөл тус бүрийн үнэлгээ, аккредитац, аудит, бенчмаркинг хийдэг байна. Олон улсын магадлан итгэмжлэлийн олон улсын байгууллагаар (ASIIN, ACQUIN, ACBSP, ABET) Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагын 111 сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэний дотор “Багш, бага боловсрол” хөтөлбөр хараахан байхгүй байна. Ер нь магадлан итгэмжлэх байгууллагыг бүс нутгийн болон олон улсын сүлжээнд дэмжлэг үзүүлж, бэхжүүлэхийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон НҮБ-ийн Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас уриалдаг.

## **ХОЁР. БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭЖ БУЙ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

### **2.1. Бага боловсролын багш бэлтгэж буй үндэсний их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хийсэн судалгааны үр дүн**

*Судалгааны зорилго* нь Дээд боловсролын “Багш, бага боловсрол” (011301) сургалтын хөтөлбөр дэх БШУ-ны сайдын 2014 оны 03 –р сарын 13-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай” А/78 тоот тушаал; БШУ-ны сайдын 2022 оны 05 –р сарын 09-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай” А/160 тоот тушаал; Боловсрол шинэчлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28 -ны өдрийн “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаал; БШУ-ны сайдын А/285 тоот албан тушаал; БШУ-ны сайдын А/103 тоот албан тушаал; БШУ-ны сайдын А/162 тоот албан тушаалуудын хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийхэд оршино.

*Судалгааны үндсэн арга:* Баримт бичгийн харьцуулсан судалгаа

*Судалгааны хамрах хүрээ:* Төрийн болон төрийн бус өмчийн их дээд сургуулийн хэрэгжүүлж буй “Багш бага боловсрол” (011301) сургалтын хөтөлбөрүүд

*Судалгааг хэрэгжүүлэх үе шат:*

I шат: Судалгааны арга зүй боловсруулах

II шат: Судалгааны материал цуглуулах

III шат: Судалгааны материалаас мэдээллийг түүвэрлэх, нэгтгэх

IV шат: Судалгааны үр дүнг боловсруулах, дүн шинжилгээ хийх

#### ***Ерөнхий мэдээлэл***

Судалгаанд “Багш, бага боловсрол” мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус өмчийн 21 их дээд сургууль хамрагдсан болно. Эдгээр сургуулийн 81 хувь нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд 18.2 хувь нь шинэ хичээлийн жилд хэрэгжүүлэхээр тусгай зөвшөөрөл авсан байна. Хөтөлбөрийн судалгааг хийхдээ зарим их сургуулийн тухайлбал МУБИС-ын Архангай аймаг дахь салбар сургуулийн хөтөлбөр ижил тул судалгаанд оруулаагүй, харин Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургуулийн хөтөлбөрүүд ялгаатай тул судалгаанд хамруулан авч үзсэн. Үүнд:

1. Монгол улсын боловсролын их сургууль
2. Монгол улсын боловсролын их сургуулийн Архангай аймаг дахь салбар сургууль
3. Монгол улсын боловсролын их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль
4. Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль
5. Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль
6. Монголын үндэсний их сургууль
7. Глобал удирдагч их сургууль
8. Идэр их сургууль
9. Их засаг олон улсын их сургууль
10. Орхон их сургууль
11. Рояль олон улсын их сургууль

12. Сити их сургууль
13. Улаанбаатар Эрдэм их сургууль
14. Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль
15. Гурван-эрдэнэ дээд сургууль
16. Дархан дээд сургууль
17. Засагт Хан дээд сургууль
18. Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль
19. Тэнгэр дээд сургууль
20. Хангай дээд сургууль
21. Этүгэн их сургууль
22. Эдийн засгийн үндэсний дээд сургууль

### **1. ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ:**

Боловсрол шинэчлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28 -ны өдрийн “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаалаар дээд боловсролын сургалтын хөтөлбөр нь дараах бүтэцтэй байна.

- Хөтөлбөрийн танилцуулга
- Сургалтын төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөр
- Сургалтын арга зүй
- Суралцах орчин
- Элсэгчдэд тавих шаардлага
- Багшид тавих шаардлага
- Төгсөгчдийн эзэмших ур чадвар
- Суралцагчийн үнэлгээ
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт
- Удирдлагын мэдээлэлийн систем
- Харилцаа хамтын ажиллагаа

#### **Монгол улсын боловсролын их сургууль**

Нийт 11 бүлэг 27 дэд бүлгээс бүрдэж байна. Хөтөлбөрийн танилцуулга бүлэгт эрх зүйн зохицуулалт дэд бүлгийг орхигдуулсан харин сургалт явуулж ирсэн түүх, туршлага дэд бүлгийг шинээр оруулж бичсэн байна. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтууд, хөтөлбөрийн үр дүн гэсэн 2 бүлэг 7 дэд бүлэг Сургалтын төлөвлөгөө бүлэгт хичээлийн хөтөлбөрүүдийг багтааж өгсөн онцлогтой байна.

Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль

Нийт 12 бүлэг 18 дэд бүлгээс бүрдэж байна. Бүтцийн хувьд “бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль

Нийт 12 бүлэг 18 дэд бүлгээс бүрдэж байна. Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Монголын үндэсний их сургууль**

Нийт 12 бүлэг 37 дэд бүлгээс бүрдэж байна. “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Орхон их сургууль**

Нийт 12 бүлгээс бүрдэж байна. Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Улаанбаатар эрдэм их сургууль**

Нийт 2 бүлэгтэй Сургалтын төлөвлөгөө, Хичээлийн хөтөлбөрүүд гэсэн 2 бүлгээс бүрдэж байна.

#### **Рояль олон улсын их сургууль**

Нийт 1 бүлэгтэй Сургалтын төлөвлөгөө гэсэн 1 бүлгээс бүрдэж байна.

#### **Этүгэн их сургууль**

Нийт 9 бүлэг 31 дэд бүлгээс бүрдэж байна. Хөтөлбөрийн танилцуулга хэсэгт Хөтөлбөрийг боловсруулах үндэслэлийг орхигдуулсан Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Гурван-эрдэнэ дээд сургууль**

Нийт 12 бүлэг 9 дэд бүлэгтэй. “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Засагт хан дээд сургууль**

Нийт 12 бүлэг 11 дэд бүлгээс бүрдэж байна. Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Дархан дээд сургууль**

Нийт 12 бүлэг 9 дэд бүлгээс бүрдэж байна. Хөтөлбөрийн танилцуулга бүлэгт хөтөлбөрийн зориулалт дэд бүлгийг шинээр нэмсэн. Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль**

Нийт 12 бүлэг 10 дэд бүлгээс бүрдэж байна.

Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Хангай дээд сургууль**

Нийт 12 бүлэг 7 дэд бүлэгтэй. Хөтөлбөрийн танилцуулга бүлэгт хөтөлбөрийг хариуцах нэгж, захирал, харилцах хаяг дэд бүлгийг орхигдуулсан Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### **Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль**

Нийт 12 бүлэг 31 дэд бүлгээс бүрдэж байна. Хөтөлбөрийн танилцуулга хэсэгт Хөтөлбөрийг боловсруулах үндэслэлийг орхигдуулсан Бүтцийн хувьд “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан байна.

#### ***Хөтөлбөрийн нэр болон индекс***

Сургалтын хөтөлбөр дэх мэргэжлийн нэрийг “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл хөтөлбөр” (А/78)-т тусгаснаар нэрлээгүй байна. Тухайлбал, “Бага боловсролын багш/Хангай дээд сургууль/, зэрэг олон янзаар бичсэн байна.


#### ***Сургалтын хөтөлбөрийн эрх зүйн зохицуулалт***

Судалгаанд хамрагдсан их дээд сургуулиуд нийт 37 төрлийн баримт бичгийг сургалтын хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл болгон авч үзсэн байна. Эдгээр баримт бичгийг ашиглаж буй нийт сургуулийн эзлэх хувийг тооцож үзвэл дараах 8 төрлийн баримт бичгийг илүү олон сургуулиуд хэрэглэсэн байна. Тухайлбал,

- Боловсрол соёл шинжлэх ухааны Сайдын 2014 оны А/174 тоот тушаалыг -24.3 хувь

- Боловсрол соёл шинжлэх ухааны Сайдын 2014 оны А/78 тоот тушаал -19 хувь
- Боловсролын тухай монгол улсын хууль-16.2 хувь
- Дээд боловсролын тухай хууль-13.2 хувь
- Сургуулийн бакалаврын сургалтын журам-13.2 хувь
- Бага дунд боловсролын тухай хууль-10.8 хувь
- Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2014 оны А/136 тоот тушаал -10.8 хувь
- Бусад 29 дүрэм журмууд тус бүр - 2.7 хувь

Зураг 10. Их дээд сургуулийн хөтөлбөр боловсруулахад ашиглаж буй баримт бичгийн ашиглалтын давтамж



## **Хөтөлбөрийн тодорхойлолт**

Сургалтын хөтөлбөрийг хэд хэдэн янзаар тодорхойлсон байна. Тухайлбал,

- *Баримт бичиг хэмээн тодорхойлсон* (Засагт хан дээд сургууль, Дархан дээд сургууль, Зохиомж дээд сургууль зэрэг сургуулиуд сургалтын хөтөлбөрийг сургалт явуулах цогц баримт бичиг хэмээн тодорхойлсон байна.
- *Суралцагчийг зохих шатны мэдлэг,чадвар эзэмшүүлэх, сурах арга барил эзэмшүүлэхэд чиглэнэ хэмээн зорилго байдлаар томъёолсон байна* (Дорнод их сургууль, Хангай дээд сургууль)
- *Үйл ажиллагааг хөтлөн явуулах удирдамж хэмээн тодорхойлсон*
- *Сургалтын хөтөлбөрт ерөнхий суурь чиглэлийн, мэргэжлийн суурь чиглэлийн, мэргэжлийн хичээлийн тодорхойлолтуудыг бичсэн байна*
- *Боловсролын их сургууль сургалтын хөтөлбөртөө хичээлийн тодорхойлолт хэсгийг тусгаагүй байна.*

Цаашид сургалтын хөтөлбөрийн тодорхойлолтыг хөтөлбөрийн үндэслэл, зорилго зорилт хүрэх үр дүнг уялдуулан тодорхойлох шаардлагатай байна.

## **Хөтөлбөрийн үндэслэл**

Хөтөлбөрийн үндэслэлийг дараах хэд хэдэн байдлаар томъёолсон байна. Бага боловсролын цөм хөтөлбөрт тусгасан судлагдахуунуудыг стандарт, хөтөлбөрийн дагуу багш боловсон хүчин бэлтгэх шаардлагатай гэж үзсэн.

*Монгол улсын Ерөнхий боловсролын “Бага боловсролын цөм хөтөлбөрт тусгасан судлагдахуунуудыг стандарт, хөтөлбөрийн дагуу үр өгөөжтэй, чанартай удирдан явуулдаг орчин үеийн боловсролын агуулга, арга зүйн талаар гүн гүнзгий мэдлэг, чадвар хандлагатай багш боловсон хүчин хэрэгтэй байгаа нь хөтөлбөрийн гол үндэслэл болно.*

*Сургалтын агуулгыг ардчилсан нийгмийн иргэн төлөвшүүлэх, хувь хүний сонирхол, эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн, уян хатан, нэгдмэл бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай болгох, хүүхдэд насанд хүрэгчдийн туслалцаа дэмжлэгт тавих шаардлагыг хангах,хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж хамгаалал, хоол тэжээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зэрэг эрэлт хэрэгцээний дагуу боловсруулсан юм.*

Сургуулийн зорилтод үндэслэсэн

*Зүүн бүсийн инновацийн төв, нээлттэй их сургууль болж, эдийн засаг, хүрээлэн буй орчны хамгаалал, нийгмийн тогтвортой хөгжлийн талаарх НҮБ-ын үзэл баримтлал болон багш боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар бүхий төлөвшсөн, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдэнэ*

Сургуулиуд нийт 12 төрлийн баримт бичгийг ашигласан байна. Үүнд:

- Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- Үндэсний хөгжлийн цогц бодлого
- Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)
- Зөв монгол хүүхэд-үндэсний хөтөлбөр
- Боловсрол соёл шинжлэх ухааны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал
- "ЕБС-ын багш"дээд боловсролын стандарт MNS5323-95:2009

- Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр
- “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэл ” дэд хөтөлбөр
- Стратеги төлөвлөгөө
- МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
- Тогтвортой хөгжил-дээд боловсрол улсын II зөвлөгөөн
- Шинэ зууны Монгол багшийн загвар

### ***Хөтөлбөрийн зорилго, зорилт***

Их дээд сургуулиуд хөтөлбөрийн зорилго зорилтыг тухайн сургуулийн эрхэм зорилго зорилт боловсролын зорилго зорилттой уялдуулан тодорхойлохоос гадна тухайн мэргэжлийн онцлогтой уялдуулан тодорхойлсон байна. Тухайлбал,

- Дээд боловсролын орчинд сургалтын байгууллагын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангаж, сургалт олон хувилбартай байх нөхцөлийг бүрдүүлэхэд
- Хүүхдийг зөв зохистой хооллох, өсөлт хөгжлийг хянах, өсч хөгжих, амьдрах эрүүл орчин бүрдүүлэх үйл ажиллагааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн явуулах, эрүүл аж төрөх ёсны талаар мэдлэг, чадвартай болох
- Мэргэжилтэн бэлтгэх
- Багш мэргэжилтнийг
- Шилдэг багш бэлтгэх
- Мэдлэг, чадвар, зөв дадалтай, хариуцлагатай, ёс зүйтэй, багш бэлтгэнэ гэх мэтээр тодорхойлсон байна.

### ***Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн***

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг сургууль бүр өөрийн онцлогтойгоор тодорхойлсон байна. Дараах чиглэлүүдийг тусгажээ.

1. Сургалтын агуулга : Бага боловсролын багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын арга агуулга нэгдсэн бодлогын хүрээнд шинэчлэгдэж боловсронгуй болно.
2. Багш нарын мэргэжил, заах арга зүй : Бага боловсролын багш бэлтгэдэг сургуулиудын багш нарын мэргэжил, заах арга зүй ур чадвар дээшилнэ.
3. Багш нарын хандлага, сургалтын арга барил : Бага боловсролын багш нарын боловсролын шинэчлэлд хандах хандлага, сургалтын арга барил сайжирна.
4. Төгсөгчдийн эзэмших цогц чадамж: Бага боловсролын багш бэлтгэдэг сургуулиудын төгсөгчдийн эзэмших цогц чадамжийн түвшин дээшилнэ.
5. Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлага:
  - Багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшил
  - Хувь хүний суурь мэдлэг чадвар
  - Багш боловсролын мэдлэг чадвар
  - Бага боловсролын багшийн мэдлэг, чадвар
  - Мэргэжлийн мэдлэг, сэтгэлгээ
  - Хувь хүний болон ур чадвар, хандлага
  - Хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар
  - Салбар болон нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар
6. Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг хөтөлбөрийн зорилгод тусгахын хамт төгсөгч гэж хэн байх тухай тодорхойлон бичсэн байна.

"Бага боловсролын багш" мэргэжлээр төгсөгч нь тухайн боловсролын онцлогийг харгалзан сургалтын ажлыг оновчтой төлөвлөх, зохион байгуулах, улмаар бие хүний төлөвшил, бүтээлчээр сонгож хэрэглэх, суралцагчдад боловсролын стандартын шаардлагад тохирсон, мэдлэг, чадвар эзэмшүүлэх, холбогдох хууль тогтоомжид тусгагдсан суралцагчдын эрхийг хангах, тэдний эрүүл мэндийг хамгаалах, авьяас билгийг хөгжүүлэх, эцэг эх, төр олон нийттэй хамтран ажиллах, өөрийн мэргэжил боловсролоо тасралтгүй дээшлүүлэх бэлтгэлтэй байна.

Түүнчлэн МУБИС, Этүгэн их сургууль, МҮИС зэрэг сургуулиуд хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлага болон хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хоорондын уялдаа, холбоог гаргаж матриц хийсэн давуу талтай байна. Цаашид их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн ерөнхий зорилго, зорилт хүрэх үр дүнг хоорондоо уялдаа холбоотойгоор томъёолох шаардлагатай байна.

**2. СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сургуулиудын сургалтын хөтөлбөр нь 2014 -2021 оны хооронд боловсруулдсан байна. Сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлүүдийг багц цагийн хэмжээ болон тэдгээрийн эзлэх хувиар тооцож ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн чиглэл тус бүрээр гаргав.

**Ерөнхий суурь хичээл**

Зураг 11. Ерөнхий суурь хичээлийн багц цагийн эзлэх хувь




Тайлбар : 1 -МУБИС, 2-Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, 3-Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, 4-Улаанбаатар-Эрдэм их сургууль,5-Этүгэн их сургууль,6-Орхон их сургууль,7-МҮИС,8-Дархан дээд сургууль,9-Гурван-Эрдэнэ дээд сургууль,10-Засагт Хан дээд сургууль,11-Хангай дээд сургууль,12-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль,13-Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль,14-Идэр их сургууль

Ерөнхий суурь чиглэлийн багц цагийн хэмжээ нийт багц цагт эзлэх хувь нь БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын 2.2 сургалтын төлөвлөгөө хэсгийн 2.2.1 заалтад нийцэж байна.

**Мэргэжлийн суурь хичээл**

Зураг 12. Мэргэжлийн суурь хичээлийн багц цагийн эзлэх хувь



Тайлбар : 1 -МУБИС, 2-Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, 3-Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, 4-Улаанбаатар-Эрдэм их сургууль,5-Этүгэн их сургууль,6-Орхон их сургууль,7-МҮИС,8-Дархан дээд сургууль,9-Гурван-Эрдэнэ дээд сургууль,10-Засагт Хан дээд сургууль,11-Хангай дээд сургууль,12-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль,13-Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль,14-Идэр их сургууль

### Мэргэжлийн хичээл


Зураг 13. Мэргэжлийн хичээлийн багц цагийн эзлэх хувь



Тайлбар : 1 -МУБИС, 2-Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, 3-Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, 4-Улаанбаатар-Эрдэм их сургууль,5-Этүгэн их сургууль,6-Орхон их сургууль,7-МҮИС,8-Дархан дээд сургууль,9-Гурван-Эрдэнэ дээд сургууль,10-Засагт Хан дээд сургууль,11-Хангай дээд сургууль,12-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль,13-Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль,14-Идэр их сургууль

### Нийт багц цагийн хэмжээ

Зураг 14. Нийт багц цагийн харьцуулалт



Тайлбар : 1 -МУБИС, 2-Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, 3-Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, 4-Улаанбаатар-Эрдэм их сургууль,5-Этүгэн их сургууль,6-Орхон их сургууль,7-МҮИС,8-Дархан дээд сургууль,9-Гурван-Эрдэнэ дээд сургууль,10-Засагт Хан дээд сургууль,11-Хангай дээд сургууль,12-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль,13-Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль,14-Идэр их сургууль

Судалгаанд хамрагдсан их дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөний нийт багц цаг нь БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын 2.2 заалтад

нийцэж байна. Их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд: Төрөлжсөн чиглэл, Нарийвчилсан чиглэл, Хөтөлбөрийн нэр, Боловсролын зэрэг, Мэргэжлийн индекс, Суралцах хугацаа, Элсэгчдийн боловсрол, Суралцах хэлбэр зэргийг нийтлэг тусгасан байна.

1. Сургалтын төлөвлөгөө хэсэгт заавал судлах цаг, мэргэшүүлэх хичээл гэх мэт нэршлийн хувьд зөрүүтэй бичсэн байна.
2. Заавал судлах болон сонгон судлах хичээлийн ангилал хийгдээгүй ерөнхийлөн байна.
3. БСШУ-ны Сайдын А/285 тоот тушаалын хавсралтад заасан заавал судлах хичээлийн жагсаалтад тусгасан 4 хичээлийг бүрэн тусгаагүй зарим хичээлийг орхигдуулсан, сонгон судлах хичээлийн жагсаалтад оруулсан байна.
4. Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт (А/285) ёсоор “Монгол хэл бичиг, найруулга зүй” хичээлийг дараах байдлаар сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна бөгөөд 10 янзаар нэрлэсэн байна. Тухайлбал, Монгол хэл бичиг найруулга зүй, Монгол хэлний найруулга зүй, Монгол бичиг найруулга зүй, Найруулга зүй (монгол хэл), Монгол хэл-1, Монгол хэл-2, Монгол хэл-3, Монгол хэл-4, Монгол хэл бичиг ярианы чадвар найруулга зүй, Яриа бичгийн ур чадвар гэх мэт.

Цаашид БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага а/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт А/285 тоот тушаалуудын хүрээнд сайжруулан боловсруулах шаардлагатай.

Их дээд сургуулиуд сургалтын төлөвлөгөөндөө тодорхой өөрчлөлтүүдийг хийн сайжруулсаар байдаг. Бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн бус өмчийн их, дээд сургуулийн тоо олон боловч нийт төгсөгчдийн 28.7 хувийг эзэлж байна. Төрийн өмчийн их дээд сургуулиудыг төгсөгчдийн эзлэх хувь өндөр 71.2 хувь байна. Эдгээр төгсөгчдийн 61.4 хувийг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн (салбар сургуулийн хамт) төгсөгчид эзэлж байна. Ийм учраас бид МУБИС-ын Багшийн сургуулийн бага ангийн багш бэлтгэх сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтийг авч үзлээ.

Багшийн сургуулийн багш бэлтгэж ирсэн 2000, 2003, 2007, 2008, 2011, 2014, 2018, 2021 оны сургалтын төлөвлөгөөний харьцуулалт

Хүснэгт 7. Ерөнхий суурь хичээлийн заавал судлах хичээлийн харьцуулалт

Хичээлүүд	2000	2003	2007	2008	2011-2013	2014-2017	2018-2020	2021-2022
Нийт багц цаг	20	20	13	13	12	20	21	21

2000-2003 оны хооронд судлах хичээлүүдийн харьцаа ижил нийт 8 төрлийн хичээлийг 20 кредит цаг судлахаар төлөвлөж байсан бол 2007-2013 оны хооронд 12-13 кредит цагийг, 2014-2020 онд нийт 11 төрлийн хичээлийг 21 кредит заавал судлахаар тусгасан байна. Энэхүү хэсэгт сэтгэлгээний түүх соёл, бүтээлч сэтгэлгээ, гамшгийн менежмент, монгол хэл бичиг, найруулга зүй, Байгалийн ухаан гэсэн хичээлүүд шинээр нэмэгдэж судлах болсон байна.

Хүснэгт 8. Ерөнхий суурь хичээлийн сонгон судлах хичээл

Хичээлүүд	2003	2007	2008	2011-2013	2014-2017	2018-2020	2021-2022
-----------	------	------	------	-----------	-----------	-----------	-----------

Хүмүүнлэгийн ухаан	6	6	6				
Нийгмийн ухаан	6	3	6				
Байгалийн ухаан					2		
Нийт багц цаг	12	9	12	10	4	4	4

Ерөнхий суурийн сонгон судлах хичээл нь хамгийн чухал бөгөөд сонирхлоороо тухайн хичээлийг дурын улиралд сонгож өөрийн сурах үйлийг төлөвлөдөг онцлогтой. Үүнд:

- 2000 онд сонгон судлах хичээл байхгүй зөвхөн заавал судлах хичээлээр ерөнхий суурийн мэдлэг, чадварыг олгож байсан бол 2003- 2008 оны үед хичээлийн төрөл, кредит цагийн хувьд цөөн тоогоор хязгаарлагдмал байсан байна. Тухайлбал, хүмүүнлэгийн ухаан I, II – тус бүр 3 кредит цаг нийт 6 кредит цаг, нийгмийн ухаан I, II хичээлийг тус бүр 3 кредит цаг нийт 6 кредит цаг судлах бөгөөд тухайн хичээлийн жилд 12 кредит заавал сонгох;
- 2011-2013 онд сонгон судлах хичээлийн тоо 8 болж “Орос хэл”, “Философи”, “Хүний хөгжил”, “Эдийн засаг”, “Улс төр”, “Түүх, Даяаршил ба соёл” гэх зэрэг хичээлүүд нэмэгдэж нийт 10 кредит сонгон судлахаар төлөвлөсөн бол 2014-2021 оны хичээлийн жилд сонгон судлах хичээл багц байдлаар боловсруулагдаж 4 кредит цагийг судлахаар тусгаж өгсөн байна.

*Хүснэгт 9. Мэргэжлийн суурь хичээлийн заавал судлах хичээл*

Хичээлүүд	2000	2007	2008	2011-2013	2014-2017
Нийт	90кр	69 кр	15 кр	15 кр	14 р

- 2000-2017 оны хооронд мэргэжлийн суурь гэсэн бүтцийн хүрээнд “Сэтгэл судлал”, “Сурган хүмүүжүүлэх арга зүй”, “Судлагдахууны заах арга зүй” зэрэг хичээлүүдийг, 2008-2013 оны үед Мэргэжлийн удиртгал, Хүүхдийн сэтгэл судлал, Сурган хүмүүжүүлэх арга зүй, тусгай хэрэгцээт боловсрол гэсэн мэргэжлийн суурь хичээлүүдийг заавал судлахаар оруулсан байна.
- 2014-2017 онд сургалтын төлөвлөгөөний бүтэц 4 бүрдэл (Ерөнхий суурь, Багш боловсролын суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл) хэсэгтэй байсан. Энэ үед “Эх хэл” “Математик”-ийн хичээлүүдийг мэргэжлийн суурь хэмээн үзэж нийт 14 кредит цаг судлахаар оруулсан байна.
- 2018 онд сургалтын төлөвлөгөөний үндсэн бүтэц нь 3 болж (Ерөнхий суурь, Багш боловсролын суурь, Мэргэжлийн хичээл) өөрчлөлт орсон байна.
- 2000 онд мэргэжлийн суурь хичээлд 90 кредит судалдаг байсан бол 2014 онд энэ нь 14 кредит цаг болж эрс өөрчлөлт орж байсан байна. Энэ нь цаг үе, нийгмийн эрэлт хэрэгцээ оюутан төвтэй хандлага, сурах үйл ажиллагааг өөрөө төлөвлөх гэсэн олон улсын чиг хандлага, онол, үзэл баримтлал зэрэгт тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй өөрчлөлт шинэчлэлийг хийсэнтэй шууд холбоотой юм.

*Хүснэгт 10. Багш боловсролын суурь хичээл харьцуулалт*

Хичээлүүд	2014-2017	2018-2020	2021	Хичээлүүд	2014 - 2017	2018-2020	2021
Заавал судлах хичээл			Сонгон судлах хичээл				
Нийт кредит	24 кр	16 кр	14 кр	Нийт кредит	2 кр	2 кр	2

- Багш боловсролын суурь хичээлийн агуулгад “Багш мэргэжлийн удиртгал”, “Сэтгэл судлал” “Боловсрол судлал”-ын хичээлүүдийг суурь болгон төлөвлөсөн байна.
- 2014 онд анх 24 кредит цагаар судалдаг байсан бол 2021 онд 14 кредит болгож өөрчлөлт оруулжээ. “Хүний хөгжлийн сэтгэл судлал” хичээлийн оронд “Сэтгэл судлал хичээл”, “Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл судлал”, “Нэгдмэл арга зүй” зэрэг хичээлүүдийг мэргэжлийн хичээл рүү шилжүүлсэн байна. Ингэснээр кредитийн харьцаа 2018 онд 16 кр, 2021 онд 14 кр болгож өөрчлөлт оруулсан байна.
- Сонгон судлах хичээлд нийт 9 хичээлийг тусгасан ба оюутан дурын улиралд тухайн санал болгосон хичээлүүдээс 4 кредит цаг сонгон судлах, 2018 онд 2 кредит цаг сонгон судлахаар өөрчилсөн байна.

*Хүснэгт 11. Мэргэжлийн заавал судлах хичээл*

Хичээлүүд	2003	2008	2011-2013	2014-2017	2018-2020	2021-2022
Нийт багц цаг	15	67	74	44	76	78

- 2007 онд мэргэжлийн хичээл нийт 15 кредит, 2011 онд 74 кредит, 2014 оны шинэчилсэн хөтөлбөрөөр 44 кредит болж өөрчлөлт орсон.
- Сургалтын төлөвлөгөөнд “Мэргэших хичээлийн удиртгал”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, арга зүй”, “Эрүүл мэнд арга зүй” “Мэргэжлийн судалгааны арга зүй” хичээл гэсэн хичээлүүд нэмэгджээ.

*Хүснэгт 12. Мэргэшүүлэх хичээлийн сонгон судлах хичээл*

Хичээлүүд	2000	2003	2007	2008	2011-2013	2014-2017	2018-2020	2021-2022
Нийт багц цаг	14	22	21	15	14	8	4	4

- 2000-2013 оны хичээлийн жилд мэргэшүүлэх чиглэлийн сонгон судлах хичээл нь 14-22 кредит, 2014 оноос 4 кредит болсон байна.
- 2011 оны төлөвлөгөөнд Технологи дидактик, Дүрслэх урлаг дидактик, Дуу хөгжим дидактик, Биеийн тамир дидактик хичээлүүд заавал судлахаар тусгагдаж байсан бол 2018, 2021 оны шинэчилсэн төлөвлөгөөнд мэргэжлийн заавал судлах хэсэгт төлөвлөсөн байна.

*Хүснэгт 13. Багшлах дадлагын харьцуулалт (2011-2021)*

№	Дадлагын төрөл	2000	2003	2007	2008	2011	2014-2017	2018-2020	2021-2022
1	Ангийн ажил	2 кр	2 кр	2 кр	1 кр	1 кр			
2	Танилцах дадлага	1 кр					1 кр	1 кр	1 кр
3	Судлах дадлага 1						1 кр		
4	Судлах дадлага 2	6 кр					2 кр	2 кр	2 кр
5	Дагалдан суралцах дадлага						3 кр		
6	Туршин заах дадлага		8 кр	8 кр	6 кр	6 кр	3 кр	5 кр	5 кр
7	Багшлах дадлага	7 кр	6 кр	6 кр	6 кр	6 кр	4 кр	5 кр	5 кр
	Нийт багц цаг	14 кр	14кр	14кр	13кр	13 кр	14 кр	13 кр	13

- 2000-2011 оны төлөвлөгөөнд дадлага III курсийн хаврын улирал 6 долоо хоног буюу 6-8 кредит, IV курсийн намрын улиралд 6 долоо хоног буюу 6-7 кредит судлахаар тусгажээ.
- 2000-2011 онд оюутан бүр ангийн ажил бичиж хамгаалдаг байсан бол 2014 онд дадлагын нэр төрөлд өөрчлөлт орж оюутан бүх улиралд дадлага хийхээр тусгасан байна. Нийт 6 удаа буюу 14 кредит, нийт сургалтын кредитийн 11,4хувь, 2018 онд дадлагын нэр төрөлд өөрчлөлт орж 4 удаагийн дадлага буюу 10,3 хувийг эзэлж байна.
- Дадлагын хугацаанд дадлагын удирдамжид заасан ёсоор бага сургуулийн сургалтын төлөвлөгөөний дагуу “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийн шаардлагад нийцсэн арга зүйгээр зохион байгуулж, хүүхдийн нас, бие, оюун ухаан, сэтгэхүйн хөгжлийн онцлог, хэрэгцээ, сонирхол, өмнөх мэдлэгийг бүх талаар судлан оношилж, тодорхойлох, авьяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх, сургалтыг дэмжих үйл ажиллагааг хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихүйц төрөл бүрийн арга, хэлбэрээр зохион байгуулж, багшлах арга туршлагад суралцахын зэрэгцээ өөртөө сурган хүмүүжүүлэх үзэл бодол, чиг хандлага, арга барил, туршлага чадвар төлөвшүүлэх гэсэн зорилгуудын хүрээнд дадлага хийж гүйцэтгэж байна.

*Хүснэгт 14. Сургалтын төлөвлөгөөний нийт кредитийн харьцуулалт (2000-2021 он)*

№	Бүтэц	2000	хувь	2003	хувь	2007	хувь	2008	Хувь	2011	Хувь	2014	Хувь	2018	Хувь	2021	Хувь
1	Ерөнхий суурь	20	14.7%	20	15.3%	22	16.1%	13	9.7%	13	9.4%	19	15.4%	21 кр	16.6%	21 кр	16.6%
2	Ерөнхий суурийн сонгон							12	8.9%	12	8.7%	4	3.3%	4 кр	3.1%	4 кр	3.1%
3	Багш боловсролын суурь											23	18.5%	16 кр	12.6%	12 кр	9.5%
4	Сонгон судлах хичээл											2	1.6%	2 кр	1.5%	2 кр	1.5%
5	Мэргэжлийн суурь	90	66.1%	59	43.3%	58	42.6%	17	12.6%	17	12.4%	14	11.3%				
6	Сонгон судлах хичээл											4	3.3%				
7	Мэргэжлийн хичээл			15	11.5%	15	11.5%	67	50%	74	54.01%	36	29.1%	76 кр	60.3%	78 кр	61.9%
8	Сонгон судлах хичээл	12	9%	22	16.9%	21	16.1%	15	11.1%	8	5.8%	8	6.5%	4 кр	3.1%	4 кр	3.1%
9	Багшлах дадлага	14	10.2%	14	10.2%	14	10.7%	13	9.7%	13	9.4%	14	11.2%	13 кр	10.3%	13 кр	10.3%
	<b>Нийт</b>	<b>136</b>	<b>100%</b>	<b>130</b>	<b>100%</b>	<b>130</b>	<b>100%</b>	<b>134</b>	<b>100%</b>	<b>137</b>	<b>100%</b>	<b>124</b>	<b>100%</b>	<b>126</b>	<b>100%</b>	<b>126</b>	<b>100%</b>

- 2000 онд сургалтын төлөвлөгөөний бүтэц ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон сонгон судлах гэсэн бүтэцтэй байжээ.
- 2003-2007 оны хооронд мэргэжлийн хичээл, 2008-2011 онд ерөнхий суурийн сонгон гэсэн хэсэг нэмгдсэн байна.
- 2014 онд ерөнхий суурь хичээл, сонгон судлах, Багш боловсролын суурь хичээл сонгон судлах, Мэргэжлийн суурь, сонгон судлах, мэргэжлийн хичээл, сонгон судлах гэсэн 4 үндсэн бүтэцтэй байсан бол 2018 оноос өнөөдрийг хүртэл мэргэжлийн суурь, сонгон судлах хэсэгтэй хасагдаж 3 бүтэцтэйгээр сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө 2014 оноос өмнө 134-137 кредит цагийн багтаамжаар судалдаг байсан бол 2014-2021 оны үед 124-126 кредитийн багтаамжтай сургалтын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна.

- Дэлхийн зарим улс оронд Бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөөнд онцгойлон анхаарч судлах кредит бусад мэргэжлийн бакалаврын сургалтад 134-141 кредитийн хооронд судалдаг туршлага байна.

### 3. ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

#### *Их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн тоо*

Их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлийн тоог харьцуулж үзэхэд нийт хичээлийн тоо 30-122 төрөл байна. Үүнийг чиглэл тус бүрээр задалж үзвэл: Ерөнхий суурь чиглэлд 12-32 хичээл, мэргэжлийн суурь чиглэлд 9-39 хичээл, мэргэжлийн чиглэлд 11-62 төрлийн хичээлтэй байна (Хүснэгт 15).

*Хүснэгт 15. Их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлийн тоо*

Сургууль		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Ерөнхий суурь хичээлийн тоо	Нийт	24	14	22	20	12	13	24	21	17	16	19	10	20
	Заавал судлах	10	10	10	12	0	5	14	15	10	13	6	0	18
	Сонгон судлах	14	4	12	8	0	8	8	6	7	3	13	0	2
мэргэжлийн суурь хичээлийн тоо	Нийт	22	17	28	18	8	12	13	19	26	12	15	9	12
	Заавал судлах	17	15	12	13	0	8	5	14	13	9	12	0	10
	Сонгон судлах	5	2	16	5	0	4	8	5	13	3	3	0	2
Мэргэжлийн хичээлийн тоо	Нийт	45	17	35	27	14	18	32	35	19	21	24	11	18
	Заавал судлах	24	15	19	21	0	13	20	26	12	18	20	0	15
	Сонгон судлах	21	2	16	6	0	5	12	9	7	3	4	0	3
Нийт хичээлийн тоо		91	48	85	65	34	43	69	75	62	49	58	30	49

Тайлбар: 1 -МУБИС, 2-Монгол улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, 3-Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, 4-Улаанбаатар-Эрдэм их сургууль,5-Этүгэн их сургууль,6-Орхон их сургууль,7-МУИС,8-Дархан дээд сургууль,9-Гурван-Эрдэнэ дээд сургууль,10-Засагт Хан дээд сургууль,11-Хангай дээд сургууль,12-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль,13-Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль

#### *Хичээлийн хөтөлбөрийн бүтэц*

Хичээлийн хөтөлбөрийн бүтцийг сургууль бүр харилцан адилгүй байдлаар боловсруулсан байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал, дараах 2 сургуулийн хичээлийн хөтөлбөрийн бүтцээс харж болно (Хүснэгт 16).

*Хүснэгт 16. Хичээлийн хөтөлбөрийн бүтэцийн жишээ*

МУБИС	МУИС
Хичээлийн танилцуулга	Салбарын нэр
Улирал	Хичээлийн индекс
Хичээлийн задаргаа	Хичээлийн нэр
Ажиллах цаг	Кредит
Заах багш	Улирал
Үндсэн сурах бичиг	7 хоногт орох цаг
Нэмэлт унших ном, зохиолууд	Хичээл заах багш
Хичээлийн өмнөх холбоо	Судлах цаг
Хичээлийн товч тодорхойлолт	Судлах анги
✓ Агуулга	Хичээлийн өмнөх холбоо

✓ Аргазүй	хичээлийн тодорхойлолт
✓ Үнэлгээ	хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага
Хичээлийн зорилго	хичээлийн зорилго
<b>Хичээлийн стандарт</b>	хичээлийн зорилтууд
Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага	хичээлээр оюутанд олгох мэдлэг, чадвар, дадал
Хичээлийн агуулга ба хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын хамаарал	хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт, ерөнхий агуулга
Үнэлгээний хэлбэр, жин, багтаамж	семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө
<b>Хичээлийн жишиг төлөвлөгөө</b>	хичээлийн хүрээнд оюутны 4 талт хөгжлийг ханган хэрэгжүүлэх ажлын хүрээнд
	лекц, семинарын агуулга
	хичээлийн бие даалтын агуулга
	хичээлийн заах арга зүй
	хичээлийн үнэлгээ
	хичээлийн хэрэглэгдэхүүн

- Их дээд сургуулиудын ерөнхий суурь хичээлийн чиглэлд үзэх хичээлийн тоо харилцан адилгүй байна.
- Их дээд сургуулийн заавал судлах хичээлийн тоо мэргэжлийн суурь болон мэргэжлийн чиглэлд тооны хувьд олширсон харин сонгон судлах хичээлийн тоо цөөрсөн зүй тогтолтой байна.
- Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт (А/285) -д тусгасан хичээлүүд сургалтын төлөвлөгөөний сонгон судлах хэсэгт төлөвлөгдсөн байна.
- Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт харилцан адилгүй байна.
- Нэг агуулга бүхий хичээлүүд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд олон янзаар нэрлэгдсэн байх магадлал маш өндөр байна.

Ерөнхий бүтцийн хувьд БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад зарим хэсэг нь нийцэж байгаа боловч хичээлийн хөтөлбөрийг цаашид сайжруулан боловсруулах шаардлагатай.

#### 4. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын арга зүйн талаар БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын 2.4.1-т суралцах үйл ажиллагаа нь оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах төсөлд суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулсан байна гэсэн заалтын хүрээнд их дээд сургуулиуд сургалтад ашигладаг арга зүйгээ дэлгэрэнгүй тайлбарлан тусгасан байна.

Хүснэгт 17. Их дээд сургуулиудын ашигладаг сургалтын аргууд

д/д	Сургалтын арга	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Үзүүлэн таниулах аргууд			1		1		1					
2	Оюуны дайралт \долголгоо\ хийх арга			1				1					
3	Эвлүүлгийн арга			1		1		1					
4	Сурагчдыг багаар хамтран ажиллуулах арга			1		1		1					
5	Дүрд тоглох арга			1		1		1					

6	Бод-асуу- хуваалц		1			1				
7	Лекц			1	1	1				1
8	Семинар				1					1
9	Асуудалд суурилсан сургалт	1		1	1	1				
10	Сорилтод суурилсан сургалт			1		1				
11	Даалгаварт суурилсан сургалт					1				
12	Тохиолдолд суурилсан сургалт					1				
13	Туршилтанд суурилсан сургалт					1				
14	Тоглоом ба симуляци			1	1	1				
15	Төсөлд суурилсан сургалт			1		1				
16	Зориулагдсан орчинд суурилсан сургалт					1				
17	Чадамжинд суурилсан сургалт					1				
18	Багт суурилсан сургалт				1	1				
19	Хамтын ажиллагаатай багийн сургалт					1				
20	Туршлагад суурилсан сургалт			1						
21	Орчинд суурилсан сургалт			1						
22	Жишээнд суурилсан сургалт			1						
23	Хүүхдийн танин мэдэх үйл ажиллагааг хөгжүүлэх когнитив арга			1						
24	Хүүхдийг бүтээлчээр сэтгэх өөрөө хийж бүтээх конструктив арга			1						
25	Шинжлэх ухааны судалгааны түгээмэл арга /диалектик арга/			1						
26	Ажиглах турших арга , арга барил			1						
27	Сэргээн санах, ойлгох, задлан шинжлэх, хийсвэрлэх аргуудыг хэрэглэх			1						
28	Хичээлийн агуулгаас шалтгаалан оюутан-багшийг баг хэсэгт хуваах,ярилцлага, хэлэлцүүлэг хийх, бүтээлч байдлаар ажиллуулах арга зүй			1						
29	Бие биедээ заах арга				1	1				
30	Хэлэлцүүлгийн арга				1	1				
31	Тонгоруу арга					1				
32	Ойлголтын асуулт					1				
33	Шатарчилсан арга					1				
34	Багшийн асуултын арга							1		
35	Шоо ашиглан тайлбарлах арга							1		
36	Үлгэр дууриал үзүүлэх арга							1		
37	Хэл зүй ба орчуулгын арга							1		
38	Сонсох болон хэл ярианы арга							1		
39	Цээж сургалтын арга							1		
40	Уншлага							1		
41	Асуудал дэвшүүлэх	1								
42	Төсөлт ажил	1			1					
43	Үйлийн судалгааны алхамд суралцах	1								
44	Бүтээлч сэтгэлгээний аргууд	1			1					
45	Экземпляр арга	1								
46	CDIO	1								

47	STEAM	1								
48	Оролцооны арга							1		
49	Ажиглалтын							1		
50	Тайлбар	1	1	1	1				1	1

Судалгаанд хамрагдсан 12 сургууль дээр дурдсан 49 аргыг сургалтандаа ашигладаг. Сургалтын хэрэгжүүлэх үйл ажиллагааг арга зүйтэй нь холбохоос гадна ерөнхий суурь, багш боловсролын суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн чиглэл бүрээр холбон гаргаж өгсөн давуу талтай байна. Бусад сургуулиудын хувьд сургалтын үйл ажиллагааны явцад арга зүйгээр дамжуулан суралцагчдад мэдлэг бүтээх, тодорхой чадвар чадамжийг эзэмшүүлэхэд чиглүүлдэг тухай тайлбарласан байна.

- Их дээд сургуулиуд сургалтын аргыг дурдан бичихээс гадна лекц, семинар, оюутны бие даалт, дадлагын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа тэдгээрийг хийх арга зүй, мөн хийх явцдаа суралцах арга зүйг бичиж өгсөн онцлогтой байна.
- Бага ангийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт ашигладаг сургалтын аргын тоог сургууль тус бүрээр гаргаж үзвэл хамгийн олон аргыг Этүгэн их сургууль ашигладаг байна. Энэ нь нийт аргын 46,9 хувийг эзэлж байна. 30,6 хувийг Монголын үндэсний их сургууль, 26,5 хувийг Орхон их сургууль тус тус ашигладаг байна.
- Сургалтын арга зүйн талаар БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын 2.4.1-т суралцах үйл ажиллагаа нь оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах төсөлд суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулсан байна гэсэн заалтын хүрээнд 11 сургууль сургалтад ашигладаг арга зүйгээ дэлгэрэнгүй тайлбарлан тусгасан байна. Эдгээр сургуулиуд нь нийт 49 аргыг сургалтандаа ашигладаг байна.

## 5. СУРАЛЦАХ ОРЧИН

### Эрх зүйн зохицуулалт

Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага, стандарт, үзүүлэлтийн биелэлтийг БСШУЯ-ны сайдын 2007 оны 03 сарын 13-ны 74 тоот тушаалын 1-р хавсралт “Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага, стандарт, үзүүлэлт”-ийн биелэлтийг дараах байдлаар тусгасан байна.

*Хүснэгт 18. Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага*

д/д	Үзүүлэлт	Стандарт	1	2	3	4	5	6
1	Лабораторийн нэг суудалд ногдох талбай	2.5	2			1.85	2	
2	Бүх төрлийн лекцийн нэг талбайд ногдох талбай	2.2	2	7.5		1.14		
3	Хичээлийн лекцийн өрөө	1	3	1.4	0.9	6		
4	Лабораторийн өрөө	1	2			2		
5	Номын фондын өрөө	1	1			2		
6	Уншлагын танхим	1	1			2		
7	Профессорын өрөө	1	1					
8	Сургалтын бодлого алба	1	1			1		
9	Багш нарын өрөө	1	16	4.6	4.1	1		
10	Биеийн тамирын заал	1	1			2		

11	Нэг багшид ногдох талбай	1	4			4.6	2.7	
12	Байрны нэг оюутанд ногдох талбай	1	4	7		4.8		
13	Нэг оюутанд ногдох ном, сурах бичгийн тоо	20	24			47		48
14	Мэргэжлийн сурах бичгийн тоо	1/3	18559			3.45		720
15	Номын сангийн суудлын хүртээмж	15	100%					
16	Нэг багшид ноогдох оюутны тоо	15				13.5	24.3	48
17	Зөвлөх багшид ноогдох оюутны тоо							48
18	Эрдмийн зэрэг цолтой багшийн эзлэх хувь	15		100%		100%		
19	Орон тооны багшийн эзлэх хувь	75		95%		100%		
20	Гадаад, дотоодын хэвлэл захиалалт	3	16	0		14		
21	Нэг оюутанд ноогдох компьютерийн тоо	0.5	1			1		
22	Нэг багшид ноогдох компьютерийн тоо	1	1			1		1
23	Хөтөлбөрт ногдох оюутны тоо / удирдлага мэдээллийн систем дэх/			15				48

Тайлбар: 1-Монгол Улсын Боловсролын их сургууль; 2-Дорнод их сургууль; 3-Ховд их сургууль; 4-Монголын үндэсний их сургууль; 5-Гурван-Эрдэнэ дээд сургууль; 6-Этүгэн их сургууль

#### **Анги кабинетийн талаарх судалгаа**

Монгол Улсын Боловсролын их сургууль МУИС-н Дорнод аймаг дахь салбар сургууль МУИС-н Ховд аймаг дахь салбар сургууль, Монголын үндэсний их сургууль, Этүгэн их сургууль зэрэг 5 сургууль анги кабинетийн талаарх мэдээллийг тусгасан байна.

Хүснэгт 19. Анги, кабинетийн нэр

д/д	Анги, кабинетийн нэр	1	2	3	4	5
1	Лекцийн танхим	1	1	1	1	
2	Гадаад хэлний кабинет	1				
3	Лингафоны кабинет		1			
4	Компьютерийн лаборатори	1	1			
5	Монгол хэл, уран зохиолын кабинет	1				
6	Хүүхдийн сэтгэл судлалын кабинет	1				
7	Дүрслэх урлаг заах арга зүйн кабинет	1				
8	Дүрслэн урлахуйн кабинет	1				
9	Хэл яриа хөгжүүлэх арга зүйн кабинет	1				
10	Хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй	1				
11	Байгаль орчинтой танилцуулах арга зүйн кабинет	1				
12	Бие бялдар хөгжүүлэх арга зүйн кабинет	1				
13	Хөгжим заах арга зүйн кабинет	1				
14	Хөгжимт хөдөлгөөн арга зүйн кабинет	1				
15	Хүүхдийн эрүүл мэндийн кабинет	1				
16	Хөгжмийн кабинет	1	1			
17	СУХСС-ийн тэнхим	1				
18	Урлаг спортын тэнхим	1				
19	Сургалтын алба, мэрэгжилтэнгүүд	1	1		1	

20	Төгсөлтийн дараах сургалтын нэгж	1				
21	Сургалт арга зүйн төв	1				
22	Сургалт мэдээллийн төв	1				
23	Интернэт төв	1				
24	Менежментийн кабинет	1				
25	Захирал, нарийн бичгийн өрөө	1				
26	Багшийн өрөө	1	1			
27	Оюутны зөвлөлийн өрөө	1			1	
28	Зохион байгуулагчийн өрөө	1				
29	Ня-бо-гийн өрөө	1			1	
30	Эмчийн өрөө				1	
31	Номын сан	1			1	1
32	Биеийн тамирын зал	1	1	1		
33	Спорт заалны хувцас солих өрөө		1			
34	Урлаг заал	1	1	1		
<b>Оюутны үйлчилгээний газрууд</b>						
35	Мини кино заал					1
36	Цайны газар				1	1
37	Буфет					1
38	Фитнесс		1			1
39	Усан бассейн					1
40	E-IDEA FACTOR					1

Тайлбар: 1-Монгол Улсын Боловсролын их сургууль; 2-Дорнод их сургууль; 3-Ховд их сургууль; 4-Монголын үндэсний их сургууль; 5-Этүгэн их сургууль

***Тухайн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийн судалгаа***

Монгол Улсын Боловсролын их сургууль Ховд их сургууль, Этүгэн их сургууль зэрэг 4 сургууль Сургалтад хэрэглэж буй тоног төхөөрөмжийн талаар тусгасан байна.

Компьютер PC- 4, Компьютер ACER, Принтер Samsung4390, Принтер LazerJet M1212, Принтер Samsung scx3200, Принтер LazerJet M1010, Принтер Samsung scx4300, Принтер LazerJet M1100, Принтер Samsung ML1641, Принтер Samsung SC4300, Принтер LazerJet M1120, Принтер Samsung ML1641, Принтер LazerJet M1010, Принтер LazerJet M1120, Принтер Samsung scx4300, Принтер Samsung scx14521F, Принтер HPLazerJet 1010, Принтер ScanJet M1010, Принтер ScanJet M1011, Scanner, Notebook, Рүтер / Dlink 5 оролт/, Канон, Projector Privia PX-A100 даралтат хөгжим, Зурагт , Ухаалаг дэлгэц, Ширээ, Сандаг

***Сургалтад хэрэглэх программ хангамжийн судалгаа***

Microsoft office , Adobe indesign, Adobe photoshop, Dyened, Google chrome, Prezi trial зэрэг программ хангамжуудыг ашигладаг байна.

***Хичээлийн хөтөлбөрийн агуулга арга зүйд нийцсэн үндсэн сурах бичиг, нэмэлт гарын авлага, материалуудын судалгаа***

Монгол Улсын Боловсролын их сургууль Ховд их сургууль Монголын үндэсний их сургууль Этүгэн их сургууль зэрэг 4 сургууль үндсэн сурах бичиг, нэмэлт гарын авлага, материалуудын судалгааг хийсэн байна.

### **Хөтөлбөрт ашиглагдах дадлагын баазын судалгаа**

Их дээд сургуулиуд дадлагын бааз болгон улаанбаатар хот, хөдөө орон нутгийн сургуулиудтай хамтран ажилладаг, төрийн бус өмчийн их дээд сургуулиуд өөрийн сургуулийн дэргэдэх лицей сургуульд түшиглэн дадлага хийдэг байна. Сургуулийн үйл ажиллагааны цар хүрээ, багш бэлтгэх хөтөлбөрийн тоо, суралцагч оюутны тоо зэргээс шалтгаалан хамтран ажиллах байгууллагуудын тоо харилцан адилшгүй хамгийн ихдээ нэг сургууль 74 хүртэл сургалтын байгууллагатай хамтран ажилладаг байна.

Орчны талаарх судалгаанд өөр бэлэн, шинжилгээ дүгнэлт хийсэн эх материал, судалгааг ашиглавал зүгээр санагдана. Энд, орчны дээрх дэд бүлгүүдээр шаардлага хангасан, хангаагүй үнэлгээ, дүгнэлтүүд, цаашид анхаарвал зохих зөвлөмж, зөвлөгөөтэй бол сайн.

### **6. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА**

Судалгаанд хамрагдсан их дээд сургуулиуд элсэгчдэд тавих шаардлагыг БШУСайдын А/143 тоот тушаал-д үндэслэн боловсруулсан байна.

Судалгаанд хамрагдсан их дээд сургуулиудын элсэгчдэд тавих шаардлагыг судалснаар 13 төрлийн шаардлага байгааг тогтоолоо. Үүнд:

- Эрх зүйн зохицуулалт
- Боловсролын түвшин
- Элсэлтийн ерөнхий шалгалт
- Элсэхээр хүсэлт гаргагчийн өмнөх шагнал, нийгмийн идэвх болон бусад хүндэтгэх шалтгаан
- Хувь хүний чадамж
- Ерөнхий боловсролын суурь чадвар
- Бакалаврын түвшний элсэгчдэд тавих шаардлага
- Гадаадын иргэнд тавих шаардлага
- Эрүүл мэндийн шаардлага
- Магистрын түвшний элсэгчдэд тавих шаардлага
- Докторын түвшний элсэгчдэд тавих шаардлага
- Гадаадын иргэнд тавих шаардлага
- Эрүүл мэндийн шаардлага

Их, дээд сургуулиуд нь нийт 45 төрлийн шаардлагыг элсэгчдэд тавьсан байна (Хүснэгт 20).

*Хүснэгт 20. Элсэгчдэд тавих шаардлага*

<b>Багш, сургуулийн өмнөх насны боловсрол хөтөлбөрт элсэгчид тавих шаардлага</b>	<b>Сургуулийн тоо</b>
<b>Эрх зүйн зохицуулалт</b>	
Оюутан элсүүлэхдээ БШУЯ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журмыг”-ыг үндэслэн зохион байгуулна	3
Тухайн их дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталсан “Оюутан элсүүлэх журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг.	3
<b>Боловсролын түвшин</b>	
Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байна	6
Бүрэн дундаас доошгүй боловсролтой, түүнтэй дүйцүүлэх боловсрол эзэмшсэн байх	3
<b>Ерөнхий эрдмийн шалгалт</b>	
Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 400 болон түүнээс дээш байна.	5
Тухайн мэргэжлийн чиглэлээр өгсөн ЕШ-ийн босго оноо нь 450 ба түүнээс дээш байна.	1

Элсэлтийн ерөнхий шалгалт өгч оноо авсан байх	1
Элсэлтийн ерөнхий шалгалтыг сүүлийн 2 жилийн дотор өгсөө байна.	1
Ерөнхий шалгалтын батламж 2,5 жилд хүчинтэй	2
Математик, Монгол хэлний шалгалт өгсөн байх	3
Монгол хэл Математик хичээлүүдийн ерөнхий шалгалт, эсвэл дүйцүүлэх шалгалт өгсөн бол түүний дүн нь тооцож болох хүчинтэй хугацааны дотор байна.	1
Монгол хэл болон гадаад хэл, байгалийн ухааны аль нэг хичээлээр 400-с доошгүй оноо авсан байх	1
Нийгмийн тухай мэдлэг монгол хэлний хичээлээр ЭЭШ-г заавал өгч тухайн жилд МИДКС-аас тогтоосон болон тус сургуулийн элсэлтийн журамд заасан босго онооноос доошгүй оноо авсан байна.	1
Багш сонгоны суралцагчдыг шууд элсүүлэх	1
Эрэгтэй элсэгчдийг 400-с дээш оноотой бол элсүүлэх	1
Эзэмших мэргэжлийн талаарх төсөөлөл, зорилго, багш болох чин хүсэл, суралцах арга барлын талаар эсээ бичин хэл найруулга,сэтгэлгээний чадварын гарааны үнэлгээ хийх	1
<b>Элсэхээр хүсэлт гаргагчийн өмнөх шагнал, нийгмийн идэвх болон бусад хүндэтгэх шалтгаан</b>	
Элсэхээр хүсэлт гаргагчийн өмнөх шагнал, нийгмийн идэвх болон бусад хэндэтгэх шалтгаануудыг харгалзан үзэх	1
Олон нийтийн оролцоо идэвх санаачлага гаргасан байх	2
Олон улсын, бүсийн олимпиадад эхний 3 байр эзэлсэн суралцагчийг элсүүлэх	1
<b>Хувь хүний чадамж</b>	
Элсэгчийн намтар бичих	1
Мэргэжилдээ дур сонирхолтой байх	3
Бага насны хүүхэдтэй ажиллах сонирхолтой байх	1
Хүүхдэд хайртай байх	1
хүүхдийг бүх талаар цогц хөгжүүлэхийн тулд элсэгч өөрөө бүтээлч хөгжих боломжтой байх	1
Урлах, бүтээх чадвартай байх	1
Өөрийгөө илэрхийлэх чадвартай, үг ярианы баялагтай байх	1
Сэтгэн бодох чадвар, уран сэтгэмжээр дүүрэн байх	1
Ямар нэг авьяастай байх	2
Мэргэжлийн үнэ цэнийг ойлгодог байх	1
Өсөн дэвжих, насан туршдаа суралцах эрмэлзэлтэй байх	1
Зөв хүн байх	1
Аливаад хандах хандлага сайтай байх	1
Ил газраа шивээсгүй байх	1
<b>Ерөнхий боловсролын суурь чадвар</b>	
Монгол хэлээр чөлөөтэй уншиж,сонсож, бичиж, ярьж чаддаг байх	1
Компьютер, англи хэлний анхан шатны мэдлэгтэй байх	1
Зөв бичгийн дүрмийн алдаагүй бичдэг байх	1
Найруулан бичих чадвартай байх	1
<b>Бакалаврын түвшний элсэгчдэд тавих шаардлага</b>	
Дээд боловсролтой иргэн өдрийн ангид элсэхэд өмнөх бакалаврын дипломны голч дүн 2,5-аас дээш байна.	1
Орой, эчнээ, нягтлан бодох бүртгэлийн бямба гарагийн ангид элсэгчид нь тухайн элсэж буй мэргэжлээс өөр мэргэжлээр бакалаврын зэрэгтэй байна.	1

Гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн элсэхдээ ерөнхий шалгалтыг дүйцүүлж болох тухай тодорхойлолтыг БШУЯ-аас авсан байна.	2
Хөрвөх сургалтад элсэх хүсэлтэй иргэн бакалаврын зэрэгтэй байна	1
Оюутан авьяас сонирхолдоо нийцсэн мэргэжил сургуулиа сонгох зэрэг тодорхой шалтгааны улмаас дотоод гадаадын их дээд сургууль болон тус их сургуулийн аль нэг үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөс нөгөөд шилжин суралцаж болно. Сургууль хоорондын кредитыг хүлээн зөвшөөрөх нөхцөл	1
<b>Магистрын түвшний элсэгчдэд тавих шаардлага</b>	
Магистрын ангид элсэгчид тухайн мэргэжлээр бакалаврын зэргийн боловсролыг 2,8-аас дээш голч дүнтэй эзэмшсэн байна.	1
<b>Докторын түвшний элсэгчдэд тавих шаардлага</b>	
Докторын ангид элсэгчид магистрын зэрэг эзэмшсэн, магистрын дипломны голч дүн 3,0-оос дээш байна.	1
<b>Гадаадын иргэнд тавих шаардлага</b>	
Гадаадын иргэд элсэхдээ өөрийн төгссөн бүрэн дунд боловсролын үнэмлэх болон түүнтэй дүйцэх баримт бичиг, хичээлүүдийн дүнгийн үнэлгээ, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн нөхцлийг үндэслэн элсүүлнэ.	1
Гадаадын иргэнийг .... –д элсүүлэх,оюутан солилцооны болон зуны хөтөлбөрт суралцуулах асуудлыг журмаар зохицуулна.	1
<b>Эрүүл мэндийн шаардлага</b>	
Хэл ярианы согоггүй байх	1

Зураг 15. Элсэгчдэд тавих шаардлага тус хамаарах шаардлага



Судалгаанд хамрагдсан их, дээд сургуулиуд нь:

- БСШУ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын 2.6 дугаар заалтад тусгасан элсэлтийн ерөнхий шалгалтын хүчинтэй хугацааны талаарх шаардлагыг тусгаагүй.
- Ерөнхий эрдмийн шалгалтын оноо болон элсүүлэх нэмэлт нөхцлийн талаарх шаардлагууд нийт шаардлагын 26,6 хувийг эзэлж байна.
- Хувь хүний чадамжийн талаарх шаардлагууд нийт шаардлагын 31,1 хувийг эзэлж байна.

## 7. БАГШИД ТАВИХ ШААРДЛАГА

Багшид тавих шаардлагыг “Дээд боловсролын тухай хууль”, “Бакалаврын хөтөлбөрт тавих шаардлага”, “Тухайн сургуульд багш ажиллуулах журам” зэрэг эрх зүйн үндэслэл болох баримт бичгийг баримталдаг байна.

Хүснэгт 21. Сонгон шалгаруулалтад орох багшид тавих шаардлага

Багшид тавигдах шаардлага	Сургуулийн тоо
<b>Боловсролын зэрэг</b>	
Мэргэжлийн хичээл заах багш нь тухайн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байна.	7
Нийт багш нарын 70-аас доошгүй хувь нь үндсэн багш байна.	2
<b>Багшийн мэргэжлийн шаардлага</b>	
Сургуулийн эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд ноогдох ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ биелүүлэхүйц байна.	3
.....сургуулийн профессор, багш (цаашид, багш гэнэ) нь онолын гүнзгий мэдлэгтэй; судалгааны болон заах арга зүй эзэмшсэн; сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хослуулан гүйцэтгэх чадвар, дадалтай; мэдлэг, чадвараа дээшлүүлэхийн төлөө байнга санаачлагатай ажилладаг; сургалт, судалгааны ажилдаа мэдээллийн технологийн ололтыг ашигладаг, залуу үеийг сурган хүмүүжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлсэд чин сэтгэлээсээ ханддаг; оюуны өндөр чадамжтай, зөв төлөвшсөн, судлаачийн ёс зүйг эрхэмлэдэг эрдэмтэн байна.	7
Мэргэшлийн хичээл заадаг, таваас дээш жил ажиллаж байгаа багш тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний ажил заавал хийж, гадаадын хоёроос доошгүй хэлээр мэргэжлийн ном сэтгүүл ашиглах чадвартай байна.	2
Тав хүртэл жил ажиллаж байгаа залуу багш мэргэжлээ гүнзгийрүүлэн эзэмших; сургалт, судалгааны арга барил, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх төлөвлөгөө гаргаж тэнхим/профессорын багийн эрхлэгч/ахлагчаар батлуулж ажиллана. Тэнхим/профессорын багаас залуу багшийг удирдан ажиллах сургалт, эрдэм шинжилгээний ажлын туршлагатай багшийг томилж, төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавина.	3
Гадаадад ажиллах, суралцахаар явсан багш сургуультай гэрээ хийх ба хугацааг нэг удаа сунгуулж болно. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээний хугацааг хэтрүүлбэл ажилд эргэж орох асуудлыг шинэ багшийн адил сонгон шалгаруулалтаар шийдвэрлэнэ.	1
Үндсэн мэргэшлийн хичээл заадаг багш .....д багшаар томилогдсноос хойш 12 жилийн дотор докторын (Ph.D) зэрэг хамгаалсан байна. Энэ хугацаа нь ажиллаж байгаа багш нарт мөн адил хамаарах ба докторын зэрэг хамгаалаагүй ч болзлыг биелүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн гэрээг .....(1-2) хүртэл жилээр сунгаж болно. Энэ шаардлагыг хангаагүй нөхцөлд .....-д үргэлжлүүлэн багшлуулах боломжгүй гэж үзнэ.	2
Багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд хангалтгүй дүн үзүүлж, эрдэм шинжилгээ, сургалт заах аргын ур чадварын хувьд өсөөгүй, цаашид багшаар ажиллуулах боломжгүй гэж бүрэлдэхүүн сургууль шийдвэрлэвэл зохих журмын дагуу тухайн багшийн хөдөлмөрийн гэрээг цуцалж, хичээлийн жилийн эцэст ажлаас чөлөөлнө.	2
Үйлдвэрлэл практикийн туршлагатай, өндөх мэргэшсэн ажилтныг холбогдох чиглэлээр зочин багшаар урих, оюутны дадлага улирдуулах боломж бүрдүүлэх ба энэ тохиолдолд албан ёсны гэрээ байгуулан ажиллана	2

Төсөл хөтөлбөрийг практик уйл ажиллагаанд бүтээлчээр хэрэгжүүлэх чадвар туршлагатай байна.	
Өөрийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг суралцагчдын ухамсартай бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан багш бие хүний үндсэн шинж төлөвшихөд үлгэр үзүүлэхүйц хэмжээнд зохион байгуулах чадвартай мэргэжлийн өндөр бэлтгэлтэй багшлах эрх бүхий байна.	2
Багшийн ёс зүйн дүрэм, хэм хэмжээг мөрдөн ажилладаг, зөрчилгүй байх	4
Багш нь судалгааны ажилдаа гадаад хэлийг ашиглах мэдлэг чадвартай байна.1-с доошгүй гадаад хэл эзэмшсэн байна.	3
Мэдээллийн технологийг ашиглан тасралтгүй бие даан суралцах чадвартай байх	1
Багш, сургуулийн өмнөх насны боловсрол хөтөлбөрийн бакалаврын зэрэг эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нар нь заах хичээлийн чиглэлд тохирох мэргэжлийн боловсрол болон сурган заах аргын мэдлэгийг эзэмшсэн байна.	4
Багшийн цагийн ачаалал нь тохиромжтой байх ба хичээлийн бэлтгэлийг хангах, суралцагчидтай хамтран ажиллах, өөрийнхөө мэдлэг мэргэжлийг дээшлүүлдэг байх	1
Мэргэжлийн болон сургалтын арга, заах арга, технологийн чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлж, сургалтад үр дүн ахиц гардаг байх	1
Багш нь суралцагчаар мэдлэг бүтээлгэх замаар хичээл сургалтыг зохион байгуулах ба мэдлэг чадвар, төлөвшилийг хослуулан үнэлдэг байх	1
Багш сургалт болон суралцагчийг үнэлэхдээ мэдээлэл харилцааны технологийг ашигладаг байх	2
Багш өөрийн үйл ажиллагаандаа судалгаа хийж, багшлах ажлаа сайжруулдаг байх	3
Багш нь эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх цаг хугацаа, орчин нөхцөл бололцоогоор хангуулж,үндэсний болон олон улсын түвшинд үр дүн гардаг, сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц үр ашигтай байх	2
Багш нар хамтарч ажилладаг байх, хамтарсан үйл ажиллагаа /хөтөлбөр, хичээл, ном, гарын авлага, хичээлээс гадуурх ажил, сургалт-семинар/-ууд үр дүнтэй байдаг байх	2
Багш хичээл сургалтадаа хувь оюутны сурах чадвар, чадамжийг харгалзан үздэг байх, түүнийг хөтөлбөрт тусгасан байх	1
Багш нь ажлын эерэг, бүтээлч уур амьсгалаар ажиллаж мэдлэг туршлагаа хөтөлбөрийнхөө хөгжилд бүрэн дайчилдаг байх	2
<b>Бусад шаардлага</b>	
Суралцагч бүрийн бие даасан байр суурь үзэл бодол онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг хүндэтгэлтэй харьцдаг байна.	1
Бие даан болон багаар ажиллах чадвартай илтгэх баримт бичиг боловсруулах, найруулан бичих ур чадвар эзэмшсэн бусдын бодлыг хүндэтгэн зөвшилцөж багаар ажиллах чадвартай	1
Өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай	1
Хүүхдэд хайртай	1
Багаар ажиллах чадвартай	1
Зөв эерэг хандлагатай	2
Манлайлагч	1
Харилцааны өндөр ур чадвартай	2

Дээрх хүснэгтээс харахад багшид тавих шаардлага нь 3 үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд нийт шаардлагын 7.0 хувь нь боловсролын зэргийн талаарх шаардлага, 29.0 хувь нь багшийн мэргэжлийн шаардлага, 64.0 хувь нь бусад төрлийн шаардлага байна.

Бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн багш нарын судалгаа, бусад салбар тэнхимийн багш нарын судалгаа, ерөнхий суурь хичээлийн багш нарын судалгааг тусгажээ.

## 8. ТӨГСӨГЧИЙН ЭЗЭМШИХ УР ЧАДВАР

Их дээд сургуулиуд төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг дараах байдлаар ангилсан байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага

Төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага	Нийт
<b>I. Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар дадал төлөвшил</b>	
<i>Хувь хүний суурь мэдлэг, чадвар, хандлага</i>	
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа мэдэх, бахархах, хадгалах, хэрэглэх, хөгжүүлэх	2
Иргэний ардчилсан ёсны суурийг бүрдүүлэгч, үнэт зүйлсийг мэддэг, бусад үндэстэн, бүс нутаг, өөрийн улс орны түүх, соёлын өвийг олон ургальч агуулгаар олгох, тайлбарлах, баяжуулах чадвартай, эх оронч үзэлтэй, хүнлэг ёсыг дээдлэн сахидаг байх	1
Хувь хүний болон иргэний эрх, эрх чөлөө ардчилсан ёс, хууль дээдлэх зарчим, шударга ёс, хүнлэг чанарыг эрхэмлэдэг	1
Бага насны хүүхэдтэй ажиллах сонирхолтой, тэднийг хайрладаг сэтгэлтэй, тулгамдсан асуудалд зөв шийдвэр олж чаддаг оюуны өндөр чадавхитай, эх оронч бусад улс үндэстний соёл иргэншлийг ойлгон хүндэтгэдэг эрх зүйт төр хууль цаазыг дээдэлдэг.	2
Байгаль, нийгэм, хүний хоорондын харьцааг зохицуулдаг, ёс зүй, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, энэ мэдлэгээ амьдрал, үйл ажиллагаандаа хэрэглэх чадвартай байх	2
Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны төсөөлөлтэй болсон, өөрийн бие бялдрыг хөгжүүлэх чадвар, дадалтай байх	1
Урлаг спортын ерөнхий мэдлэгтэй, байгаль, гоо сайханы мэдрэмжтэй, эрүүл аж төрөх ёс зүйд суралцсан, гадаад хэлний зохих мэдлэгтэй байна	1
Бие даан бүтээлчээр суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвартай байх	1
Хамт олны дунд ажиллахад бэлэн, өөрийн хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулдаг, харилцааны соёлтой байх, зөрчилтэй нөхцөлд бусдын үзэл бодлыг хүндэтгэн зөвшилцөж, өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх	2
Шинэ санаа гаргах, түүнийгээ хэрэгжүүлэх чадвар дадлыг олгосон байна.	1
<i>Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадал төлөвшил</i>	
Шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх чадвартай болсон байна /Асуудлыг тодорхойлж, шинэ санаа гаргах, зураглах, боломжит хувилбарыг сонгож, илэрхийлэн харуулах г.м/	2
Асуудлыг шинжлэн судалж шийдэл гаргах чадварыг бүрдүүлсэн байна. /Таамаглал дэвшүүлэн, харьцуулсан судалгаа, анализ хийж, загварчилж, баримт бичиг боловсруулах	1
Суралцах төлөвлөгөөг жил, улирал, сар, өдөр, цагаар төлөвлөх чадвар эзэмшсэн байна. /мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгож, ач холбогдлоор нь ангилан, чухал санаан дээр төвлөрч, харилцан хамаарлыг нь шалгах, харьцуулан сонгох г.м/	1
V. Мэргэжлийн онцлогийг нийгэм цаг үетэй холбон ойлгуулах, заах, цаашид суралцах, гүйцэтгэх чадвартай болсон байна.	1
Хүний хөгжлийн зүй тогтол, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг таньж мэдэх	1
Суралцагчийн хөгжил, төлөвшил болон нийгэм-сэтгэл зүйн орчны онцлог, түүнийг сургалт үйл ажиллагаанд харгалзах чадвартай байх	1
Боловсролын тогтолцоо, түүний удирдлагын үндсийн тухай мэдлэг	2
Хүний хөгжлийн зүй тогтол, хувийн ба нийгэм сэтгэлзүйн онцлогийг таних, харгалзах	1

Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах /хөтөлбөр боловсруулах, хөтөлбөр үнэлэх, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн хэрэглэгдэхүүн бэлтгэх,	1
Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон сургалтын арга барил, арга технологийг ашиглах, зурах, урлах, наах бүтээл үйлүүдийг эзэмшсэн	2
Хүмүүнлэгийн болон нийгэм-эдийн засгийн шинжлэх ухааны үндсэн сургаалиудтай танилцсан, нийгмийн шинжтэй үйл явдал, асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжлэх чадвартай, эдгээр шинжлэх ухааны аргуудыг мэргэжлин болон нийгмийн төрөл бүрийн үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг байх	2
Амьд болон амьгүй байгаль дэх үзэгдэл үйл явцын тухай бүрэн дүүрэн төсөөлөлтэй, байгалийг танин мэдэх шинжлэх ухааны орчин үеийн аргуудын боломжийг ойлгосон, тэдгээрийг мэргэжлийн үүргээ биелүүлэхэд ашиглаж чаддаг байх	1
Мэргэжлийн үүргээ биелүүлэхтэй холбоотой зорилгыг тавих, зорилтуудыг тодорхойлох чадвартай, тэдгээрийг шийдвэрлэхэд шинжлэх ухааны аргуудыг ашиглаж чаддаг байх	1
Сургалтын идэвхитэй арга барил болон сургалтын бусад арга барилын олон хувилбаруудаас оновчтой сонгон суоган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чадвартай	1
Багшийн нэр хүнд ёс зүй, төрийн хууль, дүрэм, журам сахин мэдэх, мөрдөх, үлгэрлэх	1
<b>II. Хүмүүстэй харилцах чадвар</b>	
Нэгээс доошгүй гадаад хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай байх	2
Багаар ажиллах чадвартай байх, өөрийн хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулдаг, харилцааны соёлтой, Монгол утга зохиолын хэлээр найруулан бичих, илтгэх, зөрчилтэй нөхцөлд бусад үзэл бодлыг хүндэтгэн зөвшилцөж оновчтой шийдвэр гаргах, өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх	1
Орчин үеийн мэдээлэл технологийг ашиглан өөрийн мэдлэгээ баяжуулан, шинэ мэдлэг олж авах, бие дааж суралцах чадвартай бүтээлч сэтгэлгээтэй, ертөнцийг үзэх үзэлтэй	3
Номын сангийн фонд , компьютерийн систем , гадаад ном хэвлэл зэргээр дамжуулан мэргэжлийн холбогдол бүхий мэдээллийг авч ашиглах чадвартай	1
Шинжлэх ухааны хөгжил, нийгмийн практик хурдацтай өөрчлөгдөж байгаа нөхцөлд өөрийн боломждоо дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан шинэ мэдлэг олж авах, өөрийн мэргэжил боловсролоо бүтээлчээр тасралтгүй дээшлүүлэх чадвартай байх	1
Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, бага насны хүүхдийг хөгжүүлэх арга технологи, боловсролын хөгжлийн үндсэн чиглэл, хэтийн төлөвийн талаар мэдлэг, чадвартай байх	1
Мэдлэг боловсролоо бие даан дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэх чадвартай	1
Багаар ажиллах, удирдах, манлайлах, гүйцэтгэх чадваруудыг эзэмшсэн байна. /Баг бүрдүүлэх, багийг удирдах, төслийн менежментийг хэрэгжүүлэх, манлайлах г.м/	1
Хүн, нийгэмтэй харилцах чадварыг эзэмшүүлсэн байна. /Техник технологи хөгжиж буй өнөө үед албан болон хувийн хэрэгцээнд электрон шуудан илгээх, хүлээн авах, мултимедиа, график дүрслэл ашиглан тайлан бэлтгэх, тайлагнах, илтгэх ур чадвар/	1
Тухайн гадаад хэлээр мэргэжил, мэдээлийг ашиглах чадвартай байна.	1
Хөтөлбөрийн хичээлээр мэдлэгийг эзэмшиж, мэргэжлийн ур чадварыг эзэмшихэд сургууль туслан дэмжсэн байна.	1
<b>III. Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар</b>	
Монгол улсын үндсэн хууль, боловсролын багц хууль, Засгийн газрын тогтоол шийдвэр , хүүхдийн эрхийн конвенц зэрэг эрх зүйн актыг зөв ойлгож хэрэглэх , тайлбарлах хэрэгжүүлэх чадвартай	5
Бага насны хүүхдийн мэдлэг чадвар хэвшлийг үнэлэх чадвартай	1
Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийж , тэдний хөгжлийн түвшинг	1

тодорхойлох , судалгааны үр дүнд өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт өгч чаддаг чадвартай	
Хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийх, судалгааны үр дүнд боловсруулалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх	1
Бага насны хүүхдийн сурч хөгжих, үр ашигтай аргуудыг хэрэглэх чадвартай	1
Бага насны хүүхдэд аюулгүй, аюултай гэдгийг ойлгуулж мэдрүүлэх чадвар чадвартай	1
Хүүхдийг хайрладаг тэдэнтэй эв дүйтэй харьцдаг	2
Бага насны хүүхэд боловсролын ямар үйлчилгээг авах ёстой тухай мэдлэг	2
Ерөнхий сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын орчин үеийн онол арга зүйн мэдлэг	3
Бага насны хүүхдийн хөгжлийн тухай онол үзэл баримтлал	2
Бага насны хүүхдийн хөгжил, түүний онцлог	1
Хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг	2
Судалгааны арга зүйн мэдлэг	1
Бага насны хүүхдийн нас сэтгэцийн хөгжлийн онцлогт тулгуурлан тэднийг хөгжүүлэх арга технологийн талаарх мэдлэг	1
Бага насны хүүхдийг сургаж хөгжүүлэх сургах зүйн дидактик системтэй мэдлэг эзэмшсэн	3
Бага насны хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх мэдлэг эзэмшсэн	3
Бага насны хүүхдийн математик чадварыг хөгжүүлэх мэдлэг эзэмшсэн	3
Бага насны хүүхдийн эцэг эхтэй ажиллах арга барилын мэдлэг эзэмшсэн	2
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж хөгжүүлэх онол арга зүйн мэдлэг	3
Холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг мөрдөх, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах,	1
Бага насны хүүхдийн мэдлэг чадварыг үнэлэх,	1
Хувилбарт сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,	1
Хүүхдийн хэл яриа, сэтгэхүйг хөгжүүлэх,	2
Бага насны хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх,	1
Сургалтын үйл ажиллагааны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангах.	2
Сургалтын арга барилын олон хувилбаруудаас оновчтойг сонгон авч сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	1
Хувилбарт сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	1
Бага насны хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл, чийрэг өсгөж, хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх	3
Хүүхэд өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харьцах, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах	2
Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх	2
Заах арга, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх	2
Хөгжлийн орчин үеийн чиг хандлага, судалгааны, арга барилын талаар цогц мэдлэгтэй	1
Хүүхдийг судалж танин мэдэх чадварыг эзэмшсэн.	1
Суралцагчийн сурах үйл ажиллагааг удирдан дэмжихэд багшийн гүйцэтгэх үүргүүдийг мэддэг байх	1
Сургах үйл ажиллагааг сургалтын зорилгод чиглүүлэн хэрэгжүүлэх хичээлээрээ дамжуулан бие хүнийг хүмүүжүүлэх хөгжүүлэх мэдлэгтэй	1
Орчин үеийн сургалтын хэрэглэгдэхүүн тэдгээрийг хэрэглэх мэдлэгтэй	1
Сургалт хүмүүжлийн ажлын үр дүнг хянах ажлыг зохион байгуулах мэдлэгтэй	1

Хүүхдийг таньж мэдэх сурах хэрэгцээ, сонирхлыг судлах чадвар	1
Сургалтын өөр өөр орчинд суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжих чадвар	1
Суралцагчийг ялгаварлан гадуурхалгүйгээр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах чадвар	1
Сургалтыг бие хүний үнэт зүйлсийг төлөвшүүлэхтэй хослуулах чадвар	1
Сургалтын явцад суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, тэднээр техникийн аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах дүрмийг сахиулах чадвар	1
Хичээлээс гадуурх сургалт-хүмүүжлийн ажлыг төлөвлөх, удирдах чадвар	1
Анги удирдах /ангид хичээл заах/үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвар	1
Ангийн баримт бичиг /журнал, ажиглалт, тэмдэглэл, мэдээ/хөтлөх чадвар	1
Сургалт заах аргын нэгдэл болон заах аргын бусад хэлбэрийн үйл ажиллагаанд оролцох,бусад багш нартай хамтран ажиллах чадвар	1
Багшийн мэргэжлийн ёс зүйн шаардлагыг эрхэмлэн сахиж, биелүүлэх чадвар	1
Сургалтын талаар баримтлах бодлого-ын 8 дахь заалт "Сургалтын үнэлгээ"	1
сургалтын гэрээний хавсралт (1) курс тус бүрт оюутны эзэмшсэн байх чадварын жагсаалт	1
Оюутныг бүтээлийн сангаар үнэлэх удирдамж	1

Төгсөгчдийн эзэмших ур чадвар бүлэгт ихэнх их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт:

- Ерөнхий боловсролын сургуулийн багш MNS 5323-95 : 2009 стандартын 5 дугаар бүлгийн Төгсөгчдийн бэлтгэлд тавих нийтлэг шаардлага, "Ерөнхий боловсролын багш" мэргэжлээр төгсөгчийн мэргэжлийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлагуудыг бичсэн;
- Мэргэжлийн болон мэргэжлийн чиглэлийн хичээлүүдийн хүрээнд төгсөгчийн эзэмших мэргэжлийн болон мэргэжлийн мэдлэгийг тодорхойлсон;
- Төгсөгчдөд тавих 91 төрлийн шаардлага байна;
- Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварын тодорхойлсон нь 59.0 хувийг эзэлж байна.
- Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил 29.0 хувийг эзэлж байна.

БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад тусгасан “Төгсөгчдийн эзэмших ур чадвар” хэсгийг илүү нарийвчилж тодорхой болгох шаардлагатай байна.

## 9. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

1. Суралцагчийн үнэлгээ хэсэг нь дараах хэсгүүдээс бүрдэж байна.

- ✓ Эрх зүйн зохицуулалт
- ✓ Үнэлгээний хэлбэр
- ✓ Үнэлгээнд тавигдах шаардлага
- ✓ Үнэлгээний шалгуур
- ✓ Үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг
- ✓ Үнэлгээний зохион байгуулалт
- ✓ Оюутны мэдлэг, чадварыг үнэлэхэд анхаарах зүйлс

*Хүснэгт 23. Суралцагчийн үнэлгээ*

Суралцагчийн үнэлгээ	1	2	3	4	5	6	7	8	9	10	Нийт
Эрх зүйн зохицуулалт											

БСШУЯ-ны Сайдын 2003 оны 05 сарын 09 өдрийн 158 тоот тушаалаар батлагдсан журам									1	1
Сургуулийн захирлын “Оюутны мэдлэг чадварыг үнэлэх журам”			1							1
Сургуулийн захирлын тушаалаар батлагдсан “Оюутны сурах үйл ажиллагааг үнэлэх журам”										1
Бакалаврын сургалтын журам	1							1		2
<b>Үнэлгээний хэлбэр</b>										
Явцын үнэлгээ		1		1	1	1	1		1	7
Улирлын үнэлгээ		1			1	1	1		1	6
Ур чадварын үнэлгээ		1				1	1			5
Бусад үнэлгээ		1				1	1			4
Ирц, идэвх					1			1	1	3
Бие даалтын ажил					1			1	1	3
Явцын шалгалт								1		1
Батлах шалгалт								1		1
1- ангийн оюутнуудын эзэмших чадварын биелэлийг шалгах				1						1
2- ангийн оюутнуудын эзэмших чадварын биелэлийг шалгах				1						1
3- ангийн оюутнуудын эзэмших чадварын биелэлийг шалгах				1						1
4- ангийн оюутнуудын эзэмших чадварын биелэлийг шалгах				1						1
Төгсөлтийн шалгалт				1						1
Хувьчилсан оноо - үсгээр илтгэсэн дүн-тоогоор илтгэсэн дүнгийн хамаарлыг харуулсан	1							1	1	3
Ерөнхий суурь мэдлэгийн багц шалгалт			1							1
мэргэжлийн суурь хичээлүүдийн багц шалгалт			1							1
<b>Үнэлгээнд тавигдах шаардлага</b>										
Үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн, бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой.		1			1			1		3
Хөтөлбөрийн үр дүн нь мэргэжлийн эрх олгохтой холбогдох тохиолдолд харгалзах мэргэжлийн шалгалтын үнэлгээний аргачлалтай нийцэхүйц байна		1			1			1		3
Үнэлгээнд харгалзан үзэх хүчин зүйлүүд		1								1
Үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг		1								1
Үнэлгээний зохион байгуулалт			1		1					2
Оюутны мэдлэг, чадварыг үнэлэхэд анхаарах зүйлс		1								1

Тайлбар: 1-МУИС-н Дорнод аймаг дахь салбар сургууль; 2-МУИС-н Ховд аймаг дахь салбар сургууль; 3-Монголын үндэсний их сургууль; 4-Гурван-Эрдэнэ дээд сургууль; 5-Засагт Хан дээд сургууль; 6-Хангай дээд сургууль; 7-Дархан дээд сургууль; 8-Боловсрол,соёл,эрх зүйн дээд сургууль; 9-Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль; 10-Орхон их сургууль

Эрх зүйн зохицуулалт

Судалгаанд хамрагдсан их дээд сургуулиуд нь БСШУЯ-ны Сайдын 2003 оны 05 сарын 09 өдрийн 158 тоот тушаалаар батлагдсан журам, БСШУЯ-ны Сайдын Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага А/174 тоот тушаалыг баримтлахаас гадна “Бакалаврын сургалтын журам”, “Оюутны сурах үйл ажиллагааг үнэлэх журам”, “Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам”, Сургалтын талаар баримтлах бодлого, Сургалтын үнэлгээ, Сургалтын гэрээ, Оюутныг бүтээлийн сангаар үнэлэх журам, Төгсөлтийн шалгалтын хөтөлбөр зэргийг эрх зүйн зохицуулалт болгон ашигладаг байна.

*Үнэлгээний хэлбэр*

- ✓ БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын хүрээнд үнэлэх
- ✓ Тухайн курсын оюутнуудын эзэмших чадварын биелэлийг шалгах
- ✓ Ирц, идэвх, Бие даалтын ажил
- ✓ Батлах шалгалт
- ✓ Ерөнхий суурь мэдлэгийн багц шалгалт
- ✓ Мэргэжлийн суурь хичээлүүдийн багц шалгалт гэсэн хэлбэрүүдтэй байна.

*Зураг 16. Үнэлгээний хэлбэр*



БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад “хичээл бүрийн үнэлгээний зэрэгцээ хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг дараах хэлбэрээр үнэлнэ”.

- ✓ Явцын үнэлгээ
- ✓ Улирлын үнэлгээ
- ✓ Ур чадварын үнэлгээ
- ✓ Бусад үнэлгээ гэж тусгасан байна.

*Үнэлгээнд тавигдах шаардлага:*

БСШУ-ны Сайдын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад “Үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн, бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой байх, хөтөлбөрийн үр дүн нь мэргэжлийн эрх олгохтой холбогдох тохиолдолд харгалзах мэргэжлийн шалгалтын үнэлгээний аргачлалтай нийцэхүйц байна” гэж заасан байна

- Их дээд сургуулиуд сургалтын хөтөлбөртөө оюутны мэдлэг чадварыг үнэлэх үнэлгээ нь тэдний бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, багшийн зөвлөн туслах, чиглүүлэх, хамтран ажиллах зарчмыг удирдлага болгох ба шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байх зарчимд суурилдаг тухай бичсэн байна.
- Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам-ын гуравдугаар зүйлийн 13-заалтад Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхэд А, В, С, D, F гэсэн үсгэн дүн, 4, 3, 2, 1, 0 гэсэн тоон дүн болон процентон дүн хэрэглэнэ. Түүнчлэн тооцов, үл тооцов гэсэн тэмдэглэгээг хэрэглэж болно гэж заасан байна.

*Хүснэгт 24. Суралцагчийн тоон болон үсгэн үнэлгээ*

№	Рейтингийн оноо	Тоон үнэлгээ	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний болзол
1.	100	4.0	А	Тухайн хичээлийн агуулгыг бүрэн бүтээлчээр ойлгож, мэдлэг эзэмшсэн, хичээлийн ухагдахуун ойлголтуудыг
2.	99			
3.	98			

4.	97	3.9	практик хэрэглээнд чадварлаг ашиглаж чадахыг харуулна.
5.	96		
6.	95	3.8	
7.	94		
8.	93		
9.	92		
10.	91		

- Судалгаанд хамрагдсан нийт сургуулийн 45,4 хувь нь суралцагчийн үнэлгээ бүлгийг сургуулийн хөтөлбөртөө тусгажээ.
- Хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг үнэлэх талаар төдийлөн тусгаагүй.
- Зарим их дээд сургуулиуд үнэлгээний шалгуур, үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг, үнэлгээний зохион байгуулалт, оюутны мэдлэг, чадварыг үнэлэхэд анхаарах зүйлс зэргийг багтаасан байна.

Цаашид А/174-т хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг үнэлэх талаар тодорхой тусгах шаардлагатай байна.

### 10. ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын чиглэлээр сургалтын хөтөлбөртөө тусгасан байдлыг тоймлон авч үзвэл:

Зураг 17. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалттай холбоотой судалгааны ажлууд



Их, дээд сургуулиудын 75.0 хувь нь сургалтын хөтөлбөрийн “Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт” хэсэгт чанарын үнэлгээний чиглэлээр судалгаа хийдэг байна. Магадлан итгэмжлэлд эрх зүйн зохицуулалтын дагуу бэлтгэнэ гэсэн заалт нийт сургуулийн 50 хувьд байна. Бусад үзүүлэлт тус бүр 8.3 хувийг эзэлжээ. Зарим их дээд сургуулиудын хувьд Сэтгэл ханамжийн үнэлгээ (оюутнууд, төгсөгчдөөс), Явцын үнэлгээ (оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ), Гүйцэтгэлийн үнэлгээ (Ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ, Үр нөлөөний үнэлгээ (Мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх), Хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ үнэлгээ, Хөтөлбөрийн чанарын үнэлгээ журам зэргийг Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг жагсаан бичсэн байх бөгөөд эдгээрийн дагуу хийх үйл ажиллагааг огт дурдаагүй байна. Иймд БСШУ-ны Сайдын А/174-тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д энэ чиглэлээр сургуулийн хийж буй

үйл ажиллагаа, судалгааны төлөвлөлт, явц , үр дүнг тусгах талаар тайлбарлан оруулах хэрэгтэй байна.

## **11. УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ**

Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагуудын ашиглаж байгаа Боловсролын удирдлага, мэдээллийн системүүд нь тухайн сургуулийн өөрийн онцлогтойгоор боловсруулагдсан байна. Боловсролын удирдлага, мэдээллийн системийн тусламжтайгаар:

*Оюутан:*

- Оюутан цахим картыг ашиглан шалгалтын дүн болон суралцах хугацаандаа судалсан бүх хичээлийн дүн, кредит болон ерөнхий голч дүнг харах
- Өөрийн хувийн мэдээлэл, төлбөрийн мэдээлэл зэргийг хянах боломжтой.
- Хичээл зааж байгаа багш нар:
- Заасан хичээлийн явцын үнэлгээг ums системд оруулах, сурлагын амжилт, чанарын үзүүлэлтийг авах боломжтой.

*Зөвлөх багш:*

- Ангийн оюутнуудын анкет ба бусад материалыг харах,
- Оюутнуудын судалсан хичээлүүдийн дүн, кредит, ерөнхий голч дүн зэрэг мэдээллийг харах

*Сургуулийн захиргаа, тухайлбал сургалтын алба, бүртгэл мэдээллийн алба, оюутны хөгжлийн алба:*

- Оюутны мэдээллийг харах, түүнийг ашиглан судалгаа хийх
- Оюутны дүнгийн болон суралцаж байгаа тухай тодорхойлолтыг гаргах
- Тухайн улиралд орох хичээлүүдийн хуваарь, заалгаж байгаа багшийг нь мэдэх
- Төгссөн оюутны диплом болон дипломын хавсралтыг бэлдэх ба хэвлэх
- Ерөнхий дүгнэлт хийх, шийдвэр гаргах
- Хичээл заасан багшийн тухай болон хичээлийн тухай судалгаа оюутнуудаас авах боломжтой.

*Санхүүгийн систем:*

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Daemonol программыг ашигладаг. Тус програмаар дамжуулан сургалтын төлбөр төлөлтийг хянах, санхүүгийн орлого зарлагын ангилал, үр дүнгийн мэдээллийг удирдлага авах боломжтой байдаг.

*Номын сангийн систем*

- Номын сангийн цогц програмыг ашигласнаар оюутан, багш, ажилтан, ажилчид хэрэгцээт номын каталогиос хайлт хийх, уншлагад байгаа эсэхийг үзэх, шинээр нэмэгдсэн ном сэтгүүлийн мэдээллийг авахын зэрэгцээ онлайн номын сангаар үйлчлүүлэх боломжтой.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 45.4 хувь нь сургалтын хөтөлбөртөө удирдлагын мэдээллийн системийн талаар тусгасан бөгөөд 24.0 хувь нь “Xcloud” удирдлага мэдээллийн нэгдсэн программ, MIS сургалтын нэгдсэн програм, Google дээр суурилсан Engrade программ, Google apps mail ШУТИС-ийн МХТС-иас гаргасан "Сургалтын удирдлагын системийн программ", Uniface5.0 системийн веб хувилбаруудыг тус тус ашиглаж байна. Эдгээр мэдээллийн нэгдсэн программууд нь дараах үндсэн хэсгүүдээс бүрддэг байна.

- Өгөгдлийн хэсэг
- Удирдлагын сайт

- Багшийн сайт
- Оюутны сайт
- Эцэг эхийн сайт

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 4.1 хувь нь Moodle.zokhiomj.mn мэдээллийн санг, 4.1 хувь нь санхүүгийн DAEMONOL программ, 12.3 хувь нь lib4u номын сангийн нэгдсэн программыг тус тус ашигладаг бол 8.2 хувь нь facebook хуудас нээн тус тус ашигладаг байна. Дээрх сургуулиуд өөрийн сургуулийн сургалтын онцлогт нийцүүлэн удирдлага, мэдээллийн системийн хөгжүүлэн тодорхой хэмжээнд үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлсэн байна. Жил бүр удирдлага, мэдээллийн системийн хөгжүүлэлтийг хийх зорилгоор тодорхой хэмжээнд төсөв хувиарладаг. Түүний дагуу систем дэх хөгжүүлэлтийг хийх, шинэ модуль нэвтрүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулдаг байна. Сургалтын бүхий л үе шатан дахь процессийг автоматжуулах, багш, оюутнуудын үйл ажиллагааг хөнгөвчлөх, ажиллахад хялбар, энгийн байх талаас нь сургууль тус бүр өөр, өөрийн онцлогт тохирсон системийг хөгжүүлж нэвтрүүлсэн байна.


- 58.4 хувь нь сургалтын хөтөлбөртөө энэ талаарх мэдээллийг тусгаагүй нь хөтөлбөрийн боловсруулалтын бүрэн бүтэн байдалтай холбоотой байна.
- Санхүүгийн систем болон Номын сангийн цогц програмын талаар дэлгэрэнгүй бичсэн сургууль цөөхөн байна.
- Нийт сургуулийн 73,9 хувь нь багш сургуулийн өмнөх боловсрол бакалаврын сургалтын хөтөлбөрийг 2014-2018 оны хооронд боловсруулсан боловч ихэнх сургуулийн хувьд удирдлагын мэдээллийн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн нэг болох удирдлагын мэдээллийн системийн талаар бичээгүй байна.

Цаашид боловсролын салбарын мэдээллийн системтэй холбогдож ажиллах ажлыг эрчимжүүлэх, улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сангаас цаг алдалгүй шуурхай мэдээлэл авах, сургалтын байгууллага болон БШУ-ны Яамны харьяа байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой тул удирдлага мэдээллийн системийг сургалтын үйл ажиллагаандаа яаралтай нэвтрүүлэх, сургалтын хөтөлбөрт тодорхой тусгах шаардлагатай.

## ***12. ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА***

Их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагууд, гадаадын их, дээд сургууль, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчид гэсэн үндсэн долоон чиглэлийн байгууллагуудтай харилцаа хамтын ажиллагаатай байна. Чиглэл тус бүрд хамаарах байгууллагын тоог зургаар харуулав (Зураг 18).

*Зураг 18. Харилцаа хамтын ажиллагаатай байгууллагын тоо, түүний эзлэх хувь*



Төрийн байгууллагууд-20.0 хувь, төрийн бус байгууллагууд-12.3 хувь, гадаадын их, дээд сургуулиуд-40.0 хувь, төрийн их, дээд сургуулиуд-9.2 хувь, олон улсын байгууллага-13.8 хувь, мэргэжлийн холбоод-3.07 хувь, ажил олгогч-1.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 25. Их, дээд сургуулиудын хамтын ажиллагаатай байгууллагууд

Ангилал	Хамтран ажилладаг байгууллага	Сургуулиудын тоо
Төрийн байгууллагууд	БСШУСЯ	2
	БМИҮЗ	1
	Засаг даргын тамгын газар	1
	Төрийн байгууллагууд	5
	Хүүхдийн төлөө хэлтэс	1
	Аймгийн нийгмийн хөгжлийн хэлтэс,	1
	Боловсрол соёл урлагийн газар	3
	Ерөнхий боловсролын сургуулиуд	5
	Политехник коллеж	1
	МСҮТөв	1
	Насан туршийн боловсролын газар	1
	Цагдаагийн байгууллага	1
	Онцгой байдлын хэлтэс	1
Дотоодын их дээд сургуулиуд	Төрийн их дээд сургуулиуд	3
	МУБИС	5
	Архангайн багшийн сургууль	2
	Гурван-Эрдэнэ	3
	Дорнод их сургууль	1
	Ховд их сургууль	1
Гадаадын их дээд сургуулиуд	ОХУ-ын Москвагийн их сургууль	1
	ОХУ-ын БГУЭП	1
	ОХУ-ын Томскийн их сургууль	1
	ОХУ-ын В.М.Шукшины нэрэмжит Алтайн боловсролын академи ОХУ-ын Барнаулын Алтай их сургууль	1
	ОХУ-ын Буриадын Их Сургууль	1
	ОХУ-ын Забайкальский Их Сургууль	1
	Литви улсын урлагийн академи	1
	ОХУ-ын Тувагийн улсын их сургууль	1

	БНХАУ-ын Харбины багшийн их сургууль	1
	БНХАУ-ын СИАС их сургууль	1
	БНХАУ-ын Өвөрмонголын Үндэстний их сургууль	1
	БНХАУ-ын Хайлаар Хөлөнбуйрын их сургууль	1
	АНУ-ын Колумбын коллеж	1
	АНУ-ын Миссисурри мужийн их сургууль	1
	АНУ-ын калифорний Баптист их сургууль	1
	Японы Хирошимагийн их сургууль	1
	Япон улсын Мейжи их сургууль	1
	Япон улсын Нагоя их сургууль	1
	Япон улсын Оберлин их сургууль	1
	Япон улсын Шова их сургууль	1
	Германы Грайфсвальдын их сургууль	1
	Берлиний Чөлөөт их сургууль	1
	ХБНГУ-ын улсын их сургууль	1
	БНСУ-ын Кимчеон их сургууль	1
	БНСУ-ын Кунгнам их сургууль	1
	БНСУ-ын Дэгү их сургууль	1
Төрийн бус байгууллагууд	Төрийн бус байгууллагууд	4
	Хүүхдийн төлөө үндэсний төв	1
	Хүний эрхийн үндэсний комисс	1
	Монголын залуучуудын холбоо	1
	Шангри-Ла Монгол	1
	Хас банк	1
	Хүйсийн тэгш эрхийн төв	1
	Гүнж төв	1
Олон улсын байгууллага	Ази номхон далайн их сургуулиудын холбоо	1
	Адра олон улсын байгууллага	1
	Солонгосын КОІСА Олон улсын байгууллага	1
	Дэлхийн зөн олон улсын байгууллаг	1
	Японы Хүүхдийг Ивээх Сан	2
	Дэлхийн байгаль хамгаалах сан	1
	Японы Жайка олон улсын байгууллага	2
	Картик-Чех	1
	Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ILO/	1
Мэргэжлийн холбоод	Мэргэжлийн холбоод	4
	Францын тахь хамгаалах холбоо	1
Ажил олгогчид		4

Дотоод, гадаадын хамтын үйл ажиллагааны хүрээг багцлан авч үзвэл:

*1. Гадаад, дотоодын ижил төрлийн хөтөлбөртэй их, дээд сургуулиудтай*

- Сургалт, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтран ажиллах,
- Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг сайжруулан боловсруулах
- Сургалтын хөтөлбөрийн туршлага судлах
- Сургалтын стандарт туршлага судлах
- Сургалтын төлөвлөгөөг харьцуулан судлах

- Хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх
  - Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах
  - Багш, оюутан солилцох
  - Багшийн мэргэжил дээшлүүлэх туршлага солилцох
2. *Ажил олгогч төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай*
- Ажил олгогчтой нартай хамтарсан сургалт семинар зохион байгуулах
  - Ажлын байрны үзэсгэлэн яармаг
  - Хэлэлцүүлэг
  - Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
  - Оюутны ажиглах дадлага
  - Туршин заах дадлага
  - Багшлах дадлага хийх дадлагын түшиц болгон хамтран ажилладаг байна.
  - Багшлах боловсон хүчин дутагдаж байгаа орон нутгийн удирдлага, боловсролын газартай хамтын гэрээ байгуулж ажиллах
  - Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг өргөжүүлэх
  - Ажилд зуучлах
3. *Олон улсын байгууллага, мэргэжлийн холбоодтой*
- Багшийн мэргэжил дээшлүүлэх
  - Туршлага солилцох
  - Багш нарын солилцох
  - Оюутан солилцох зэргээр хамтран ажилладаг талаар тусгажээ.

Дотоод, гадаад харилцаа, хамтын ажиллагааг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзэхэд ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаадын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах нь хамгийн их хувийг эзэлж байна. Энэ нь БСШУ-ны Сайдын А/174-тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” –д туссан хөтөлбөрийн агуулга нь дотоод гадаадын их дээд сургуулиуд ялангуяа нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй сургуулийн хөтөлбөртэй харьцуулах боломжтой байна гэсэн заалттай нийцэж байна. Харин төр, хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, ажил олгогчидтой хамтын ажиллагаа харьцангуй бага байна.

### *Дүгнэлт*

1. Их, дээд сургуулиудад хэрэгжих сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих системийг боловсронгуй болгохын тулд дэлхийн шилдэг их сургуулиудын жишгийн хүрээнд батлагдсан журмын дагуу тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, ерөнхий суурийн дэд хороо, хөтөлбөрийн ерөнхий хороод ажиллаж байна;
2. Зарим их сургуулийн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт сургалт явуулж ирсэн түүх, туршлага дэд бүлгийг шинээр оруулж бичсэн онцлогтой;
3. Хөтөлбөрийн үр дүн хэсгийг тусгай бүлэг болгон авч үзэн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг гаргаж, хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтуудын хоорондын уялдаа холбоог томъёолсон;
4. Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц, хичээл хоорондын холбоосыг харуулсан схемийг боловсруулсан;

5. Цөөн хэдэн сургууль сургалтын үйл ажиллагаанд ашигладаг аргуудаас нэрлэсэн, сургалтын явцад ямар үйл ажиллагаа явуулдаг талаар тайлбарласан байна. Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын 2.4.2 болон 2.4.3 дугаар заалтуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг бөгөөд ихэнх сургуулиуд дээрх заалтуудыг хуулж бичсэн байна.
6. Төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадварыг тодорхойлсон боловч түүнийгээ оюутны үнэлгээ, хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгах нь тодорхойгүй байна.
7. Цаашид Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн сайжруулан боловсруулах хэрэгтэй байна.

## 2.2. Бага боловсролын багш бэлтгэж буй гадаадын их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээний үр дүн

### Сургалтын хөтөлбөрийн нэршил

Хөтөлбөрийн нэршил нь тухайн мэргэжлээр суралцагчдын эзэмшвэл зохих мэргэжлийн чиглэл, агуулгыг бүрэн гаргасан байх учиртай. Судалгаанд хамрагдсан гадаадын их, дээд сургуул, коллежийн бага боловсролын багш бэлтгэдэг сургалтын хөтөлбөрийн нэршлийг авч үзэхэд “бага боловсролын багш” гэсэн агуулгыг бүрэн илэрхийлж байна.

Хүснэгт 26. Сургалтын хөтөлбөрийн нэршил

Улс	Сургалтын байгууллага	Сургалтын хөтөлбөрийн нэршил	Хэрэгжих хугацаа
Монгол	МУБИС, Багшийн сургууль	“Багш, бага боловсрол”	4 жил
Австрали	University of the Sunshine Coast	Bachelor of Primary Education	4 жил
	University of Newcastle	Bachelor of Education (Primary Studies)	4 жил
	Edith Cowan University	Bachelor of Education (Primary)	4 жил
	University of Tasmania	Bachelor of Education (Primary)	4 жил
АНУ	Montclair State University	Elementary teacher (Bachelor of Art)	4 жил
	George Mason University	Elementary Education, B.S.Eds.	4 жил
	Georgia State University	B.S.E. Elementary Education program (мэргэшүүлэх)	2 жил
	University of Virginia	Elementary Education: B.S.Ed. – Bachelor of Science in Education	4 жил
	University of Wisconsin-Madison	Elementary Education	4 жил
Англи	Oxford Brookes University	Primary Teacher Education	3 жил
Арабын Нэгдсэн Эмират улс	Qatar University	Bachelor of Education in Primary Education	4 жил
Ирланд	Dublin City University	Bachelor of Education (Primary Teaching)	4 жил
	Mary Immaculate College	Bachelor of Education (Primary Teaching)	4 жил
Канад	Онтарио Тех ИС	The Bachelor of Education Primary/Junior program	4 жил
	University of Victoria	Elementary Curriculum (Bachelor of Education)	4 жил
Шинэ Зеланд	University of Auckland	Bachelor of Education (Teaching)	3 жил
	University of Canterbury	Primary Teacher Education	
Финлянд	University of Turku	Degree Programme in Primary Teacher Education	4 жил
	University of Oulu	Primary Teacher Education (BA, Education)	
Норвег	Nord University	Primary and Lower Secondary Teacher Education	5 жил /магистр/
ОХУ	Московский государственный психолого-педагогический университет	Психология и педагогика начального образования (учитель начальных классов)	4 жил
Өмнөд Солонгос	Chungcheon National University of Education	Curriculum for elementary school teacher training at Chungcheon National University of Education	4 жил
Сингапур	Nanyang Technological University	Bachelor of arts (Education) (Primary) Bachelor of science (Education) (Primary)	4 жил
БНХАУ	“Зүүн хойд багшийн их	Бага боловсролын багш мэргэжлийн	3-6жил

	сургууль”	бакалаврын сургалтын хөтөлбөр	
Япон	Hiroshima University	Program in Elementary School Teacher Education	4 жил
Испани	Mondragon University	Degree Programme in Primary Teacher Education	4 жил
Ямайка	St. Joseph's Teachers' College	B. ED in Primary education	4 жил
Филиппин	University of Stella Salle	Bachelor of Elementary Education	4 жил
Малта	Institute for Education	Bachelor of Education (Primary)	4 жил

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 85.0 хувь 4 жилийн хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Зарим их сургуулийн хувьд дээд боловсролтой иргэн бага боловсролын багш болохоор мэргэшин суралцах тохиолдолд 2 жилийн хугацаанд суралцдаг бөгөөд нийт их сургуулиудын хувьд танхим, холимог хэлбэрээр сургалтыг зохион байгуулдаг байна.

## Сургалтын хөтөлбөрийн зорилго

*Хүснэгт 27. Сургалтын хөтөлбөрийн зорилго*

Улс орон	Бага боловсролын хөтөлбөрийн зорилго
Монгол, МУБИС, Багшийн сургууль	Ирээдүйд ажиллаж, амьдрах, эрдэм боловсролтой монгол иргэн төлөвшихөд бага боловсролын үйлчилгээ үзүүлэх, хувийн болон мэргэжлийн чадамж бүхий, бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадвартай, бүтээгч багш бэлтгэхэд чиглэнэ.
Австрали, University of Newcastle	Хөтөлбөр нь амжилттай багшлахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, зан чанарыг хөгжүүлэх зорилготой. Хөтөлбөр нь бага сургуулийнхаа чиглэлээр мэргэшсэн, мэдлэгтэй, үр дүнтэй ажиллах чадвартай, урам зоригтой багш төгсөгчдийг хөгжүүлэх зорилготой; сургалтын хөтөлбөр, бодлого, практикт оновчтой судалгаа хийх чадвартай, ухаалаг эрдэмтэд; боловсролын талаар болон түүнээс цааш олон нийтийн яриа хэлэлцээнд бүтээлч үүрэг гүйцэтгэх чадвартай, шинэлэг удирдагчдыг бэлтгэх зорилготой.
Австрали, Edith Cowan University	Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн тус хөтөлбөр нь бага боловсролын багш нарыг бэлтгэх зорилготой.
Англи, Oxford Brookes University	Бага ангийн багшийн боловсролын бакалаврын хөтөлбөр нь дадлагажигчдад хэрхэн үр дүнтэй багш болоход туслах зорилготой юм.
Ирланд, Dublin City University	Боловсролын бакалаврын хөтөлбөр нь таныг бага насны хүүхдүүдийн амьдралд эерэг, урт хугацааны нөлөө үзүүлэх бага ангийн багшийн үр өгөөжтэй ажилд бэлтгэнэ. Тус хөтөлбөрөөр суралцагчдыг зөвхөн агуулгын мэдлэгээр хангаад зогсохгүй тэдэнд хэрэгтэй манлайлах, харилцааны ур чадварыг эзэмшүүлнэ.
Канад, University of Victoria	Энэхүү бага боловсролын бакалаврын хөтөлбөр нь судлагдахууны мэдлэг, практик туршлагатай чадварлаг бага ангийн багш бэлтгэх зорилготой.
Шинэ Зеланд, University of Auckland	Багш бэлтгэх хөтөлбөрийн зорилго нь нотолгоонд суурилсан, үр дүнд чиглэсэн, судалгаанд суурилсан заах арга барилтай төгсөгчдийг хөгжүүлэх явдал юм. Төгсөгч багш нь идэвхтэй суралцахуйн арга барилаар хичээл заах, боловсролын ололт амжилтын ялгааг арилгахад чиглэсэн судалгаа шинжилгээ, судлагдахууны талаарх мэдлэг, сурган хүмүүжүүлэх ойлголт, зохих зан чанартай байх болно.
Финлянд, University of Turku	Хөтөлбөрийн зорилго нь: харилцааны, сурган хүмүүжүүлэх ур чадварын, оюуны болон ёс зүйн чадамжуудыг оюутнуудад төлөвшүүлэхэд оршино. 1. Харилцааны чадамж: Хамтран ажиллах, янз бүрийн нөхцөл байдалд харилцах чадвартай байх. 2. Сурган хүмүүжүүлэх чадамж: Сургалтын хөтөлбөрийн үндсийг мэддэг бөгөөд сургалтын үйл явц, сургалтын орчныг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэх чадвартай. 3. Оюуны чадамж: Боловсролын шинжлэх ухааны хувьд суурь мэдлэгтэй, шинжлэх ухаанч сэтгэлгээнд тулгуурлан өөрсдийн үйл ажиллагаа, мэргэжил дээшлүүлэх. Бага

	насны хүүхдийн нийгэм, соёлын үндэс суурь зарчмуудыг ойлгодог. 4. Ёс зүйн чадамж: Оюутнууд өөрсдийн үйлдлээ ёс зүйн үүднээс тодорхойлж, дүн шинжилгээ хийх, ёс зүйн зарчмын дагуу ажиллах чадвартай.
ОХУ, Московский государственный психолого- педагогический университет	“Ажил олгогчийн зүгээс тавих шаардлага”, “Багш (СӨБ-оос бүрэн дунд боловсролын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа)” мэргэжлийн стандартын шаардлагад нийцсэн чадамжтай мэргэжилтэнг чанартай бэлтгэх; дээд боловсрол эзэмшихээр суралцагсдад тэгш боломжийг олгох; суралцагчийг мэргэжлийн болоод бие хүний хувьд амжилттай байх чадамж, чанарыг хөгжүүлэх.
Өмнөд Солонгос улс, Chungcheon National University of Education	Оюутнуудад мэргэжлийн багш нарт шаардагдах зан чанар, тууштай байдал, ёс зүйг төлөвшүүлэх; Оюутнууд аливаа сэдвээр агуулгын гүнзгий мэдлэгийг эзэмшүүлж хөгжүүлэх; Оюутнуудын суралцагчийн сурах үйл ажиллагааг үр дүнтэй дэмжихэд шаардагдах сурган хүмүүжүүлэх ур чадварыг хөгжүүлэх; Оюутнуудын боловсролын үзэгдлийг судлах чадварыг хөгжүүлэх; Оюутнууд өөрчлөгдөж буй ертөнцөд үр дүнтэй дасан зохицохын тулд тэдний бүтээлч чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ, МХХТ-ийн чадамжийг хөгжүүлэхэд оршино.
Сингапур, Nanyang Technological University	Хөтөлбөрийн зорилго нь төгсөгчдийг боловсрол, боловсролтой холбоотой салбарууд болон бусад салбарт карьераа ахиулах цогц мэдлэг, эрэл хайгуулын чадвартай эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч болгоход оршино.
БНХАУ, Зүүн хойд багшийн их сургууль	Улс төрийн зөв чиг баримжаатай, эрхэмсэг ёс суртахууны шинж чанартай, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн сайн шинж чанартай, олон улсын үзэл бодолтой, боловсролын шинжлэх ухаан, мэргэжлийн салбарт шаардлагатай суурь мэдлэг, үндсэн онол, үндсэн ур чадвар, арга барилыг системтэй эзэмшсэн, шинийг санаачлагч, бизнес сэтгэлгээтэй байх. Мөн менежментийн чадвар, бүх түвшний боловсрол, удирдлагын янз бүрийн байгууллагуудад боловсрол, заах, менежмент, судалгааны чиглэлээр чадварлаг байх мэргэжилтнүүд бэлтгэх.
Япон, Hiroshima University	Хөтөлбөрийн зорилго нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан боловсролтой холбоотой зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ болон бусад асуудлыг судлах чадвартай бага ангийн багш нарыг хөгжүүлэх, мөн түүнчлэн тэдгээрт адил тэгш шаардлагатай чанар, чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ тусгай үйл ажиллагаа, анги удирдах, сурагчдыг чиглүүлэх зэрэгт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх туршлагатай бага ангийн багш бэлтгэхэд оршино.
Испани, Mondragon University	Хөтөлбөрийн зорилго нь сурагчдын боловсрол сургалтын хэрэгцээг урьдчилан таамаглах чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэхэд оршино. Хөтөлбөрийн үр дүнд: - Хүүхдийн гэр бүл, нийгэм, соёлын онцлогийг харгалзан үзэж, зохих ёсоор ханддаг, - Бодит байдлыг тайлбарлахын зэрэгцээ өөрчлөгдөн хувьсаж буй өнөөгийн нийгэмд дасан зохицох уян хатан, бүтээлч, тууштай, - Хүүхдийг танин мэдэх эмпати чадварыг хөгжүүлж, нээлт хийх, турших, шинэ мэдлэгээ хуваалцах, суралцах таатай орчинг бүрдүүлдэг мэргэжилтнүүд бэлтгэгдэн гарна.
Франц, University of Rouen Normandy	Төрөөс боловсруулсан удирдамжийн дагуу бага, дунд сургуулийн багш, ахлах боловсролын зөвлөхөөр ажиллах хүсэлтэй оюутнууд, түүнчлэн дадлагажигч багш, боловсролын ажилтнуудад зориулсан анхан шатны сургалтыг Аквитанийн бүсийн таван их сургууль болон сургуулийн системтэй хамтран зохион байгуулах

Хөтөлбөрийн зорилгыг авч үзвэл олон улсын ажил мэргэжлийн ангилалд заагдсан багш мэргэжлийн талаарх тодорхойлолтын агуулгыг бүрэн багтаасан гэж үзэж болохоор байна. Бага боловсрол мэргэжлийн онцлогийг тусгасан зөөлөн ур чадварууд (харилцааны, ёс зүйн гэх мэт) болон мэргэжлийн ур чадварууд, цаашид насан туршид шаардагдах нийгэмшихүйн хүрээний ерөнхий ур чадваруудыг тодорхойлж, хөтөлбөрийн зорилгыг гаргасан байна.

Түүнчлэн хөтөлбөрийн зорилго нь нэг талаас дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн хувь хүний болон мэргэжлийн хөгжил талаасаа, нөгөө талаас бага боловсролын суралцахуйн хүрэх үр дүнд баримжаалан бага ангийн сурагчийн хөгжлийг дэмжих чиглэлээр тодорхойлдог байна.

### Дадлагын хичээл

Судалгаанд хамрагдсан их сургуулиуд дадлагын хичээлийг дунджаар 3-4 хичээлийн жилд судалдаг. Багц цагийн хувьд 0-15 хүртэл хэлбэлзэж байгаа бөгөөд 5 сургуулийн хувьд багц цаг тооцдоггүй, 1-3 багц цагаар 9 сургууль, 4-9 багц цагаар 12 сургууль, 10-15 багц цагаар 9 сургуульд байна (Хүснэгт 28).

*Хүснэгт 28. Дадлагын хичээлийн төрөл, багц цаг, судлах улирал*

Хичээлийн нэр	Дадлагын хичээлийн агуулга	Багц цаг	Судлах улирал, жил	Улс орон, сургууль
<b>School Based Training 2</b>	Туршлагатай мэргэжилтэн, багш нартай танилцаж, сургалтын хөтөлбөрийн чиглэлийн талаар ойлголттой болно. Мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангахын тулд төлөвлөх, үнэлэх, зан үйлийн менежментийн талаар багшлахуйн стратеги, дадлага хийх ур чадвараа дээшлүүлнэ.	0	II	England, Oxford Brookes Univ
<b>Extending Professional Practice</b>	Мэргэжлийн мэдлэг, сурган хүмүүжүүлэх ур чадвар, үнэлгээний чадвараа хөгжүүлнэ. Сургалтын хүрээнд сайн зүйл хэрхэн ойлгох вэ?, сурагчдыг хэрхэн урамшуулж, сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх вэ?, таны мэргэжлийн тасралтгүй хөгжилд шүүмжлэлт сэтгэлгээ, зорилтыг хэрхэн тодорхойлох, хувийн болон бусдын сайн сайхан байдлыг хангахын тулд тэргүүлэх чиглэлээ хэрхэн тодорхойлох, ажлын ачааллаа зохицуулах зэрэг чадвартай болно.	15	II	England, Oxford Brookes Univ
<b>School Based Training 3</b>	Сургалтын үеэр багшлахуй, үнэлэх чадвараа хөгжүүлэхэд анхаарна. Багшийн зөвлөгч, их сургуулийн багш нараас заавар, дэмжлэг авна. Сургуулийн амьдралын хүрээнд илүү өргөн хүрээний чиг үүргээ хэрэгжүүлэх, чадвараа хөгжүүлэх урам зоригийг авна.	-	II	England, Oxford Brookes Univ
<b>Practice 1</b>	Багшийн үндсэн ажил, үүрэгтэй танилцах. Тухайлбал, багшийн хувийн шинж чанар, харилцааны ур чадварыг хөгжүүлэх, ангийн удирдлага, сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ.	0	I	Norway, Nord univ
<b>Practice 2</b>	Сурагчдын олон талт байдал, багшийн хувийн шинж чанар, харилцааны ур чадварыг хөгжүүлэх, дасан зохицсон заах, хэлбэржүүлэх үнэлгээ, олон соёлт ангийн багшийн ажил, сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний чадвартай болох. Сургууль нь бусад байгууллага болон бусад эрх бүхий байгууллага, хүмүүстэй хамтран ажилладаг.	0	II	Norway, Nord univ
<b>Practice 3</b>	Дадлагын удирдагч, багш нарын удирдлаган дор хамтран суралцагч нартайгаа хамт сургалтыг ажиглаж, төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлнэ. Оюутан багшлахдаа бие даан хариуцлага хүлээнэ. Багшлах дадлагыг хянаж, төрөлжүүлж, үнэлж, сурагчдын сургуулийн холбогдох хичээлийн хүрээнд ур чадвар, мэдлэг эзэмшсэн байдал, багшийн мэргэжлээр бэлтгэгдсэн байдлаа харуулна. Сургуулийн	0	III	Norway, Nord univ

	өмнө тулгамдаж буй мэргэжлийн, дидактик ба/эсвэл сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой сорилтод төвлөрөх, судалгаа гүйцэтгэх.			
<b>Practice 4</b>	Оюутан багшийнхаа дүр төрхийг төгс болгохын зэрэгцээ онол, судалгаанд тулгуурлан харилцаа холбоо, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшнэ. Багшлах дадлагыг хянаж, төрөлжүүлж, үнэлж, сурагчдын сургуулийн холбогдох хичээлийн хүрээнд ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэх, эзэмшсэн байдал, багшийн мэргэжилд бэлтгэхэд нь харуулна. Сургалтын менежмент, сурагчдын олон талт байдлын талаар гүнзгий ойлголттой болох, сайн харилцааг бий болгох, өөрчлөлт хийх чадварыг хөгжүүлэх явдал юм. Сургалтын орчин, сурагчид, эцэг эх, хамтран ажиллагсад болон бусад оролцогч талуудтай сайн харилцаатай байх.	0	IV	Norway, Nord univ
<b>Practicum in Elementary Education</b>	Зөвлөгч багшийн удирдлаган дор ажиглалт, шат дамжлагатай удирдлага, зааварчилгааны ажилд оролцдог.	3	IV	USA, George Mason univ
<b>Internship in Elementary Education</b>	Бага ангиудад ажиглалт хийх, хамтран ажиллах, хичээл заах шаардлагатай.	9	IV	USA, George Mason univ
<b>Practicum II</b>	Хүүхдийн хөгжил, судлагдахууны агуулга, сурган хүмүүжүүлэх арга зүй, хэл соёлын мэдрэмжтэй сургалт, анги танхимын менежменттэй холбоотой онолын талаарх мэдлэг, чадвараа сургалт, үнэлгээг төлөвлөхөд ашиглах, хүртээмжтэй, эерэг сургалтын орчныг бүрдүүлэхэд бэлтгэгдэнэ. Сургалтын хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнд нийцүүлж хичээлээ төлөвлөх, үнэлэх, боловсролын технологийн хэрэглээг оролцуулан суралцагчдын ойлголт, олон янз байдал, туршлагад суралцахыг утга учиртай болгоход суралцана.	3		USA, George State univ
<b>Practicum III</b>	Хүүхдийн хөгжил, судлагдахууны агуулга, сурган хүмүүжүүлэх арга зүй, хэл соёлын мэдрэмжтэй сургалт, анги танхимын менежменттэй холбоотой онолын талаарх мэдлэг, чадвараа сургалт, үнэлгээг төлөвлөхөд ашиглах, хүртээмжтэй, эерэг сургалтын орчныг бүрдүүлэхэд бэлтгэгдэнэ. Сургалтын хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнд нийцүүлж хичээлээ төлөвлөх, үнэлэх, боловсролын технологийн хэрэглээг оролцуулан суралцагчдын ойлголт, олон янз байдал, туршлагад суралцахыг утга учиртай болгоход суралцана.	3		USA, George State univ
<b>Student Teaching</b>	Сургалтын хөтөлбөрийн бүх чиглэлээр хөгжүүлэх, сургалтын хөтөлбөр, сургалтын зарчмуудыг нэгтгэхийг чухалчилдаг.	3-12		USA, George State univ
<b>Clinical Experience in Elementary Education</b>	Оюутнууд орон нутгийн сургуулийн бага ангид долоо хоногийн 3 өдөр зөвлөгч багшийн хамт ажилладаг. 8-р сарын дундаас эхэлж 11-р сарын сүүл хүртэл үргэлжилнэ.	6	IV	USA, Univ of Virginia
<b>Teaching Internship - Elementary</b>	Бага ангитай ажиллах бөгөөд 1-р сарын эхний долоо хоногоос 4-р сарыг дуустал өдөр бүр гэрээний дагуу хичээллэнэ.	12	IV	USA, Univ of Virginia
<b>Elementary Education Practicum II</b>	Жижиг бүлгүүдийг ажиглах, үнэлэх, хичээлийн төлөвлөгөө боловсруулах, математик, бичиг үсэг, хэл эзэмших, тэгш хамруулан сургах зэрэг сэдвээр цуврал хичээл заах.	0	II	USA, Univ of Wisconsin
<b>Elementary</b>	Жижиг бүлгүүдийг ажиглах, удирдан чиглүүлэх, хичээлийн	0	IV	USA, Univ

<b>teaching practicum III</b>	төлөвлөгөө боловсруулах, математик, урлагийн хичээлтэй суралцах онолтой холбоотой цуврал хичээл заах.			of Wisconsin
<b>Mana Ako: Practice Exploration 1</b>	Мана ако бол багшлах дадлага хийх судалгааны үйл явцаар бэлтгэлийн өмнөх багш нар хэрхэн заах талаар суралцаж буйг тайлбарлах арга юм. Өөрийгөө нээх, багшлахуйн мөн чанарыг ойлгох явцад багш нар хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, тууштай байх, сониуч зан, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэг. Суралцагчдыг ойлгох, тэдэнд хариу үйлдэл үзүүлэх, суралцахуйн дизайныг боловсруулах, суралцахад чиглэсэн соёлыг бий болгох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэдэг.	15		New Zealand, Univ of Canterbury
<b>Mana Ako: Practice Exploration 2</b>	Мана ако бол багшлах дадлага хийх судалгааны үйл явцаар бэлтгэлийн өмнөх багш нар хэрхэн заах талаар суралцаж буйг тайлбарлах арга юм. Өөрийгөө нээх, багшлахуйн мөн чанарыг ойлгох явцад багш нар хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, тууштай байх, сониуч зан, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэг. Суралцагчдыг ойлгох, тэдэнд хариу үйлдэл үзүүлэх, суралцахуйн дизайныг боловсруулах, суралцахад чиглэсэн соёлыг бий болгох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэдэг.	15		New Zealand, Univ of Canterbury
<b>Mana Ako: Practice Exploration 3</b>	Мана ако бол багшлах дадлага хийх судалгааны үйл явцаар бэлтгэлийн өмнөх багш нар хэрхэн заах талаар суралцаж буйг тайлбарлах арга юм. Өөрийгөө нээх, багшлахуйн мөн чанарыг ойлгох явцад багш нар хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, тууштай байх, сониуч зан, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэг. Суралцагчдыг ойлгох, тэдэнд хариу үйлдэл үзүүлэх, суралцахуйн дизайныг боловсруулах, суралцахад чиглэсэн соёлыг бий болгох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэдэг.	15		New Zealand, Univ of Canterbury
<b>Mana Ako: Primary Practice Exploration 4</b>	Мана ако бол багшлах дадлага хийх судалгааны үйл явцаар бэлтгэлийн өмнөх багш нар хэрхэн заах талаар суралцаж буйг тайлбарлах арга юм. Өөрийгөө нээх, багшлахуйн мөн чанарыг ойлгох явцад багш нар хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, тууштай байх, сониуч зан, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэг. Суралцагчдыг ойлгох, тэдэнд хариу үйлдэл үзүүлэх, суралцахуйн дизайныг боловсруулах, суралцахад чиглэсэн соёлыг бий болгох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэдэг.	15		New Zealand, Univ of Canterbury
<b>Mana Ako: Primary Practice Exploration 5</b>	Мана ако бол багшлах дадлага хийх судалгааны үйл явцаар бэлтгэлийн өмнөх багш нар хэрхэн заах талаар суралцаж буйг тайлбарлах арга юм. Өөрийгөө нээх, багшлахуйн мөн чанарыг ойлгох явцад багш нар хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, тууштай байх, сониуч зан, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлдэг. Суралцагчдыг ойлгох, тэдэнд хариу үйлдэл үзүүлэх, суралцахуйн дизайныг боловсруулах, суралцахад чиглэсэн соёлыг бий болгох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэдэг.	15		New Zealand, Univ of Canterbury
<b>Professional Placement 3</b>	Энэхүү сургалт нь оюутнуудад багшийн мэргэжлийн үүргийн талаарх мэдлэг, ойлголттой болох, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг ажиглах, багшлахуйг мэдрэх, сургуулийн орчинд зохион байгуулалттай төлөвлөлт, эргэцүүлэн бодох замаар цаашид хөгжих боломжийг олгоно. Энэхүү зуучлалын үеэр оюутнууд бага ангийн нярай/бага ангид сургалтын хөтөлбөр төлөвлөх, заах, үнэлэх ур чадварыг хөгжүүлж, зохих, хүртээмжтэй сурган хүмүүжүүлэх арга барилыг харуулсан хичээлүүдийг бэлтгэж, зааж, үнэлнэ.	5	I	Ireland, Dublin city univ

<b>Professional Placement 4</b>	Энэхүү модуль нь сурагчдад тусгай боловсролын орчинд багш нарыг ажиглаж, туслах, зохион байгуулалттай ажиглалт, эргэцүүлэн бодох, багшлах замаар тэгш хамруулах болон тусгай боловсролын талаарх ойлголтоо цаашид хөгжүүлэх боломжийг олгоно.	5	I	Ireland, Dublin city univ
<b>Professional Placement 5</b>	Энэхүү модуль нь оюутнуудад багшийн мэргэжлийн үүргийн талаарх мэдлэг, ойлголтоо сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг ажиглах, багшлахуйг мэдрэх, сургуулийн орчинд зохион байгуулалттай төлөвлөлт, заах, эргэцүүлэн бодох замаар цаашид хөгжүүлэх боломжийг олгоно. тусгах даалгаварт тусгана. Модуль нь мөн суралцагчдаас бүх хүүхдийн хэрэгцээ, сонирхол, давуу талыг харгалзан хувь хүний ялгааг хангахад онцгой анхаарал хандуулж, өөрсдийн хүртээмжтэй туршлагынхаа талаар эргэцүүлэн бодох, авьяаслаг, шинээр ирж буй сурагчид, соёлын олон талт байдлыг ойлгох.	5	I	Ireland, Dublin city univ
<b>Professional Placement 6</b>	Энэхүү модуль нь оюутнуудад бага сургуулийн аль ч ангид төлөвлөлт хийх, багшлах, дасан зохицох чадвараа хөгжүүлэх өргөн хүрээний мэргэжлийн туршлага олж авах боломжийг олгоно.	10	I	Ireland, Dublin city univ
<b>Professional Placement 7</b>	Энэхүү модуль нь оюутнуудад бага сургуулийн аль ч ангид төлөвлөлт хийх, багшлах, дасан зохицох чадвараа хөгжүүлэх өргөн хүрээний мэргэжлийн туршлага олж авах боломжийг олгоно.	10	I	Ireland, Dublin city univ
<b>Professional Experience 1</b>	Анхны Мэргэжлийн Туршлага зуучлал (PE1) нь бэлтгэл сургуулилт хийх багш нарт сургуулийн нөхцөл байдлын талаарх ойлголт дээрээ тулгуурлан заах тухай онолын ойлголтоо практикт хэрэгжүүлж эхлэх боломжийг олгодог.	0	II	Australia, Univ of Tasman
<b>Professional Experience 3 - 5 years</b>	Боловсролын чиглэлээр төгсөлтийн гэрчилгээ олгох (бага насны хүүхэд) сургалтын мэргэжлийн туршлага нь төгсөгчдөд хүүхэд асрах, боловсрол, цэцэрлэгт (эсвэл түүнтэй адилтгах) дадлага туршлагаа харуулах боломжийг олгох зорилготой юм.	0	IV	Australia, Univ of Tasman
<b>Bachelor's Level School Experience</b>	Оюутнууд сургууль, анги хамт олны дунд бусад сурагчид болон хяналтын багш нартай хамтран ажиллана. Оюутанд сургалтын үндсэн ур чадвар, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгэх чиглэлээр дадлагажуулна.	5	II	Finland, Univ of Oulu
<b>Field study1</b>	Агуулга, арга зүйн хичээлээр сурч мэдсэн боловсролын онолыг хэрэглэхэд чиглэсэн сургалтыг шууд ажиглаж, ирээдүйн багшийг анги танхим, сургалтын орчны бодит байдалтай шууд танилцуулахад анхны туршилт хичээл юм. Сурагчдын зан байдал, мотиваци, багшийн заах арга зүй, анги танхимын зохион байгуулалт, сурлагын үнэлгээ болон бусад зүйлст онцгой ач холбогдол өгнө. Энэ хичээлээр бүтээлийн сан заавал гарсан байх ёстой.	3	IV	Philippine, standard
<b>Field study2</b>	Сургууль суурилсан дадлага бөгөөд сурлагын үнэлгээ хийх, сургалтын материал бэлтгэх, мэдээллийн самбар бэлтгэх гэх мэт анги танхим дахь бусад үйл ажиллагаатай холбоотой сургалтын үйл явцад оролцох боломжийг оюутанд олгоно. Жишиг хичээл, хичээлийн төлөвлөгөө, дор хаяж нэг хичээл буюу сэдвийг заасан байх зэргээр бүтээлийн сан бүрдүүлэхийг шаардана. Мөн дадлагын явцад гүйцэтгэлийн судалгаа хийж, дүгнэлт гаргасан байхыг дэмжинэ.	3	IV	Philippine, standard
<b>Teaching internship</b>	Хамтран ажиллаж буй багшийн удирдлага дор суурь боловсролын сургуульд нэг улирлын турш бүтэн цагаар багшлах дадлага хийхийг хэлж байна. Багшлах дадлагыг	6	IV	Philippine, standard

	кампус дотор эсвэл кампусаас гадна хийж болно. Бусад академик хичээлийг зэрэгцэж үзэхгүй. Багшлах үеийн бүтээлсийн сан болон судалгааны үр дүнг шаардана.			
<b>School Experience</b>	Долоо, долоо хоногоор бага болон дунд сургуульд хийнэ.	0	I	Singapore, NTU
<b>Teaching Assistantship</b>	Хичээлд ажиглалт хийх, хичээл төлөвлөх, хэрэглэгдэхүүн бэлтгэх, сурагчдыг зохицуулах, хичээл заахад туслах.	3	II	Singapore, NTU
<b>Teaching Practice 1</b>	2 долоо хоног хичээл ажигласны дараа, бие даан хичээл заах, хичээлээ төлөвлөх, дагалдуулж буй багш болон их сургуулийн багштайгаа зөвлөлдөх.	5	III	Singapore, NTU
<b>Teaching Practice 2</b>	Бие даан хичээл заах, багшийн ажлын туршлага судлах	10	IV	Singapore, NTU
<b>Professional Experience 1</b>	Мэргэжлийн дадлага хийх хугацаанд оюутнууд багшийн удирдлаган дор мэргэжил дээшлүүлэх үйл явцад оролцож, онол практикийн хооронд сайн мэдээлэлтэй холбоо тогтоох боломжтой байдаг.	15	I	Australia, Edith Cowan univ
<b>Professional Experience 2</b>	Мэргэжлийн дадлага хийх хугацаанд оюутнууд багшийн удирдлаган дор мэргэжил дээшлүүлэх үйл явцад оролцож, онол практикийн хооронд сайн мэдээлэлтэй холбоо тогтоох боломжтой байдаг.	15	II	Australia, Edith Cowan univ
<b>Professional Experience 3</b>	Мэргэжлийн дадлага хийх хугацаанд оюутнууд багшийн удирдлаган дор мэргэжил дээшлүүлэх үйл явцад оролцож, онол практикийн хооронд сайн мэдээлэлтэй холбоо тогтоох боломжтой байдаг.	15	III	Australia, Edith Cowan univ
<b>Professional Experience 4 - Assistant Teacher Program</b>	Мэргэжлийн дадлага хийх хугацаанд оюутнууд багшийн удирдлаган дор мэргэжил дээшлүүлэх үйл явцад оролцож, онол практикийн хооронд сайн мэдээлэлтэй холбоо тогтоох боломжтой байдаг.	30	IV	Australia, Edith Cowan univ
<b>Practicum I</b>	Ангийн менежментийн үндсэн элементүүд, багшийн оролцоо, сургуулийн багшийн мэргэжлийн онцлогийг тодорхойлох, таних, шинжлэх, зурах, нөхцөл байдлын болон дидактик харилцан үйлчлэлийн үндсэн шинж чанаруудыг ойлгоно. Багшийн мэргэжилд тууштай хандах ёстойг ойлгоно.	4		Spain, Mondragon univ
<b>Practicum II</b>	Хувь хүний болон бусад чадварыг үнэлэх, дүн шинжилгээ хийх, нөөц, арга хэрэгсэл, стратегийг мэдэж ашигладаг болох, сургуулийн дадлага өөрийн дадлагад хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийх. Багшийн мэргэжлийн хэрэгцээг тодорхой нөхцөл байдалд тодорхойлж, өөрийгөө ойлгодог болох.	6		Spain, Mondragon univ
<b>Practicum III</b>	Хувийн болон мэргэжлийн үйл явцын талаар мэдлэгтэй болох, өөрийн үйл ажиллагааны сул болон давуу талуудыг мэдэх, шинжлэх, тайлбарлах. Сургалтын үйл явцад хяналт тавьж, үндсэн арга техник, стратегийг сургалтын үйл явцад хэрэгжүүлнэ. Багшлах үйл ажиллагаанд оролцож, хэрхэн гүйцэтгэх, жүжиглэх, эргэцүүлэн бодох чадварт суралцах. Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдалд хяналт тавих хэрэгсэл, стратеги, нөөцийг боловсруулж хэрэглэх.	8		Spain, Mondragon univ
<b>Practicum IV</b>	Хувийн болон мэргэжлийн үйл явцын талаар мэдлэгтэй болох, өөрийн үйл ажиллагааны сул болон давуу талуудыг мэдэх, шинжлэх, тайлбарлах. Сургалтын үйл явцад хяналт тавьж, үндсэн арга техник, стратегийг сургалтын үйл явцад хэрэгжүүлнэ. Багшлах үйл ажиллагаанд оролцож, хэрхэн гүйцэтгэх, жүжиглэх, эргэцүүлэн бодох чадварт суралцах. Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдалд хяналт тавих хэрэгсэл, стратеги, нөөцийг боловсруулж хэрэглэх.	6		Spain, Mondragon univ

<b>Professional experience: The role of teacher</b>	Австралийн багш нарын мэргэжлийн стандарттай танилцах, сургуулийн нийгэмд үр дүнтэй оролцох боломжийг танд олгох харилцааны ур чадвар, стратегитай танилцана.	12	I	Australia, univ of Sunshine
<b>Professional Experience: Connecting with Learning and Teaching</b>	Бага ангийн хүүхдийн хөгжил, хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх туршлагатай болно. Австралийн багшийн мэргэжлийн стандартын талаар мэддэг болно.	12	I	Australia, univ of Sunshine
<b>Professional Experience: Facilitating the Learning Environment</b>	Бага ангид үр дүнтэй багшлах, суралцахад нь дэмжлэг үзүүлэх ангийн менежментийн талаар мэдлэгээ хэрэгжүүлнэ. Янз бүрийн хэрэгцээтэй суралцагчдын зан үйлийг удирдан чиглүүлэх арга барилд суралцана.	12	II	Australia, univ of Sunshine
<b>Professional Experience: Differentiate d Practice</b>	Тэгш байдал, хүртээмжтэй боловсролын үзэл хандлагад суурилан сургалтанд хэрэгжүүлэхэд анхаарна. Үүнд, тусгай хэрэгцээт, гоц авьяастай хүүхэд болон бусад хүүхдүүдийн сурах хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон “Ялгаатай сургалтын хөтөлбөр”-ийн үзэл баримтлалыг ойлгоно.	12	III	Australia, univ of Sunshine
<b>Professional Experience: The Professional Teacher</b>	Багшийн мэргэжлийн стандартын шаардлагыг хангахуйц ур чадвартай болоход анхаарна. Мэргэжлийн мэдлэг, туршлага, сурган хүмүүжүүлэх арга барилаа сайжруулах боломжийг олгоно.	12	IV	Australia, univ of Sunshine
<b>Производственная практика</b>	Бага боловсрол олгодог сургалтын байгууллагад бага ангийн багш болж бие даан ажиллах мэргэжлийн чадамжтай болно.		III	OXY, МГППУ
<b>Стажёрская практика</b>	Төгсөлтийн судалгааны ажлын сэдвийн дагуу сургалтын үйл ажиллагаанд туршилт судалгаа явуулснаар сургалтын явцад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх туршлагатай болно.		IV	OXY, МГППУ
<b>Преддипломная практика</b>	Төгсөлтийн судалгаа шиг төсөлт ажлын хүрээнд мэргэжлийн зорилго, зорилтыг шийдвэрлэхтэй холбоотой мэргэжлийн чадамжийг бэхжүүлнэ.		IV	OXY, МГППУ
<b>Teaching Practice II</b>	6 долоо хоногийн туршид үргэлжлэх багшлах дадлага юм.	10	I	Malta, The institute of Ed
<b>Internship in Industry</b>	Мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх, ажиглалт, эргэцүүлэн бодох чадвар, чадамжийг хөгжүүлнэ. 2 долоо хоногийн турш үргэлжилнэ.	6	II	Malta, The institute of Ed
<b>Teaching Practice III</b>	6 долоо хоногийн туршид үргэлжлэх багшлах дадлага.	10	II	Malta, The institute of Ed

Бага боловсролын багш бэлтгэж буй сургуулиудын дадлагын хичээлийн зорилго, хүрэх үр дүнгийн хувьд сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, ангийн менежментийг оновчтой зохион байгуулах, тэгш хамруулах боловсролын (тусгай хэрэгцээт, гоц авьяастай суралцагч, цаашлаад суралцагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн) үзэл санааг хэрэгжүүлэх чадвартай болоход чиглэгдэж байна. Дадлагын хичээлийг судлах хичээлийн улирлын хувьд 1, 2-р дадлага хичээлийн зорилго нь сургалтын хөтөлбөр, багшлахуй, ангийн менежментийн талаарх ойлголттой болох, анхан шатны практик мэдлэг, чадвартай болоход чиглэж байгаа бол 3, 4-р дадлагын хичээлийн зорилго нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төлөвлөх, үнэлэх, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, суралцахуйн дизайныг боловсруулах, хэл, соёлын болон бусад олон ялгаатай талыг ойлгох, ангийн менежментийг оновчтой зохион байгуулах, сургууль болон бусад байгууллага, хувь

хүмүүстэй үр дүнтэй хамтран ажиллах зэрэг мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаандаа хэрэглэхэд чиглэж байна.


## Сургалтын төлөвлөгөө

Судалгаанд сонгогдсон их сургуулиудын бага боловсролын багш бэлтгэж буй сургалтын төлөвлөгөөг харьцуулахдаа хичээлийн бүлэг, заавал, сонгон судлах, багц цаг, судлах улирал гэсэн үзүүлэлтээр судалгааны мэдээлэл цуглуулав.

Хүснэгт 29 Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн бүлэг, тоо


№	Ангилал	New Zealand	England	Arab	Slovenia	USA						Norway	Ireland	Canada	Australia			Finland	Philippines	Singapore	Jamaica	Philippines	Spain	Korea	Japan	Russia	Malta	Нийт судлагдахууны тоо			
		Окляндын ИС	University of Canterbury	Oxford Brookes University	Qatar University	University of Ljubljana	Montclair State University	George Mason University	Georgia State University	University of Virginia	University of Wisconsin-Madison	Nord University	Dublin City university	Mary Immaculate college	University of Victoria	University of Tasmania	Edith Cowan University	University of Newcastle	University of the Sunshine Coast	University of Oulu	Turku university	University of St.La Salle	Nanyang Technological University	St. Joseph's Teachers' College	Commission on Higher Education	Mandragon University	Chung Cheong University		Hiroshima University	Московский психолого-педагогический госуниверситет	The Institute for Education
1	Боловсрол судлал	9	10	6	9	11	6	5	4	3	1	9	14	15	13	8	7	4	5	7	12	14	9	12	16	9	12	14	7	17	268
2	Тэгш хамруулах боловсрол	2	1	1	1	1	0	2	3	1	1	1	1	2	1	3	6	1	2	2	1	1	1	1	4	2	1	1	1	1	46
3	Сэтгэл судлал	0	0	1	3	2	0	0	2	3	2	0	0	1	0	1	1	1	2	1	1	2	1	4	1	1	2	2	2	0	36
4	Эх хэл	2	3	1	6	7	2	6	3	2	1	2	11	9	1	3	7	4	5	3	5	5	8	8	8	3	3	2	2	2	124
5	Математик	3	1	3	2	3	2	2	5	1	7	4	4	1	8	2	7	3	4	1	2	3	6	8	2	0	2	3	1	4	94
6	Байгалийн ухаан	2	2	2	4	6	4	3	3	4	28	0	2	1	3	2	4	2	6	2	3	4	5	5	2	1	4	3	1	4	112
7	Нийгмийн ухаан	3	1	1	2	5	3	4	1	1	8	0	2	8	3	2	9	4	2	3	2	13	6	3	2	2	16	4	1	5	116
8	МХХТ	1	0	0	0	1	0	1	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	2	1	2	1	2	2	5	0	0	1	21
9	Гадаад хэл	0	0	2	0	0	0	0	0	0	1	0	0	0	2	1	1	0	0	4	3	1	1	0	0	4	6	3	3	1	33
10	Хөгжим	0	0	0	0	4	0	0	0	0	0	0	0	0	2	0	3	0	0	0	2	1	6	1	1	0	4	1	0	0	25
11	Дүрслэх урлаг, технологи	1	1	2	1	3	0	2	0	1	1	0	4	3	2	2	6	2	2	6	3	3	4	1	1	0	3	1	2	0	57
12	Эрүүл мэнд, биеийн тамир	2	0	0	0	3	0	0	0	0	0	0	0	0	2	0	0	2	0	0	2	5	0	0	2	3	2	1	0	2	26
13	Дадлага	3	5	3	1	1	0	2	4	2	4	6	6	7	3	5	4	0	5	1	0	3	4	4	1	4	4	3	3	5	93
14	Дипломын ажил	0	0	1	0	0	0	0	0	0	0	1	0	1	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	1	0	1	0	7
15	Эрүүл мэнд	0	0		1	0	0	0	0	0		1	0	0	2	2	0	2	0	0	0	0	1	0	0	3	1	1	0	14	
16	STEM	0	0					1	0	0		0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	2	0	0	0	1	5	

Зураг 19. Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн тоо (хичээлийн бүлгээр)



Зураг 19-өөс харахад хөтөлбөр хэрэгжүүлэгч их сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны хичээл – 23.5 хувь (268 хичээл), эх хэл – 11.0 хувь (124 хичээл), нийгмийн ухаан – 10.0 хувь (116 хичээл), байгалийн ухаан – 10.0 хувь (112 хичээл), математик – 8.0 хувь (94 хичээл), дадлага – 8.0 хувь (93 хичээл), дүрслэх урлаг, технологи – 5.0 хувь (62 хичээл), тэгш хамруулах боловсрол – 4.0 хувь (46 хичээл), сэтгэл судлал – 3.0 хувь (36 хичээл), гадаад хэл – 3.0 хувь (33 хичээл), эрүүл мэнд, биеийн тамир – 2.0 хувь (26 хичээл), хөгжим – 2.0 хувь (25 хичээл), МХХТ – 1.8 хувь (21 хичээл), эрүүл мэнд – 1.2 хувь (14 хичээл), дипломын ажил – 0.6 хувь (7 хичээл), Stem – 0.4 хувь (5 хичээл) тус тус эзэлж байна (Хавсралт 1). Сургууль тус бүрийн сургалтын төлөвлөгөөнд хичээлийн бүлэг тус бүрийн эзлэх хувийн дундаж утгыг авч үзэхэд боловсрол судлал, сурган, эх хэл, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дадлага, математикийн чиглэлийн хичээлүүд зонхилох хувийг (9.0-26.0) эзэлж байна.

Зураг 20. Сургалтын төлөвлөгөө тус бүр дэх хичээлийн бүлгийн эзлэх хувь (дундаж)



Зураг 20-оос харахад сургалтын төлөвлөгөө тус бүр дэх хичээлийн бүлэгт эзлэх хувиар боловсрол судлал хамгийн өндөр хувьтай байгаа бөгөөд бага боловсролын суралцагчдын нийгэмших, сэтгэл зүйн болон суралцах хэв шинжийн онцлогоос хамаарч судлагдахуун бүрээр эзлэх хувь харилцан адилгүй байна.

### Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs-Program Learning Outcomes)

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн талаар товч авч үзье. Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн сургууль төгсөх үедээ эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалтыг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн гэнэ. Өөрөөр хэлбэл оюутан төгсөх үедээ юу мэддэг, юуг хийж чаддаг, ямар хандлага төлөвшилтэй болсон байхыг илэрхийлэх үр дүнгийн жагсаалт гэж хэлж болно. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалаар суралцахуйн үр дүнгүүдийг өөр өөр түвшинд дараах байдлаар тодорхойлдог<sup>2</sup>. Үүнд:

- Тухайн дээд боловсролын байгууллагын сургалтын чиглэлээр баримтлах урт хугацааны бодлого талаас нь тодорхойлох (Алсын хараа, эрхэм зорилго)

<sup>2</sup> Хөтөлбөрийн боловсролыг зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж, 2017

- Хөтөлбөрөөр суралцаж төгссөн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар, хандлагын түвшин талаас нь тодорхойлох (Хөтөлбөрийн боловсролын зорилт (PEOs-Program Educational Objectives))
- Хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутны сургалтын нийт хугацаанд эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага талаас нь тодорхойлох (Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs-Program Learning Outcomes))
- Хөтөлбөрт хамаарах хичээлүүдээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага талаас нь тодорхойлох (Хичээлийн суралцахуйн үр дүн (CLOs-Course Learning Outcomes)) зэрэг юм.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLOs-Program Learning Outcomes) талаас нь авч үзвэл суралцагчид зөвхөн мэдлэг эзэмших бус мэдлэгээ хэрэглэх ур чадвартай болгох үүднээс суралцахуйн үр дүнд практик ур чадвараас гадна хувь хүний болон харилцааны ур чадвар, хандлагыг багтаасан байдаг. Ингэснээр цогц чадамж буюу суралцахуйн үр дүнгийн хувьд нийлмэл шинж чанарыг агуулж чадна<sup>3</sup>.

Сургалтын хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтуудыг хангахын тулд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд буюу хөтөлбөрөөр оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг оновчтой тодорхойлсон байх ёстой. Суралцагч суралцахуйн үр дүнг ямар түвшинд эзэмшиж байгааг сургалтын явцад болон төгсгөлд заавал үнэлэх нь зүйтэй. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох, хянан судлах ба шинэчилэн сайжруулах үйл явц дараах байдлаар явагдаж байна. Үүнд:

#### **Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлохдоо:**

- Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тухайн салбарын мэргэжилтний хэрэгцээ, шаардлага, тэдний эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох
- Их сургуулийн урт хугацааны бодлого, төлөвлөлт, хөгжлийн бодлоготой уялдуулан хөтөлбөрийн боловсролын зорилго зорилтуудын тодорхойлж тэдгээртэй хамааралтайгаар суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлохоос эхэлнэ.

#### **Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг хянан судлахдаа:**

- Ажил олгогчид, төгсөгчид, төгсөх оюутнууд болон багшлах бүрэлдэхүүнээс санал асуулга авах замаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд хэр чухал ач холбогдолтой болох, төгсөгчид суралцахуйн үр дүнгүүдийг хэр түвшинд эзэмшиж байгаа болохыг тодорхойлж үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах.
- Хичээл бүрээр оюутны эзэмшиж байгаа суралцахуйн үр дүнгүүдэд улирал бүр дүн шинжилгээ хийдэг.

#### **Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг шинэчилэн сайжруулахдаа:**

- Санал асуулгын үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийн гүйцэтгэлийг хянан судалсны дараа хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдэд хэрхэн сайжруулалт хийхийг тодорхойлж хэрэгжүүлдэг<sup>4</sup>.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан гадаадын их, дээд сургуулиудын жишгээр тодорхойлохоос гадна гадаад, дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлттэй нийцүүлэх хэрэгцээ үүсдэг. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-

<sup>3</sup> Н.Эрдэнэхүү, Д.Түмэнболд, Д.Ариунболор “Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөрт үнэлгээ хийх жишиг арга зүй”, 2019он

<sup>4</sup> Цахилгаан холбоо хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэлийн тайлан

ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагыг баталсан<sup>5</sup>. Тус шалгуур, шаардлагын 1-р шалгуурын Хөтөлбөрийн зорилго хэсэг нь PEOs-той холбоотой. Энэ хэсэгт дараах шалгуур, үзүүлэлт, нотолгоог зааж өгсөн байна (Хүснэгт 30).

*Хүснэгт 30. БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуурын 1.2. дахь шалгуур*

<b>Шалгуур</b>	<b>Задлан шинжлэх асуулт</b>	<b>Нотолгоо</b>
Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилгод судалгаа хийсэн үү?</li> <li>- Хөтөлбөрийн зорилго байгууллагын эрхэм зорилго, зорилттой нийцсэн үү?</li> <li>- Хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг оролцогч талуудын саналыг тусгаж, тодорхойлдог уу?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар</li> <li>- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг</li> <li>- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал</li> </ul>

Аль ч дээд боловсролын сургалтын байгууллага хөтөлбөрийн шинэчлэл хийж PEOs, PLOs тодорхойлохдоо дээр үзүүлсэн шалгуурт нийцүүлэн холбогдох нотолгоог бэлтгэдэг.

АНУ, ОХУ, Канад, Япон, Солонгос, Европын холбоо зэрэг дээд боловсролоор тэргүүлэгч бүх улс орнуудын боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагын шалгуур үзүүлэлтүүд ижил байдлаар тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд чиглэсэн байна. Сүүлийн жилүүдэд Монгол улс дээд боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлж олон улсын түвшинд хүргэх зорилгоор олон улсын боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагуудаар сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх ажлыг эрчимтэй хийж байна. Эдгээр байгууллагуудын шалгуур, шаардлагад PEOs -ийг хэрхэн тодорхойлсон хэрхэн сайжруулдаг талаар нотлох баримтууд шаардсан байдаг. Жишээ болгон Montessori Accreditation Council for Teacher Education (MACTE) - Багшийн боловсролын Монтессори магадлан итгэмжлэлийн зөвлөл(MACTE)-ийн шалгуурыг авч үзье<sup>6</sup>.

<sup>5</sup> <http://mncea.edu.mn/>

<sup>6</sup> Үр дүнд суурилсан боловсрол ([obe.edu.mn](http://obe.edu.mn)) Сургалтын хөтөлбөрт тавигдах үндсэн шаардлага

1.1 Write a brief history and state the goals of the program.

**Mission Statement**

The educational goals of the program are clearly stated; educational objectives and outcomes are specified, reasonable, and consistent with the mission.

1.2 Write the program’s mission statement.


1.3 Describe the distinguishing characteristics of the program.

1.4 Write a summary of the process of developing the *Self-Study*. Items to be addressed: How did your program go about completing the writing process? Who was involved? Was the process collaborative? If a consultant was used during the preparation of the *Self-Study*, explain the consultant's role in the process. What are the plans for changes in your program as a result of writing the *Self-Study*?

МАСТЕ байгууллагаас гаргасан шалгуурт хөтөлбөрийн зорилго тодорхой байх, боловсролын зорилт, үр дүнгүүдийг тодорхойлсон байх, хөтөлбөрийн боловсролын зорилт (PEOs-Program Educational Objectives) нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн байх хэмээн тусгажээ. Эдгээр шалгуурт байгаа үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байвал сургалтын хөтөлбөрийн боловсролын зорилт (PEOs) болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLOs) зөв тодорхойлж хэрэгжүүлсэн гэж үзэж болно. Жишээ болгон МУБИС-ийн Багшийн сургуулийн хэрэгжүүлж буй “Багш, бага боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдэд дүн шинжилгээ хийхийг зорьсон боловч хэмжигдэхүйц бус байдлаар тодорхойлогдсон агуулгын хувьд давхардал их байв.


Гадаадын 10 улсын бага ангийн багш бэлтгэж буй 31 их, дээд сургууль, коллежийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдэд (PLO) T-LAB20207 програм (контент анализ, семантик дүн шинжилгээ, сэдэвчилсэн дүн шинжилгээ, кластер анализ, текст боловсруулах, ухагдахууны зураглал, дискурсийн дүн шинжилгээ хийх, хэл шинжлэл, статистик шинжилгээ хийх боломжтой программ хангамж) ашиглан шинжилгээ хийлээ (Хүснэгт 31).

Зураг 21. Үгсийн талбай



Зураг 21 -т үзүүлсэн үгсийн талбай нь тухайн үгсийн давтамжийн хэмжээг илэрхийлнэ. Эдгээр үгс нь Багш, бага боловсролын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдэд хамгийн өргөн ашиглагдаж байгаа үгсийг харуулж байна. Мөн learning, student, knowledge, demonstrate, skill, professional, plan, instruction, teacher, teaching, practice, education, candidate, learner, understanding, appropriate, development, apply, assessment, community, child .... гэсэн үгс өндөр давталттай байна.

Зураг 22. “Student” гэсэн үгийн хамаарал



Зураг 22 -т буй тасархай зураас нь дам, шулуун зураас нь шууд хамааралтай байгааг харуулна.

Хүснэгт 31. Үгсийн давтамж

Д/д	ITEM (N=216)	Давтамж	Д/д	ITEM (N=216)	Давтамж	Д/д	ITEM (N=216)	Давтамж
1.	Learning	69	18.	Apply	21	35.	Evaluate	13
2.	Student	60	19.	Assessment	21	36.	Know	13
3.	Knowledge	39	20.	Community	21	37.	Instructional	13
4.	Demonstrate	39	21.	Child	20	38.	Understand	13
5.	Skill	34	22.	Social	20	39.	Strategy	13
6.	Professional	32	23.	Curriculum	19	40.	Promote	13
7.	Plan	28	24.	Content	19	41.	Science	12
8.	Instruction	28	25.	Environment	19	42.	Support	12
9.	Teacher	26	26.	Diverse	18	43.	Family	12
10.	Teaching	25	27.	Develop	16	44.	Implement	12
11.	Practice	25	28.	Communication	15	45.	Individual	12
12.	Education	25	29.	Area	15	46.	Discipline	12
13.	Candidate	24	30.	Need	15	47.	Elementary	11
14.	Learner	24	31.	Technology	14	48.	Cultural	11
15.	Understanding	24	32.	Create	14	49.	Classroom	11
16.	Appropriate	23	33.	Educational	13	50.	Teach	11
17.	Development	22	34.	Effective	13	51.	Variety	11

Судалгаанд хамрагдсан их сургуулиудын хөтөлбөрийн хүрэх үр дүнг (PLOs) томъёолоход ашигласан үгийн давтамжаас харахад *learning, student, knowledge, demonstrate, skill, professional, plan, instruction, teaching, education, understanding, appropriate* гэсэн үгнүүд хамгийн олон буюу 23-60 хүртэл удаа давтагдаж байна. Хүснэгт 32-д хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн агуулгын давтамжийг харуулав.

Хүснэгт 32. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн агуулгын харьцуулалт, давтамж


Д/д	Сургуулиуд	PLOs*																			
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
1.	Oxford Brookes University	√	√	√	√	√	√														
2.	Qatar University	√					√	√													
3.	Montclair State University						√	√	√												
4.	University of Wisconsin-Madison				√					√	√	√	√	√							
5.	University of Canterbury												√	√	√						
6.	Mary Immaculate college						√														
7.	University of Tasmania		√		√		√	√	√			√				√					
8.	University of St.La Salle		√		√		√		√			√	√	√	√	√	√	√			
9.	Turku university		√	√	√		√	√				√		√		√		√			
10.	Mondragon University	√								√		√							√	√	√
11.	University of Newcastle			√			√	√		√				√	√	√		√			
12.	University of Oulu											√	√	√	√						
13.	SaintXavier University		√	√	√	√		√		√		√	√	√		√					
14.	Missouri State University				√	√						√	√	√							
15.	University of Colorado Denver		√	√	√								√	√							√
16.	North Park university, Chicago			√	√								√		√				√		
17.	Biola University												√	√			√				√
18.	Wittenberg university			√	√		√		√	√			√		√		√			√	
19.	Kean University			√	√	√		√			√		√		√				√		
20.	Tomas del Rosario College	√		√	√		√	√				√	√	√		√	√	√	√	√	√
<b>Давхцлын тоо</b>		<b>4</b>	<b>6</b>	<b>9</b>	<b>12</b>	<b>4</b>	<b>10</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>9</b>	<b>11</b>	<b>12</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>2</b>

Тайлбар\*: 1. Ахиц дэвшил гаргах, 2. Сэдэв болон сургалтын хөтөлбөрийн талаарх мэдлэг, 3. Заах, төлөвлөх, 4. Үнэлгээ хийх, 5. Зан үйлийг удирдах, 6. Үүрэг хариуцлага, ёс зүй, 7. Мэргэжлийн өндөр мэдлэг, 8. Үнэт зүйл, шударга ёс, 9. Асуудал шийдвэрлэх, 10. Мэдээллийг үр дүнтэй ашиглах, 11. Харилцааны үр дүнтэй хэлбэрүүдийг ашиглах, 12. Суралцагчийн олон талт, ялгаатай байдлыг харгалзах, 13. Боловсрол болон бусад салбар, шинжлэх ухааны талаарх ойлголт, мэдлэг, 14. Сурган заах арга зүй, 15. Бүтээлч, шүүмжит сэтгэлгээ, 16. МХХТ-ийг хэрэглэх, 17. Бие даан суралцах, 18. багаар ажиллах, 19. Манлайлал, 20. Гадаад хэл

Олон улсад бага боловсролын багш бэлтгэж буй бакалаврын хөтөлбөрөөр сургалт явуулж буй 20 сургуулийн хөтөлбөрийн сургалцахуйн үр дүн, зорилт, үндсэн ур чадвар, чадамж гэсэн харилцан адилгүй суралцахуйн жагсаалтад дүн шинжилгээ хийхэд дээрх 20 мэдлэг, чадвар, хандлагыг тусгасан байна. Давхцлын тоог авч үзвэл үнэлгээ хийх, үүрэг хариуцлага ёс зүй, суралцагчийн олон талт, ялгаатай байдлыг харгалзах, боловсрол болон бусад салбар, шинжлэх ухааны талаарх ойлголт, мэдлэг, заах төлөвлөх чадамжийг илүү чухалчилж үзсэн байгааг Хүснэгт 32-оос харж болно.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн үндсэн тодорхойлолт, олон улсын их, дээд сургуулиудыг ямар мэдлэг, ур чадвар, хандлагатай хүнийг бэлтгэхээр зорьж байгааг 31 сургуулийн тодорхойлон дэвшүүлсэн суралцахуйн үр дүн (Хавсралт 2), багшийн чадамжийн хүрээ, АНУ-н стандарт, Зүүн өмнөд азийн багшийн чадамжийн хүрээний баримт бичгүүдэд тулгуурлан “Багш, бага боловсрол” хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг ажил олгогчдын эрэлт хэрэгцээг хангасан, мэргэжлийн онцлогийг хадгалсан бөгөөд Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилтыг хангасан дараах 13 хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлон санал болгож байна. Хөтөлбөрөөр суралцагч нь тухайн салбар, чиглэлийн мэдлэг эзэмшихээс гадна хувь хүн талаасаа хөгжих, нийгэмших, мөн аливааг бүтээх ур чадвар, хандлагыг цогцоор нь эзэмших боломжтойгоор суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдаг бол “Багш, бага боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдэд Зураг 23-т үзүүлсэн мэдлэг, хувь хүний хандлага, харилцаа, үйл ажиллагаа гэсэн үндсэн бүлэгт хуваан авч үзсэн.

Зураг 23. Хөтөлбөрөөр суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагын цогц



Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд зөвхөн мэдлэг бус төгсөгчдөд шаардлагатай ур чадвар, хандлага багтсан байх ба эдгээрийг оюутан заавал эзэмшиж төгсөх ёстой байдаг. Сургалтын хугацаа, тэнд багтсан хичээлүүдийн багц цагийн хуваарилалт, агуулгын багтаамжаас хамаарч ур чадвар, хандлага талын үр дүнг тусгайлсан хичээлээр олгох боломж багатай учраас хичээл бүрд суралцахуйн үр дүнг зөв хуваарилах замаар энэ асуудлыг шийдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, хичээл зааж байгаа багш бүр тухайн хичээлийн агуулгын дагуу тодорхой мэдлэг олгохоос гадна тэр мэдлэгийг олон нөхцөлд хэрэглэх ур чадвар, мөн хувь хүний болон харилцааны ур чадвар, хандлага олгоход хичээлийн суралцахуйн үр дүнг чиглүүлэх ёстой<sup>8</sup>. “Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчид нь дараах суралцахуйн үр дүнгүүдийг эзэмшинэ (Хүснэгт 33 ). Үүнд:

Хүснэгт 33. Санал болгож буй “Багш, бага боловсрол” хөтөлбөрийн суралцахуйн үр дүн

№	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд PLOs
1.	PLO (A.1): Судлагдахууны агуулга, арга зүйн мэдлэг, чадвараа харуулах
2.	PLO (A.2): Бага ангийн сурагчдын хөгжил, төлөвшил, сэтгэл хөдлөл, нийгэмшихүй, бие бялдар, танин мэдэхүйн онцлог, суралцах хэв маяг, ялгаатай байдлын талаар шинжлэх ухаанч мэдлэг, чадвараа харуулах.
3.	PLO (A.3): Боловсролын үйл ажиллагаандаа мэдээлэл, харилцаа, холбооны технологи болон дижитал чадамжаа ашиглах.
4.	PLO (A.4): Боловсролын бодлого, чиг хандлага, эрх зүйн баримт бичиг, боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар мэдлэг, ойлголттой байх.
5.	PLO (B.1): Мэргэжлийн үйл ажиллагаа, хичээлийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх,

<sup>8</sup> Үр дүнд суурилсан боловсрол (obe.edu.mn) Үр дүнд суурилсан боловсролын стандарт, арга зүйн шалгуур, шаардлага

	үнэлэх, сайжруулах чадамжтай байх.
6.	PLO (B.2): Эерэг, найрсаг суралцахуйн орон зай, уур амьсгалыг бий болгоход хичээлийн агуулга, онцлогт тохирсон багшлахуйн болон суралцахуйн стратеги, арга зүй, харилцааны хэлбэрийг үр дүнтэй хэрэглэх.
7.	PLO (B.3): Хүний хөгжил, сургалтын онол, стратеги, боловсролын сэтгэл судлал, олон талт суралцагчидын талаарх мэдлэгээ ашиглан хүүхэд бүрийн авьяас, чадвар, сонирхлыг нээх, хөгжүүлэх, дэмжих.
8.	PLO (B.4): Сурагчид болон тэдгээрийн гэр бүлийн нийгэм, соёлын ялгаа болон олон талт байдал, сурагчдын ялгаатай хэрэгцээнд хүндэтгэлтэй хандах, тэгш хамруулах боловсролын үзэл санааг сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглах.
9.	PLO (B.5): Суралцахуйн үйл явцыг удирдан чиглүүлэх, ахиц дэвшил, амжилтыг дэмжихийн тулд үнэлгээний даалгавар боловсруулах, үнэлгээний олон төрлийн хэрэгслийг ашиглан дүн шинжилгээ хийх, тайлбарлах.
10.	PLO (C.1): Өөрийгөө танин мэдэх, эрүүл мэнддээ анхаарах, сэтгэл хөдлөлөө удирдан жолоодох, өөрийн багшлах арга зүй, туршлагадаа эргэцүүлэл хийх.
11.	PLO (C.2): Бие даан болон бусадтай хамтран тасралтгүй суралцах, мэргэжлийнхээ өсөлт, хөгжилд хариуцлагатай байж, хувь хүний чадвар, хандлагуудыг хэрэглэх, үлгэрлэн харуулах.
12.	PLO (C.3): Хүмүүнлэг, хамтач, ёс зүйтэй, алсын хараатай, мэдрэмжтэй анги танхимд харилцан хүндэтгэлтэй байдлыг бий болгох.
13.	PLO (C.4): Багш мэргэжлийн ёс зүй, нэр хүндийг эрхэмлэн багшлахуйн үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй, хариуцлагатай иргэн болж төлөвших.
14.	PLO (D.1): Суралцагчийн суралцахуйг дэмжихэд олон нийтийн оролцоог хангах, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, дэмжих сүлжээ, тогтвортой түншлэлийг бий болгох.
15.	PLO (D.2): Үр бүтээлтэй ажиллах багийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, манлайлах. Англи болон бусад түгээмэл гадаад хэлээр бичих, ярих чадвараа харуулах, зохиол бүтээлийг зөв сонгох ашиглах.

Хөтөлбөрт суралцахуйн үр дүнг ямар түвшинд эзэмших шаардлагатайг тодорхойлохдоо 1-5 хүртэл оноо бүхий загварыг ашиглаж болно. Энэ нь Массечусетийн технологийн институт (MIT)-аас гаргасан загвар болно<sup>9</sup>.

1 оноо - Тухайн үр дүнгийн хувьд тодорхой хэмжээний чадвараа илрүүлэх

2 оноо - Тухайн үр дүнтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох, хувь нэмэр оруулах чадвартай байх

3 оноо - Тухайн үр дүнг ойлгох ба тайлбарлах чадвартай байх

4 оноо - Тухайн үр дүнгийн хувьд практик эсвэл хэрэгжүүлэх чадвартай болсон байх

5 оноо - Тухайн үр дүнгийн хувьд манлайлах эсвэл инноваци хийх чадвартай болсон байх

Аливаа сургалтын төлөвлөгөөний хичээлүүд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг оюутанд эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Хэрэв хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдтэй уялдсан байдлаар хичээлүүдийг тодорхойлоогүй бол хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд нь бүрхэг, үл хэмжигдэхүйц уриа болж хувирна гэсэн үг юм.

### Хөтөлбөрт элсэгчдэд тавих шаардлага, шалгуур

Бага боловсролын багш бэлтгэж буй гадаадын их, дээд сургууль, коллежийн элсэгчдэд тавих шалгуур, шаардлага нь улс орны онцлогоос хамаараад харилцан адилгүй байх бөгөөд дараах нийтлэг дүр төрх харагдаж байна. Үүнд: Өргөдлийн маяг; Төгсөлтийн шалгалтын оноо (ЭЕШ буюу англи хэл, математик); Төгсөлтийн гэрчилгээний онооны голч 2.4 дээш; Эссэ бичих, сургалтыг байгууллагаас тодорхойлох захидал; Ярилцлага болон аман шалгалт зэрэг юм.

<sup>9</sup> <https://www.macte.org/accreditation-process/>

Хүснэгт 34. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахаар элсэгчдэд тавих нийтлэг шаардлагын харьцуулалт

Сургууль / Элсэлтийн шалгуур үзүүлэлт	GCSE	TOEFL / IELTS	Эссэ / санал болгох захидал	GACE	Онооны голч 2.4 дээш	GRE	CIE	NCEA	Ярилцлага болон аман шалгалт	IB / IB <sup>10</sup>	SAT / GMAT	CSEC / GCE / SSC	Тусгай сургалт дүүргэх
New Zealand, Auckland University	√				√		√						
England, Oxford Brookes University	√												
Ireland, Dublin City university	√								√			√	
Arab, Qatar University		√											
USA, University of Wisconsin-Madison		√	√										
Australia, University of the Sunshine Coast		√											√
Finland, Turku university		√				√				√			
Slovenia, University of Ljubljana			√		√								
USA, Montclair State University			√	√									
Canada, University of Victoria			√										√
Australia, University of Tasmania			√										√
Philippines, University of St. La Salle			√		√								
USA, Georgia State University				√	√								
Norway, Nord University					√								
USA, George Mason University					√								
Australia, University of Newcastle					√								√
Korea, Chung Cheong University					√				√				
USA, University of Virginia						√			√				
New Zealand, University of Canterbury							√	√		√			
Singapore, Nanyang Technological University									√				√
Finland, University of Oulu										√	√		√
Jamaica, St. Joseph's Teachers' College												√	√
Spain, Mondragon University					√				√		√		√
Нийт	3	4	6	2	9	2	2	1	5	3	2	2	8

Шинэ Зеландын Auckland, Английн Oxford Brookes, Ямайка улсын St. Joseph's багшийн коллеж, Ирландын Дублин их сургуулиудын элсэлтийн шаардлагад дунд боловсролын ерөнхий гэрчилгээ (GCSE- General Certificate of Secondary Education) буюу түүнтэй дүйцэхүйц: англи хэл, математик, шинжлэх ухаан (хими, физик, биологи) шалгалтын босго оноо 136 байх. CSEC-ийн (Caribbean Secondary Education Certificate) хичээлүүдийг ерөнхий болон техникийн ур чадварын шалгалтаар баталгаажуулдаг. Ерөнхий болон техникийн ур чадвар нь сурагчдад цаашдын суралцах, ажлын байранд орох үндэс суурийг бүрдүүлдэг гэж үздэг.

АНУ-ын Жоржиа мужийн багш, сурган хүмүүжүүлэгчид гэрчилгээ олгох үнэлгээ нь (Georgia Assessments for the Certification of Educators-GACE) ихэвчлэн Жоржиа мужийн ирээдүйн багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэдлэг, ур чадварыг үнэлдэг цахим шалгалт юм.

<sup>10</sup> International and European Baccalaureate-Европийн иргэншилтэй бөгөөд IB/EB хөтөлбөрийг дүүргэсэн бол эхний шатны элсэлтийн шалгаруулалтад орох шаардлагагүй.

Багш, бага боловсролын хөтөлбөрт хамрагдахын тулд дээрх нийтлэг шаардлагуудаас гадна суралцагчдын хичээлийн дүнгийн дундаж 2.75-аас багагүй байх; суралцагчдын GACE хөтөлбөрийн элсэлтийн үнэлгээнд тэнцсэн оноогоо танилцуулах; суралцагчдын Жоржиа сурган хүмүүжүүлэгчийн ёс зүйн тестийг (360 оноо) бөглөсөн байх гэх мэт шаардлага байна. Арабын Qatar, АНУ-ын Wisconsin-Madison, Австралийн Sunshine Coast, Финландын Turku зэрэг их сургуулиуд нь TOEFL, IELTS-ын шалгалтын оноо шаарддаг бол Шинэ Зеландын Canterbury их сургуульд элсэж орохын тулд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- NCEA (National Certificates of Educational Achievement)
- Кембрижийн олон улсын шалгалт (Cambridge International Examinations-CIE)
- Шинэ Зеландын ахлах сургуулийн төгсөлтийн шалгалт зэрэг байна.

Финландын Oulu их сургуульд элсэхэд SAT, эсвэл GRE (the Graduate Record Examinations) шалгалт өгсөн байх хэрэгтэй. Австралийн Tasmania их сургуулийн элсэлтийн онцлог нь өргөдөл гаргагч нь бэлтгэл сургалтад хамрагдсан байх, сургалтын дараах шалгалтад тэнцээгүй бол элсэлтийн өргөдлийг дахин хянан үзэх боломжтой эсвэл их сургуулийн бэлтгэлийн хөтөлбөрийг (эсвэл Австралийн их сургуулиас санал болгож буй түүнтэй адилтгах мэргэшлийг) дүүргэсэн байх ёстой байдаг. Австралийн Sunshine Coast их сургуулийн хувьд багш болох сонирхол, хэрэгцээг илрүүлэх зорилготой онлайн асуулга бөглөх; яагаад багш болохоор шийдсэн талаар 600-1000 үгтэй эссэ бичих; мэргэжлийн туршлагын шалгалтын өмнө цэнхэр карт авах юм. Австралийн Edith Cowan их сургуулийн хувьд Австралийн мэргэшлийн хүрээний 4-р шатны гэрчилгээтэй байх (AQF Cert IV); Австралийн дээд боловсролын байгууллагад (эсвэл түүнтэй дүйцэхүйц) бакалавр болон түүнээс дээш түвшний 0.25 EFTSL-ийн сургалтыг амжилттай дүүргэсэн; бакалаврын гэрчилгээ; дээд боловсролын элсэлтийн тусгай шалгалт; их сургуульд бэлтгэх курс; уугуул иргэдийн их сургуулийн чиг баримжаа олгох курс; Аборигенчуудын их сургуулийн бэлэн байдлын үнэлгээ; эсвэл туршлагад суурилсан элсэлтийн схем байдаг. Австрали, Newcastle их сургуулийн гадаад оюутны хувьд Шинэ Өмнөд Уэльсийн ахлах сургуулийн гэрчилгээ (HSC)-тэй төстэй ахлах дунд сургуулийн мэргэшлийг амжилттай дүүргэсэн байх; IELTS-ийн ерөнхий оноо 6.5-тай тэнцэх англи хэлний мэдлэгтэй байх ёстой байдаг.

Ямайка улсын St. Joseph's багшийн коллеж нь математик, англи хэл, байгал, нийгмийн болон бусад шинжлэх ухааны хичээлийн амжилт, GSEC, GCE, SSC шалгалтын амжилтыг хөтөлбөрт элсүүлэх шалгуур болгон авч үздэг. Дунд сургуулийн гэрчилгээ (secondary school certificate - SSC) эсвэл дунд сургуулийн төгсөлтийн гэрчилгээ (secondary school certificate - SSLC) нь Бангладеш, Энэтхэг, Пакистанд зэрэг улсуудын дунд боловсролын шалгалтыг амжилттай өгөх зорилгоор боловсролын зөвлөлөөс явуулдаг олон нийтийн шалгалтын үр дүнд авдаг.

Дээрх сургуулиудын элсэлтийн шалгуур, шаардлагыг Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагуудын элсэлтийн ерөнхий шалгуур, шаардлагатай харьцуулахад (*Хүснэгт 35*) элсэгчийн академик мэдлэг, чадвараас гадна хувь хүний олон талт хөгжил (спорт, урлаг, соёл, олон нийтийн үйл ажиллагааны идэвх, хүмүүнлэгийн үйлс, шинжлэх ухааны үйл ажиллагаа гэх мэт), хувь хүний хандлагыг илтгэсэн үзүүлэлтийг эссэ бичүүлэх, уулзалт ярилцлага болон бусад нэмэлт шалгуурыг хэрэглэдэг нь манай улсын хувьд учир дутагдалтай байна. Дэлхийн улс орны их сургуулиуд авьяасын төвлөрлийг бий болгох, шилдэг элсэгчийг татах асуудал нь дээд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашлаад сургалт, судалгааны чадавхийг сайжруулахад чиглэсэн стратегийн чухал зорилт болж байгаа хэдий ч энэ нь ганц сургалтын байгууллагаас шалтгаалах зүйл биш бөгөөд тухайн улс орны

нийгэм, эдийн засаг, улс төрийн олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тухайлбал, тухайн улс орны төрөлх хэл; дээд боловсролын сургалтын байгууллагуудын олон улсын нэр хүнд; цагаачлалын бодлого; сургалтын зээл, тэтгэлэгт хамрагдах боломж; суралцах амьдрах ахуйн таатай орчин нөхцөл; эдийн засаг, бизнес, судалгааны цар хүрээгээ өргөжүүлэх, хөгжүүлэх боломж; орлогын нэмэлт эх үүсвэртэй байх боломж нөхцөл зэргийг нэрлэж болно.

*Хүснэгт 35. Монгол улсын төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх шалгуур, шаардлагын төрөл*

Шалгуурын төрөл	Элсэлтийн шалгуур	Сургууль 1	Сургууль 2	Сургууль 3	Сургууль 4	Сургууль 5	Сургууль 6	Сургууль 7	Эзлэх хувь
<b>ЭЕШ, түүний босго оноо</b>		√	√	√	√	√	√	√	<b>100.0</b>
<b>Боловсролын гэрчилгээний дундаж оноо</b>		√	√	√	√	√	√	√	<b>100.0</b>
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	TOEFL	√		√		√			<b>43.0</b>
	IELTS	√				√			28.5
	TOEIC	√							14.0
	HSK			√		√			28.5
	N			√		√			28.5
	TOPIK			√					14.2
	ТРКИ			√					14.2
	KLPT			√					14.2
<b>Зарим улс орны элсэлтийн шаардлага</b>	SAT			√					14.2
	Кембрижийн олон улсын AS (A) түвшний шалгалт	√				√			28.5
<b>Олимпиад</b>	Үндэсний олимпиад	√	√	√		√		√	<b>71.4</b>
	Олон улсын олимпиад	√	√	√		√		√	<b>71.4</b>
	Мэргэжлийн олимпиад		√	√		√		√	<b>57.1</b>
<b>Урлаг, спортын уралдаан</b>	Урлагийн амжилт			√		√		√	<b>43.0</b>
	Спортын амжилт	√		√		√	√	√	<b>71.4</b>
	Мэргэжлийн уралдаан		√	√		√		√	<b>57.1</b>
<b>Нийгмийн идэвх</b>	Хүмүүнлэгийн үйлстэн					√			14.2
<b>Тэтгэлэг</b>	ЭЕШ-ын өндөр онооны тэтгэлэг	√	√	√		√	√	√	<b>86.0</b>
	Тухайн ИС-ийн лицей сургуулийн өндөр оноотой төгсөгч	√	√		√				<b>43.0</b>
	Тусгай хэрэгцээт сурагчид					√		√	28.5
	Өндөр оноотой ч сурах санхүүгийн хүндрэлтэй сурагч					√			14.2
	Үндэсний болон ОУ-ын олимпиадын 1-3 байр эзэлсэн сурагч							√	14.2
<b>Бусад</b>	Эрүүл мэнд, бие бялдар						√		14.2

Хүснэгт 35-аас харахад, монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн журамд тусгагдсан элсэгчдэд тавигдах зарим шаардлагыг багцлан авч үзвэл: англи хэлний мэдлэг, элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, үндэсний болон олон улсын олимпиад, уралдаан, тэмцээн, спорт, урлагийн авьяасыг голлон анхаарсан байна. Мөн элсэлтийн ерөнхий шалгалтыг өгч босго оноог хангасан байх, үндэсний болон олон улсын түвшний олимпиад, уралдаан, тэмцээнд амжилт гаргасан байх, спортын авьяас чадвар, амжилт зэрэг шалгуурууд 7 их сургуулийн хувьд 71.4 – 100.0 хувийг эзэлж байна. Түүний дараа англи хэлний мэдлэг (TOEFL), мэргэжлийн олимпиад, уралдаан 43.0-57.1 хувийг эзэлжээ. Суралцагчид сургуулийн зүгээс олгох тэтгэлэг нь ихэнхдээ элсэлтийн ерөнхий шалгалтад авсан онооноос хамаарч сургалтын төлбөрийн (15.0 хувь, 50.0 хувь, 70.0 хувь, 100.0 хувь) хөнгөлөлтийг

үзүүлэх, зарим тохиолдолд эхний жилийн сургалтын төлбөрөөс 100 хувь чөлөөлдөг байна. Мөн тухайн мэргэжил, хөтөлбөрийн онцлогоос шалтгаалж элсэлтийн тусгай шалгуурыг сургалтын байгууллага боловсруулан гаргадаг.

Монгол улсын их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох (Очирбат, Б., бусад, 2021) зорилгоор АНУ, Япон, БНХАУ, БНСУ зэрэг улс орнуудын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх элсэлтийн шалгалтын тогтолцоог судалсан бөгөөд судалгааны үр дүнд ижил болон ялгаатай талуудыг онцолсон байна. Ижил төстэй талуудад: их сургуульд элсэх үндэсний хэмжээний шалгалттай; боловсролын бодлого боловсруулах байгууллагад элсэлтийн шалгалт зохион байгуулах тусгай нэгжтэй; жилд 1 удаа зохион байгуулдаг; их сургуулийн нэмэлт шалгалтуудтай; шалгалтын хэлбэрийн хувьд тестийн олон сонголттой болон богино хариулттай асуулттай байдаг байна. Харин ялгаатай талд: элсэлтийн шалгалтын агуулга, зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн хэсгүүд ялгаатай; эх хэл, түүхийн шалгалтыг заавал өгөх бөгөөд эдгээр шалгалтад тэнцсэн тохиолдолд дараагийн шатны шалгалтад орохоор журамлагдсан; цахимд суурилсан шалгалтын тогтолцоо зарим улс орны хувьд хэрэгжиж эхлээгүй байна гэжээ.

### **Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчин**

“Багш, бага боловсрол” бакалаврын жишиг хөтөлбөр боловсруулахад шаардагдах сургалтын орчин, хэрэглэгдэхүүнтэй холбоотой судалгааны мэдээлэлд шинжилгээ хийв. Сургалтын орчны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдээс үзэхэд сургалтын орчныг цогцоор нь тодорхойлох байдал нийтлэг байна. Тухайлбал, “Сургуулийн суралцахуйн орчин гэдэг нь сургалтыг дэмжсэн, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй анги, сургууль болон сургуулийн олон нийтийг хэлнэ. Хичээл заах (талуудын хамтын оролцоотой хэлэлцүүлэг, хичээл заах, бие даан болон хамтран ажиллах зэрэг олон талт, тэнцвэртэй нэгж хичээлээс)-аас эхлээд сургуулийн соёл (сургуулийн манлайлал, сэдэлжүүлэлт, багшийн хөгжил) болон олон нийтийн түншлэл (эрүүл мэндийн байгууллага, сурагчдын сэтгэл зүйн асуудлуудад тусламж үзүүлэх бусад байгууллага) зэрэг бүгдийг багтаан ойлгоно. Сургалтын орчны судалгаануудад судлагдахууны чиглэлээс үл хамааран сургуулийн өмнөх, бага, ахлах сургууль, коллеж, их сургууль, насан туршийн боловсролын талаарх ойлголтыг багтаадаг байна.

Олон улсын болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүд, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, олон улсын их, дээд сургуулиудын хөтөлбөрүүдийг үндэслэн сургалтын орчныг дөрвөн бүрэлдэхүүнээр ангилан авч үзлээ. Үүнд:

- *Материаллаг орчин:* Сургуулийн материаллаг орчинд барилга байгууламж, анги танхим, биеийн тамирын заал, номын сан, чөлөөт цагаа өнгөрөөх орон зай, сургуулийн автобус, сургуулийн дэргэдэх талбай, дотуур байр, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг биет зүйлс хамаарна.
- *Цахим орчин:* мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан, тэгш, хүртээмжтэй боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн өргөн хүрээтэй сургалтын орчны экосистемийн нэг хэсэг;
- *Сэтгэл зүйн (үйлийн) орчин:* сургалтын орчны уян хатан байдал, аюулгүй тайван, ялгаварлан гадуурхалтгүй орчин, багшийн зан үйл, эерэг байдал, мотиваци, зохион байгуулалт, суралцагч бүрт хамааралтай хүндлэл, дэмжлэг бүхий найрсаг, стрессгүй, хүлээн зөвшөөрсөн, эрүүл, аюулгүй, хамгаалалттай, жендэрийн мэдрэмжтэй орчин;

- *Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин*: бүлэг дүүргэлт, ялгаварлан гадуурхалтгүй суралцагч бүрийг хүлээн зөвшөөрсөн, дэмжсэн үйлчилгээ, сургуулийн дотоод журам, хооллолт, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт.

ТХЗ 4.а зорилтыг “2030 он гэхэд бүх нийтийн аюулгүй, хүчирхийлэлгүй, инклюзив оролцоог хангасан, үр өгөөжтэй суралцах орчин бүрдүүлж, боловсролын байгууллагын дэд бүтцийг хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл болон жендерийн мэдрэмжтэй болгон шинэчлэн сайжруулах” хэмээн тодорхойлсон билээ (UNESCO, 2015). Сургалтын орчны талаарх олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдээс үзэхэд суралцахуйн орчин нь суралцагчийн сурлагын амжилтад 12-25.0 хувь хүртэл нөлөөлдөг гэж үзжээ.

### ***Материаллаг орчин***

Үндэсний хөгжлийн бодлогын болон дээд боловсролын эрх зүйн баримт бичгүүдэд дурдсанаар материаллаг орчныг хөгжүүлэхэд, тухайлбал дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бүтцийг сайжруулах, мөн суралцагч төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавих шаардлагыг боловсруулж, стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгох хэрэгтэй хэмээн тэмдэглэжээ. Цаашлаад ногоон орчны үнэлгээ, ухаалаг технологитой уялдуулан дээд боловсролын сургалтын орчны стандартыг сайжруулан баталгаажуулах хэрэгцээ байсаар байна. Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, БШУС-ын А174 тушаалд" 2.5.1 Сургалтын тусгай зөвшөөрөл болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх байгууллагын тогтоосон шаардлагад нийцсэн материаллаг болон материаллаг бус орчинг бүрдүүлсэн байна" гэж заасан. Дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага болон БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 5 дугаар хавсралт шалгуур 5-ын материаллаг болон технологийн нөөцөд сургууль нь эрхэм зорилго, зорилгуудаа үр ашигтай хэрэгжүүлэх материаллаг (анги танхим, тоног төхөөрөмж, лаборатори, номын сан) болон технологийн нөөцийг бүрдүүлэх, байнга шинэчлэх бодлого, зохицуулалттай байна. Сургалтын таатай орчин, технологийн нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ, хангамжийг сайжруулах хэрэгцээ байсаар байна.

Сургуулийн болон суралцах орчныг суралцагчдад ээлтэй болгох бодлого Монгол Улсын Засгийн газраас сүүлийн жилүүдэд суралцагчдад ээлтэй сургалтын байгууллагын дэд бүтэц, суралцахуйн таатай орчин бүрдүүлэхэд илүүтэй анхаарч ажиллаж байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилтыг нэн тэргүүнд тусгаж, үүний дагуу шинээр сургууль, цэцэрлэг барих, сургуулийн ус, ариун цэвэр, эрүүл ахуй (УАЦЭА)-н орчныг сайжруулахаар төлөвлөсөн.

Олон улсын баримт бичиг болон судалгааны ажлуудад тэмдэглэснээр материаллаг орчинд сургуулийн CO<sup>2</sup> түвшинг хянах болон агааржуулалтын хурд, бусад материаллаг зүйлийг хянах хүчин зүйлүүд (температур, харьцангуй чийгшил, цуурайтах цаг хугацаа, дуу чимээ, гэрэлтүүлэг, тоосжилт, чийгшил, хөгц мөөгөнцөрт өртсөн эсвэл өртөөгүй) сургуульд тамхи татах орон зай, ундны ус, ариун цэврийн байгууламж, галын аюулгүй байдал, онцгой байдлын гэрэлтүүлэг, аюулгүй байх орчныг дизайнчлах, орон зайн бүтэц нь байрны оршин суугчдын бие махбодийн аюулгүй байдлыг хамгаалдаг байх, бодисын зохистой хэрэглээ барилгын систем, материал, тээврийн хэрэгслийн болон явган хүний хөдөлгөөний аюулгүй байдал, цайны өрөө, коридор, шатны хонгил, машин автобусны зогсоол зэргийг хамруулан

авч үзжээ. Олон улсын 28 их, дээд сургуулийн материаллаг орчинд хамаарах бүрэлдэхүүнийг харьцуулан шинжлэхэд дараах үр дүн гарлаа. Нийтлэг бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Их сургуулийн хотхон (кампус) барилга, байгууламж, оюутны байр
- Их сургуулийн номын сан
- Хурлын заал, урлаг, соёл, спортын танхим, сургалтын танхим, лаборатори
- Гадна талбай, машин, автобусны зогсоол
- Оюутны хоолны газар, кафе

Тухайлбал, Английн Oxford Brookes их сургууль нь үл хөдлөх хөрөнгийн стратегийг хэрэгжүүлэх төлөвлөлтөд их сургуулийн материаллаг орчныг байнга шинэчлэн сайжруулах ажлыг тогтмол хийснээр цаашдаа гарах зардлыг хэмнэх үр дүнтэй гэж үзсэн байна.

Гадаадын их сургуулиуд нь өөрсдийн онцлого бүхий барилга байгууламжаа төлөвлөх, ашиглах, зохион байгуулах, тохижуулах гэх мэтээр материаллаг орчныг загварчлан бүрдүүлсэн байна.

### ***Цахим орчин***

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хөгжлийн гол цөм нь нийгэм, эдийн засагт өөрчлөлт хийгч, түүнд оролцогч болсон хүн” гэж үзсэн бөгөөд нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх, боловсролын бүх шатанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлэхээр тусгагдсан.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад чиглэсэн цахим сургалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2020 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 1 дүгээр тогтоол-ыг гаргасан байна. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар “Боловсролын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)” бодлогын баримт бичгийг баталсан. Уг баримт бичгийн дагуу ухаалаг, дижитал технологийг бүх түвшний боловсрол, сургалтад ашиглах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна гэж тодорхойлжээ. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Жагсаалт батлах тухай” 359 дүгээр тогтоол, 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоолоор нэгж байгууллагын түвшинд цахим үйл ажиллагааг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулах эрх зүйн болоод санхүүгийн боломжийг бүрдүүлээд байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлагад “сургууль нь эрхэм зорилго, зорилгуудаа үр ашигтай хэрэгжүүлэх материаллаг болон технологийн нөөцийг бүрдүүлэх, байнга шинэчлэх бодлого, зохицуулалттай байх, сургалт, судалгаандаа тохирсон мэдээлэл холбооны технологийн системтэй, хангалттай тооны программын лицензтэй, түүнийг ашиглах компьютер, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх, суралцагч, багш, ажилтнууд тэдгээрийг ашиглах боломжоор хангагдсан байх, мэдээлэл, харилцааны технологи нь бүх хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг хангасан байна” хэмээн тусгажээ. Харин олон улсын туршлагаас үзэхэд, дээд боловсролын сургалтын байгууллагын цахим орчны бүрдүүлэгч хэсэгт интернэтийн сүлжээ, мэдээллийн систем, техник хангамж, дижитал хэрэглэгдэхүүн, боловсролын нээлттэй нөөц материал, лицензтэй программ хангамж болон эдгээрийн аюулгүй байдлыг хангах хүрээнд тодорхойлсон байна.

*Мэдээллийн системд* сургуулийн веб сайт, удирдлагын мэдээллийн систем, цахим сургалтыг зохион байгуулах цахим сургалтын систем (LMS), цахим номын сангийн систем зэрэг платформ болон порталуудыг хамруулан ойлгоно.

*Интернэтийн сүлжээнд* өндөр хурдны шилэн кабелиар холбогдсон байдал, утасгүй интернэтийн сүлжээг ойлгоно.

*Компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд* сургалтын зориулалттай компьютерын лаборатори, дижитал студи, сервер компьютер, сүлжээний техник хэрэгсэл, гар утас, таблет, хөдөлгөөнт төхөөрөмжүүд, камер гэх мэтийг багтаадаг.

*Дижитал хэрэглэгдэхүүн, боловсролын нээлттэй нөөц материалд* Сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны зориулалтаар ашиглах цахим сурах бичиг, ном, гарын авлага, цахим хичээл, аудио, видео контент суралцагч болон багшид зориулсан нэгдсэн санг ойлгоно. . Үүнээс гадна, тухайн сургуулиуд сургалтын нээлттэй нөөц материал (OERs) хэрэглэж байна.

*Сургалтад хэрэглэх программ хангамж.* Суралцахад дэмжлэг болох технологи, программ хангамж нь өргөн болон тусгай харэгцээний зориулалттай, пицензтэй байна.

Зарим гадаадын их, дээд сургуулийн туршлагаас харахад, тухалбал, University of Victoria (Канад) сургалт болон суралцагчдад үйлчилгээ үзүүлэх тусгай хэрэгцээний лабораторууд ижитал сэтгэл зүйн лаборатори (BMED), Дижитал эрүүл мэндийн лаборатори (TIE) ашиглаж байна. Баримт бичгийн судалгаагаас үзэхэд, цахим сургалтын орчинг цогцоор нь бүрдүүлэх нь чухал гэж тэмдэглэжээ.

### ***Сэтгэл зүйн (үйлийн) орчин***

Сэтгэл зүйн (үйлийн) орчинд сургалтын орчны уян хатан байдал, аюулгүй тайван, ялгаварлан гадуурхалтгүй орчин, багшийн зан үйл, эерэг байдал, мотиваци, зохион байгуулалт, сурагч бүрт хамааралтай хүндлэл, дэмжлэг бүхий найрсаг, стрессгүй, хүлээн зөвшөөрсөн, эрүүл, аюулгүй, хамгаалалттай, жендэрийн мэдрэмжтэй орчин гэх мэт үзүүлэлтүүд багтана гэж тодорхойлжээ. Үндэсний бодлогын, хөгжлийн баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан сургуулийн бүх үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх сургалтын орчныг бий болгохыг онцолжээ.

Олон улсын судалгаанаас үзэхэд сургуулийн нийгэм-сэтгэлзүйн уур амьсгалд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд нь суралцагч, багш хоорондын харилцаа, сургалтын үйл явцад ашигласан арга барил, ангийн удирдлага, сахилга бат, суралцагч багш нарын тав тухтай байх орчин, сургууль дээрх хүчирхийлэл, нийгмийн болон сэтгэл санааны байдал зэрэг нь хамааралтай байгааг тодорхойлжээ. Сэтгэцийн эрүүл мэнд, бусадтай харилцах, дэмжлэг үзүүлэх, хүн хоорондын харилцааны ур чадварууд нь сургуулийн сэтгэл зүйн орчинд судлагдаж байна.

### ***Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин***

“Боловсролын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)” бодлогын баримт бичигт “эдийн засгийг хөгжүүлэхэд дээд боловсролын сургалтын байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлж, судалгааны чадавх, үр өгөөжийг сайжруулах, үр дүнг нь зах зээлийн эргэлтэд оруулж инноваци, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох бүтэц, зохицуулалтыг боловсронгуй болгох, дэмжлэг үзүүлэх” гэж тэмдэглэсэн байна. Багш бэлтгэх их, дээд сургуулийн багшлах дадлагын хугацаанд зохицуулалт хийж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэрэгцээг тус баримт бичигт тодорхойлсон байна.

Гадаадын их, дээд сургуулиудын туршлагаас үзэхэд, суралцагчдад мэдээлэл түгээх, чиглүүлэх, зөвлөх, санал бодлыг хүлээж авах, нийгмийн шаардлагатай үйлчилгээнд хамруулах, дэмжиж урамшуулах, тэтгэлэгт болон солилцооны хөтөлбөрт хамруулах, хүмүүжил, хөгжил, төлөвшлийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оюутны эрэлт, хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ үзүүлж байна.

#### *Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих*

Оюутны өдөр тутмын хэрэглээгээ хангах, хөдөлмөрт бэлтгэх, нийгэмд өөрийн гэсэн байр суурьтай болох, төлөвших, ажлын байранд дадлагажих зэрэг эдийн засаг, нийгмийн хэрэгцээ нэмэгдэж байгаатай уялдуулан оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор дараах үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнд:

- Оюутныг карьер төлөвлөлтөө хийхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- Оюутнуудыг хөдөлмөр эрхлэх, дадлага хийх хүсэлтийг хүлээн авах, дэмжих
- Ажил олгогч байгууллагатай хамтран ажиллах хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар оюутан, төгсөгчдөө ажлын байраар хангах;
- Оюутныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх сургалт зохион байгуулах;
- Төгсөгчийн ажлын байрны судалгаа хийж, ажлын байраар хангахад туслах;
- Бүртгэгдсэн оюутан болон төгсөгчдөд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- Оюутны хөдөлмөр эрхлэхэд зуучлахдаа албан байгууллагын нээлттэй ажлын байр, цагийн болон гэрээт ажлын байрнуудын мэдээллээр хангах;

*Оюутан солилцоо, тэтгэлэгт хамрагдалтад* дотоод, гадаадын их, дээд сургуульд оюутан солилцоонд хамрагдах, тэтгэлгээр суралцах боломж нөхцлийн талаар танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хамаарна.

*Оюутны нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэх, зөв төлөвшүүлэх зөвлөгөө өгөх үйлчилгээ*  
Оюутны чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хувь хүний хөгжлийн чиглэлээр клуб, дугуйлан, оюутны түншлэл, нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд эерэг өөрчлөлт авчрах сайн дурын ажлууд орж байна. Мөн гадаад оюутнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд сурч боловсрох сэдлийг төрүүлэх, зөвхөн өөрийн улс төдийгүй бусад улс орны зан заншил, соёлын ойлголтыг өгөх, танилцуулах, оюутан хоорондын харилцааг гүнзгийрүүлэх зорилготойгоор төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг.

#### *Эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ*

Анхан шатны тусламж, эмчилгээ үзүүлэхээс гадна, эрүүл ахуйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч байна. Зарим их дээд сургуулиудын онцлох үйлчилгээг дурдвал, St. Joseph's Teachers' College (Ямайка) оюутнуудад зориулсан бясалгалын төв ажиллуулдаг бол, Edith Cowan University (Австрали) -д хүүхэд асрах үйлчилгээ үзүүлдэг байна. Бага ангийн сурагчийн сурлагын амжилт, суралцахууд сургуулийн эрүүл ахуй, агааржуулалт, гэрэлтүүлэг илүү нөлөөлдөг бол мэргэжлийн болон дээд боловсролын суралцагчдад эрүүл мэндийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх, хөгжүүлэх үйлчилгээний орчин илүү нөлөөлдөг байна.

## 2.3. Гадаадын улс орнуудын багш бэлтгэх туршлага

### 2.3.1. Австралийн багш бэлтгэх туршлага

Австралийн боловсролын систем нь үндэсний, муж эсвэл орон нутаг, сургууль гэсэн шатлалтай. Муж эсвэл орон нутаг бүр дэх багш зохицуулах байгууллагууд багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, багш нарыг бүртгэх, гүйцэтгэлийг хянах, хөгжүүлэх стандартыг тогтоох үүрэгтэй байдаг. Австралийн Багшийн мэргэжлийн стандарт нь багш нарыг шаардлагатай чадамж эзэмшсэн эсэхийг үнэлдэг, чанарын баталгаажуулалтын үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн механизм юм. 2010 онд Боловсролын сайдын баталсан уг стандарт нь багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, багшлах эрх олгох арга аргачлалын үндэслэл болдог. Австралийн Багшийн мэргэжлийн стандарт (APST) нь Австралийн багш, багшлахуйн удирдамжийн хүрээ (AITSL, 2013) юм. АБМС нь мэргэжлийн мэдлэг, дадлага, оролцоо гэсэн гурван хүрээтэй.

*Хүснэгт 36. Австралийн Багшийн мэргэжлийн стандарт*

Домэйн	Стандарт
Мэргэжлийн мэдлэг	1. Сурагч, тэдний хэрхэн суралцдагийг мэдэх
	2. Агуулга, түүнийг хэрхэн заах талаар мэдэх
Мэргэжлийн дадлага	3. Сургалтыг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх
	4. Дэмжлэг болох, аюулгүй суралцах орчныг бүрдүүлж, хадгалах
	5. Сурагчийн суралцахуйг үнэлэх, хариу мэдээлэл, зөвлөгөө өгөх, тайлагнах
Мэргэжлийн оролцоо	6. Мэргэжлийн сургалтад хамрагдах
	7. Хамт ажиллагсад, эцэг эх/карьер болон олон нийттэй мэргэжлийн түвшинд хамтран ажиллах

Австралийн сургуульд багшлах эрхтэй болохын тулд бүх багш нар магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын багш бэлтгэх боловсролын хөтөлбөрт хамрагдах ёстой ба доод тал нь дөрвөн жил суралцан дээд боловсрол эзэмшсэн байх шаардлагатай. Багш мэргэжилтэй болох гурван үндсэн арга зам байдаг. Үүнд:

- Багш боловсролын дөрвөн жилийн бакалаврын боловсрол. Энэ нь ихэвчлэн бага ангийн багш нарт зориулагдсан байна.
- Хосолсон зэргийн хөтөлбөр - тодорхой мэргэжлийн зэрэг олгох хоёр жилийн хугацаанд хэрэгжих, багш боловсролын сургалт. Ихэнх их, дээд сургууль дөрвөн жилийн хугацаатай энэ хувилбарыг санал болгодог. Бөгөөд ихэвчлэн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулагдсан байна.
- Эрдмийн зэргээс гадна төгсөлтийн дараах хоёр жилийн багш бэлтгэх сургалт (Боловсролын диплом эсвэл магистрын зэрэг (бага ба/эсвэл дунд)).

Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын багш нар ISCED 6 (бакалаврын зэрэг) түвшнийг хангасан байдаг. Харин ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн сургалт хариуцсан багш нарын мэргэшлийн доод түвшин ISCED 4-д дүйцэх ёстой.

Ерөнхий боловсролын сургуулийг төгссөн, багш болох хүсэлтэй суралцагч суралцах хөтөлбөрийн босго оноог хангаж, Австралийн дээд боловсролын элсэлтийн зэргийн (ATAR) оноотой байх шаардлагатай. Багш бэлтгэх сургалтын агуулгын хүрээнд судлагдахууны хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх ухаан, хүүхдийн сэтгэл зүй, хөгжил, тоглоомын онол, дадлага, ерөнхий боловсрол судлал, мэргэжлийн дадлагын хичээлийн агуулгыг судална. Бага ангийн багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийн хүрээнд бага ангийн сурагчдын судлах

агуулгатай холбоотой бүх хичээлийг судалдаг. Дунд боловсролын багшаар бэлтгэгдэж буй оюутнууд багш бус мэргэжлийн боловсрол эзэмших оюутнуудтай ижил хичээлүүдийг судалдаг. Багшлах бакалаврын зэргийн хөтөлбөрийн хүрээнд хамгийн багадаа 80 хоногийн багшлах дадлагыг, төгсөлтийн дараах сургалтын хүрээнд 60 хоногийн багшлах дадлагыг гүйцэтгэдэг.

Багш нарыг стандартын түвшинд бэлтгэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн стандарт, журмыг ашиглан багш бэлтгэх боловсролын хөтөлбөрүүдийг муж, орон нутгийн түвшинд магадлан итгэмжилдэг.

### 2.3.2. АНУ-ын багш бэлтгэх туршлага

#### АНУ-ын Калифорни муж

Калифорнийн багш мэргэжлийн стандартад (Credentialing, 2009) тухайн мужийн багш нарын хувьд хамгийн сайн туршлага болох зүйлсийг онцлон тусгадаг.

#### Хүснэгт 37. Калифорнийн багшийн мэргэжлийн стандарт

Стандарт	Шалгуур
<b>Бүх сурагчийг суралцахууд татан оролцуулах, дэмжих</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сурагчдыг мэдлэг, чадвараар нь дамжуулан идэвхтэй суралцахууд татан оролцуулах,</li> <li>2. Сурагчдын өмнөх мэдлэг, амьдралын туршлага, сонирхлыг суралцахуудтай нь холбох,</li> <li>3. Хичээлийн агуулгыг бодит амьдралын чухал хам сэдэвтэй холбох,</li> <li>4. Сурагчдын суралцах олон талт хэрэгцээг хангахын тулд олон төрлийн сургалтын стратеги, нөөц, технологийг ашиглах,</li> <li>5. Эрэл хайгуул хийх, асуудал шийдвэрлэх, эргэцүүлэн бодох замаар шүүн тунгаах чадварыг хөгжүүлэх,</li> <li>6. Сурагчийн суралцахууд хяналт тавих, сургалтын явцад тохирох зааварчилгааг өгөх.</li> </ol>
<b>Сурагчийн суралцах үр дүнтэй орчныг бүрдүүлэх, хадгалах</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сурагч бүрд шударга, хүндэтгэлтэй хандан халамжлах, хамт олны дундах нийгмийн хөгжил, хариуцлагыг дэмжих,</li> <li>2. Сурагчийн суралцахуудыг дэмжих, олон талт байдлыг эргэцүүлэх, сурагч хоорондын бүтээлч, үр ашигтай харилцааг хөхиүлэн дэмжих материаллаг эсвэл виртуал сургалтын орчныг бүрдүүлэх,</li> <li>3. Бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүйн таатай сургалтын орчныг бүрдүүлэх, хадгалах,</li> <li>4. Бүх сурагчдад зохих дэмжлэг үзүүлэх, өндөр хүлээлттэй, нягт нямбай сургалтын орчныг бүрдүүлэх,</li> <li>5. Хувь хүний болон бүлэг хамт олны зан үйлийг өндөр түвшинд удирдах, хөгжүүлэх, харилцах, хадгалах,</li> <li>6. Бүх сурагчдын сурч боловсрох эерэг зан үйлийг дэмжсэн уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд хичээлийн дэг журам, дүрэм, хэм хэмжээг тогтоох,</li> <li>7. Сургалтыг оновчтой болгохын тулд сургалтын цагийг үр дүнтэй ашиглах.</li> </ol>
<b>Сурагчийн суралцах хичээлийн агуулгыг ойлгох, зохион байгуулах</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Судлагдахууны агуулга, академик агуулгын стандарт, сургалтын хөтөлбөрийн хүрээний талаарх мэдлэгээ харуулах,</li> <li>2. Сурагчийн хичээлийн агуулгын ойлголтыг баталгаажуулахын тулд сурагчийн хөгжил, ур чадварын талаарх мэдлэгийг хэрэглэх,</li> <li>3. Сурагчийг тухайн сэдвийн агуулгыг ойлгоход дэмжих, чиглүүлэх үүднээс сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах,</li> <li>4. Хичээлийн агуулгад тохирсон сургалтын стратегийг хэрэглэх,</li> <li>5. Агуулгыг бүх сурагчдад ойлгомжтой болгохын тулд нөөц, технологи, стандартад нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах, тохируулах,</li> </ol>

	6. Англи хэлтэй болон тусгай хэрэгцээт сурагчдын хэрэгцээг харгалзан тэгш хүртээмжтэй агуулгаар хангах.
<b>Сурагчдын суралцах туршлагыг харгалзан сургалтыг төлөвлөх, зохиомжлох</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сурагчдын суралцахад бэлэн байдал, хэлний мэдлэг, соёл, хувь хүний хөгжлийн талаарх мэдлэгийг сургалтыг төлөвлөхөд хэрэглэх,</li> <li>2. Сурагчийн суралцахуйн зорилгыг тодорхойлох, илэрхийлэх,</li> <li>3. Сурагчийн суралцахуйд дэмжлэг үзүүлэх урт болон богино хугацааны сургалтын төлөвлөгөөг боловсруулах, эрэмбэлэх,</li> <li>4. Сурагчдын суралцах хэрэгцээг хангахуйц стратегийг тусган сургалтыг төлөвлөх,</li> <li>5. Сурагчдын суралцах хэрэгцээг үнэлж, түүнд нийцүүлэн сургалтын төлөвлөгөө, сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрчлөх.</li> </ol>
<b>Сургалтын үйл явцыг үнэлэх</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнэлгээний төрлүүдийн зорилго, шинж чанар, хэрэглээний талаарх мэдлэгээ хэрэгжүүлэх,</li> <li>2. Сургалтыг хөгжүүлэхийн тулд төрөл бүрийн эх сурвалжаас үнэлгээний өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх,</li> <li>3. Сурагчийн суралцахуйд хяналт шинжилгээ хийхийн тулд бие даан болон хамтран ажиллагсадын хамтаар өгөгдлийг хянах,</li> <li>4. Сургалтын зорилгоо тодорхойлох, сургалтыг төлөвлөх, төрөлжүүлэх, өөрчлөхөд үнэлгээний өгөгдлийг хэрэглэх,</li> <li>5. Сурагчдыг өөрийгөө үнэлэх, зорилгоо тодорхойлох, ахиц дэвшилдээ хяналт тавих үйл ажиллагаанд татан оролцуулах,</li> <li>6. Сурагчийн суралцах үйл ажиллагааг үнэлэх, дүн шинжилгээ хийх, харилцахад туслах боломжит технологийг хэрэглэх,</li> <li>7. Үнэлгээний мэдээллийг хэрэглэн сурагч, тэдний гэр бүлийнхэнд цаг алдалгүйгээр тодорхой ойлгомжтой хариу мэдээлэл, зөвлөгөө өгөх.</li> </ol>
<b>Мэргэшсэн багш болж хөгжих</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сурагчийн суралцах үйл ажиллагаанд дэмжлэг болох сургалтын дадлага туршлагын талаар эргэцүүлэн тусгах,</li> <li>2. Мэргэжлийн зорилгоо тодорхойлж, тасралтгүй, зорилготой мэргэжлийн өсөлт, хөгжлийг хангахад оролцох,</li> <li>3. Багш, сурагчийн сурах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд хамтран ажиллагсад болон мэргэжлийн өргөн хүрээний бүлэг хамт олонтой хамтран ажиллах,</li> <li>4. Сурагчийн сурах үйл ажиллагааг дэмжих зорилгоор гэр бүлтэй нь хамтран ажиллах,</li> <li>5. Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс орон нутгийн олон нийтийг татан оролцуулах,</li> <li>6. Бүх сурагчийг сэдэлжүүлэх, итгэл үнэмшил, тууштай байдлыг хадгалахын тулд мэргэжлийн үүрэг, хариуцлагыг мэддэг байх,</li> <li>7. Мэргэжлийн хариуцлага, шударга, ёс зүйтэй байдлаа харуулах.</li> </ol>

Калифорнид багшийн мэргэжил эзэмшсэн хүмүүс боловсролын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн бакалаврын зэрэгтэй байх, эсвэл сонгосон хичээлүүдээр бакалаврын сургалтад хамрагдаж, дараа нь багшлах чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан байх шаардлагыг тавьдаг.

### ***АНУ-ын Вашингтон муж***

Вашингтон мужийн хууль тогтоох байгууллагаас баталсан боловсролын шинэчлэлийн тухай хуулийн төсөл “E2SSB 6696”-д заасан гүйцэтгэл, хариуцлагын талаар тодорхой тусгасан стандарт, шалгуурууд байдаг. Вашингтон мужийн хууль тогтоох байгууллагаас тодорхойлсон багшийг үнэлж, дүгнэх хамгийн доод шалгуурыг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 38. Вашингтон мужийн боловсролын стандарт*

<b>Стандарт</b>	<b>Тайлбар</b>
<b>Багшлах чадвар</b>	Өдөр тутмын хичээлийг чадварлаг төлөвлөх, заах, үүнийг

	хэрэгжүүлэх зохих мэдлэгтэй болохоо харуулах
<b>Анги танхимын зохион байгуулалт</b>	Багш нь ангийнхаа орчныг зохион байгуулж чаддаг байх
<b>Мэргэжлийн бэлтгэл, тэтгэлэг</b>	Багш нь боловсролын онолын мэдлэгтэй, мэргэжилдээ үнэнч байхыг харуулдаг
<b>Шаардлагатай үед сайжруулалт хийх хичээл зүтгэл</b>	Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн өсөлтийг харуулдаг
<b>Сурагчийн сахилга бат, ирцийн асуудлыг шийдвэрлэх</b>	Багш сургалтын нөхцөл байдал дахь хүний тогтвортой бус, урьдчилан төлөвлөгдөөгүй үйлийг зохицуулах чадвартай байх
<b>Сурагчдад хичээл заах сонирхол</b>	Багш бүх сурагчийнхаа суралцах үйлд идэвх зүтгэл гарган бие сэтгэлээ зориулдаг байх
<b>Хичээлийн агуулгын талаарх мэдлэг</b>	Зааж буй хичээлийн агуулгын талаар зохих мэдлэг, ур чадвартай байх

Багш боловсролын бүх хөтөлбөрийг Вашингтон мужийн Ахиц амжилтын Зөвлөлөөр батлуулсан байх ёстой. Вашингтон мужид багшаар ажиллахын тулд хамгийн багадаа дөрвөн жилийн бакалаврын зэргийн сургалт, хорь гаруй магадлан итгэмжлэгдсэн коллеж, мужийн тусгай зөвшөөрлийн дагуу коллеж, их сургуулийн хэрэгжүүлдэг багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдах шаардлагатай. Вашингтон мужид хүлээн зөвшөөрөгдсөн багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй хүмүүс тохирох онооны дундажтай байхаас гадна үндсэн ур чадварын шалгалтад тэнцсэн байдаг.

### 2.3.3. Нэгдсэн Вант Улсын багш бэлтгэх туршлага

Нэгдсэн Вант Улс ньбагшийн стандартыг 2011 оноос мөрдөж эхэлсэн. Стандартад Мэргэшсэн багшийн статус (QTS) бүхий багш нарын хүрсэн хамгийн минимум туршлагыг тусгасан байдаг.

*Хүснэгт 39. Английн багш нарын стандарт*

Стандарт	Шалгуур
<b>Багшлахуй</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сурагчдыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх, өөрсдийгөө туршин сорих, хүлээгдэж буй үр дүнг томъёолох,</li> <li>2. Сурагчдын гаргасан ахиц дэвшил, эерэг үр дүнг сурталчлах,</li> <li>3. Судлагдахуун, сургалтын хөтөлбөрийн талаар мэдлэг сайтай болохоо харуулах,</li> <li>4. Зохион байгуулалт сайтай хичээлийг төлөвлөх, заах,</li> <li>5. Сурагчдын давуу тал, хэрэгцээнд нийцүүлэн заах аргаа тохируулах,</li> <li>6. Үнэлгээг зөв, үр бүтээлтэй хэрэглэх,</li> <li>7. Сургалтын ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэхийн тулд зан үйлийг үр дүнтэй удирдан зохион байгуулах,</li> <li>8. Мэргэжлийн үүрэг хариуцлагыг илүү өргөн хүрээнд биелүүлэх.</li> </ol>
<b>Хувийн болон мэргэжлийн төлөв байдал</b>	<ol style="list-style-type: none"> <li>9. Багш нар тухайн мэргэжилд итгэх олон нийтийн итгэлийг дээдэлж, сургуулийн дотор болон гадна ёс зүй, зан үйлийг өндөр түвшинд баримтлах,</li> <li>10. Багш ажиллаж буй сургуулийнхаа ёс зүй, бодлого, үйл ажиллагааг зохих ёсоор, мэргэжлийн түвшинд авч үзэж, ирц, цагийг ягштал баримтлах,</li> <li>11. Багш нар мэргэжлийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон хууль тогтоомжийн талаар ойлголттой байж, түүний хүрээнд ажиллах.</li> </ol>

Бага, дунд боловсролын багш бэлтгэх сургалтын хугацаа 4 жил, үүнд бакалаврын зэрэг олгох 3-аас багагүй жил (академик сургалт), багш бэлтгэх сургалт (ИТТ) 1 жил (сурган хүмүүжүүлэх сургалт / дадлага) байдаг. Багш бэлтгэх боловсролын хөтөлбөрт оюутан сонгон шалгаруулахдаа голчлон үнэлгээний онооны нийлбэрийг харгалзан үздэг.

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг Багшийн стандарт (2011)-д нийцүүлэн боловсруулдаг. Дадлагажигч багш нарыг уг стандартыг хангаж буй эсэхээр үнэлдэг байна. Багш бэлтгэх дээд боловсролын сургалтын агуулга нь ерөнхий боловсролын сургалтын цөм агуулгын хүрээтэй уялдах ёстой байдаг. Бага, суурь боловсролын багш бэлтгэх боловсролын багшлах дадлагын үргэлжлэх хугацааны хувьд долоо хоногт 15 цаг байхаар санал болгодог.

#### ***2.3.4. Ирландын багш бэлтгэх туршилага***

Бага боловсролын багш бэлтгэх сургалтын дөрвөн жилийн бакалаврын хөтөлбөрөөр (ISCED 6) суралцан эзэмшинэ Бакалаврын зэргийн хөтөлбөрийг дүүргээд, боловсролын мэргэжлийн магистрын хөтөлбөрөөр (ISCED 7) нийт 6 жил суралцан эзэмших боломжтой. Бага боловсролын багш бэлтгэх бакалаврын хөтөлбөрт хамрагдах оюутнуудыг ерөнхий боловсролын сургуулийн шалгалтын дүнд үндэслэн сонгодог бөгөөд ирланд, англи хэл, математикийн хичээлээр авбал зохих минимум үнэлгээ болон бусад академик шаардлагыг хангасан байх ёстой.

Бага боловсролын багш бэлтгэх сургалтад амжилттай хамрагдсан нэр дэвшигчдийн хувьд багшлах дадлагад тохирох эсэхийг тодорхойлох нэмэлт үйл явц байдаг. Үүнд:

1. Магадлах шалгалт: Дээд боловсролын байгууллага оюутнуудыг бүртгэхээс өмнө багш боловсрол эзэмшихээр суралцах бүх оюутнууд ял шийтгэл эсвэл эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг тогтоох магадлах шалгалтад хамрагддаг. Хэрэв ял шийтгэл хүлээж байсан нь нотлогдвол тухайн оюутныг хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах эсэхийг шийдүүлэхээр асуудлыг дээд боловсролын байгууллагын дэргэдэх Хяналтын хороонд шилжүүлдэг.
2. Эрүүл мэндийн шаардлага: Зарим дээд боловсролын сургалтын байгууллага багш боловсрол эзэмших оюутныг суралцаж буй хичээлийн шаардлагыг хангах, тэдний чадамжид сөргөөр нөлөөлж болзошгүй өвчин, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох эрүүл мэндийн мэдээллийн маягтыг бөглөхийг шаарддаг. Оюутанд бүрэн эсвэл хэсэгчилсэн байдлаар эрүүл мэндийн ноцтой байдал, хөгжлийн бэрхшээл, эсвэл сэтгэлзүйн асуудал илэрсэн тохиолдолд тэднийг ганцаарчилсан үзлэг, үнэлгээнд хамруулан, боломжит нөхцөлийг бүрдүүлвэл тухайн оюутныг үргэлжлүүлэн суралцуулдаг.

Бага боловсролын багш бэлтгэх бакалаврын сургалтаа дүүргэсэн оюутнууд хүсвэл шалгалт өгч дараагийн шатны буюу боловсролын мэргэжлийн магистр (PME) хөтөлбөрт хамрагдах боломжтой. Бага боловсролын багш бэлтгэж буй ихэнх коллежид сурган хүмүүжүүлэх чиглэлээр дипломын ажил бичих шаардлагатай. Цөөн тооны коллежид оюутнуудыг сурган хүмүүжүүлэх сэдвээр дипломын ажил бичихийн оронд сонгон суралцах курст хамрагдах боломжийг олгодог. Бага боловсролын багш бэлтгэх бакалаврын хөтөлбөрт хамрагдах дөрвөн жилийн хугацаанд дунджаар 30 долоо хоногийн багшлах дадлага хийдэг. Харин бакалаврын хөтөлбөрийг дүүргэсний дараа боловсролын магистрын сургалтад хамрагдах бөгөөд багшлах дадлагын хугацаа сургуулиудад харилцан адилгүй, 11 долоо хоногоос 24 долоо хоног хүртэлх хугацаатай байдаг.

#### ***2.3.5. Канад улсын багш бэлтгэх туршилага***

Канад улсын муж бүр боловсролын асуудлаа хариуцдаг. Онтариогийн Боловсролын яам нь боловсролын асуудлыг эрхлэх үүрэгтэй бөгөөд Онтарио Багшийн коллеж багшлах эрх олгох

асуудлыг хариуцдаг. Хувийн сургуулиумөн Боловсролын яамнаас гаргасан дүрэм журмыг мөрдөх ёстой. Онтарио Багшийн коллежоос (2016) багшлах мэргэжлийн дадлагын стандартад багш нарын эзэмших чадамж, үр дүнг тусган тодорхойлдог. Уг стандартыг боловсруулахдаа дэлхийн улс орнуудын стандартуудыг судалж, Онтарио мужид тохирох онцлог чиглэлүүдээр тодорхойлсон байна.

Хүснэгт 40. Багшлах мэргэжлийн дадлагын Онтариогийн стандарт

Домэйн	Чадамж
<b>Суралцагч, суралцахуйн талаарх үүрэг, амлалт</b>	Багш нар бүх сурагчийн сайн сайхан байдал, хөгжлийн төлөөх үүрэг, амлалт авдаг байх,
	Багш нар сурагчдын суралцахуй, сурлагын ахиц амжилтад дэмжлэг үзүүлэх, сургахын төлөө хичээл зүтгэл гаргадаг байх,
	Багш нар бүх сурагчдад эрх тэгш, хүндэтгэлтэй ханддаг байх,
	Багш нар сурагчдыг асуудал шийдвэрлэгч, шийдвэр гаргагч, насан туршдаа суралцагч, өөрчлөгдөж буй нийгэмд хувь нэмрээ оруулах гишүүн байхад нь урамшуулах сурах орчныг бүрдүүлдэг байх.
<b>Мэргэжлийн мэдлэг</b>	Багш хариуцсан хичээл судлагдахуун, Онтариогийн сургалтын хөтөлбөр, боловсролтой холбоотой хууль тогтоомжийг мэддэг байх,
	Багш үр дүнтэй сургах, үнэлэх олон төрлийн аргыг мэддэг байх,
	Багш анги танхимыг үр дүнтэй удирдан зохион байгуулах олон төрлийн арга стратегийг мэддэг байх,
	Багш сурагчид хэрхэн суралцдаг, сурагчдын суралцахуй, сурлагын ахиц амжилтад нөлөөлөх хүчин зүйлсийг мэддэг байх.
<b>Багшлах дадлага</b>	Багш сурагчдынхаа суралцахуй, сурлагын ахиц амжилтыг дэмжихийн тулд сурагч, сургалтын хөтөлбөр, хууль тогтоомж, багшлах туршлага, анги танхимын зохион байгуулалтын арга стратегийн талаарх мэргэжлийн мэдлэг, ойлголтоо хэрэглэдэг байх,
	Багш сурагчид, эцэг эх, хамтран ажиллагсадтайгаа үр дүнтэй харилцдаг байх,
	Багш сурагчдын ахиц дэвшлийн үнэлж, ахиц амжилтын талаар үнэлгээ дүгнэлт гарган, үр дүнг сурагч, эцэг эхчүүдэд тогтмол мэдээлдэг байх,
	Багш төрөл бүрийн эх сурвалж, нөөцийг ашиглан тасралтгүй суралцах, эргэцүүлэн бодох замаар заах ур чадвараа тохируулан сайжруулдаг байх,
	Багш сургалтын үйл ажиллагаа болон мэргэжлийн холбогдох чиг үүргийн үйл ажиллагаанд зохих технологийг ашигладаг байх.
<b>Манлайлал ба хамтын ажиллагаа</b>	Багш анги танхим, сургуульдаа суралцагч хамт олныг бүрдүүлж, тогтвортой байлгахын тулд бусад багш, сургуулийн ажиллагсадтай хамтран ажилладаг байх,
	Багш нар сурагчдын суралцахуй, сурлагын ахиц амжилт, сургуулийн хөтөлбөрийг сайжруулахын тулд мэргэжлийн хүмүүс, эцэг эх, олон нийтийн төлөөлөлтэй хамтран ажилладаг байх.
<b>Мэргэжлийн чиглэлээр тасралтгүй суралцахуй</b>	Багш нар мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтад хамрагдаж, заах ур чадвараа сайжруулахад хэрэглэдэг байх.

Багшийн мэргэжлийн дадлагын стандартаас гадна Онтариогийн Багшийн коллежоос гаргасан Багшийн мэргэжлийн ёс зүйн дөрвөн стандарт байдаг: (1) Асран халамжлах, (2) Хүндэтгэл, (3) Итгэл үнэмшил, (4) Нэгдмэл байдал (Teachers, Ethical Standards, 2016).

Онтариод багш бүрэн дунд боловсролоо дүүргэсний дараа урлаг, байгалийн ухаан, нийгмийн ухаан гэх мэт олон чиглэлээр бакалаврын зэрэг олгох 3-4 жилийн сургалтад хамрагдаж, боловсролын бакалаврын зэрэг олгох нэг жилийн (хоёр семестр) сургалтыг дүүргэсэн байх ёстой. 2015 оны 9 дүгээр сард Онтариогийн боловсролын факультетуудад

багш бэлтгэх хөтөлбөрөөр суралцах хугацааг хоёр жил (дөрвөн семестр) болгон, дадлагын хугацааг 40 хоногоос 80 хоног болгон тус тус нэмэгдүүлсэн. Үндсэн агуулгын зэрэгцээ сэтгэцийн эрүүл мэнд болон сайн сайхан байдал, олон талт байдал, дижитал сурган хүмүүжүүлэх ухаанд ихээхэн анхаарал хандуулдаг байна (Federation). Багш улсын төсвөөс санхүүждэг сургуульд ажиллахын тулд Онтариогийн Багшийн коллежийн Мэргэшилийн болон багшлах эрхийн ерөнхий гэрчилгээ эсвэл шилжилтийн гэрчилгээтэй байх шаардлагатай (Education O. M., 2016). Гэрчилгээ нь нэг жилийн хугацаатай лиценз юм. Шилжилтийн гэрчилгээг багш бэлтгэх хөтөлбөрөө хараахан дуусгаагүй байгаа багш нар авч болох ба тэд сургалтаа дүүргэсний дараа ерөнхий гэрчилгээг авах боломжтой болно (Teachers, Types of Teaching Certificates, 2016). Шилжилтийн гэрчилгээ нь зургаан жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд хугацааг сунгаж болдог.

Онтариогийн багшид гэрчилгээ олгох урьдчилсан нөхцөл:

- Хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад дээд боловсрол олгох (хамгийн багадаа) гурван жилийн сургалтад хамрагдан төгссөн байх;
- 2 жилийн буюу 4 семестрийн туршид багш бэлтгэх хөтөлбөрийг дүүргэсэн байх;
- Багшлах эрхийн бүртгэлийн болон гишүүнчлэлийн хураамжийг төлсөн байх;

Эдгээр шаардлагыг бүрэн хангаагүй хувь хүмүүс тодорхой нөхцөлтэй гэрчилгээ авах боломжтой. Онтарио Багшийн коллеж нь сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үүрэгтэй бөгөөд эдгээр курс нь багш нарт дээр дурдсан стандартад нийцсэн ур чадвар олгодог эсэхийг баталгаажуулдаг (Teachers, Program Accreditation, 2016).

### 2.3.6. Шинэ Зеланд улсын багш бэлтгэх туршлага

Шинэ Зеландын Боловсролын яам нь сургалтын стандартыг Боловсролын зөвлөл (ECNZ)-тэй хамтран тогтоодог. Тус зөвлөл багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, багшлах эрх олгох, гүйцэтгэл, хөгжлийн үнэлгээний стандартыг тогтоох үүрэгтэй. Шинэ Зеландын Боловсролын зөвлөлөөс сургууль төгсөгч, дадлагажигч багш нарт зориулсан багшийн стандартыг гаргасан байдаг. Багш бэлтгэх боловсролын байгууллагууд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд нь төгсөх ангийн багшийн стандартад нийцэх байдлыг үнэлж харуулах шаардлагатай. Гарааны багш мэргэжлийн мэдлэг, дадлага, үнэ цэн, харилцааны чиглэлээр мэдлэг, ур чадвартай байх ёстой.

Хүснэгт 41. Шинэ Зеландын гарааны багшийн стандарт

Домэйн	Стандарт
<b>Мэргэжлийн мэдлэг</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Гарааны багш юу заахаа мэддэг байх,</li> <li>2. Гарааны багш сурагчийнхаа хэрхэн суралцдаг талаар мэддэг байх,</li> <li>3. Гарааны багш суралцахуй, багшлахуйд нөхцөл байдал хүчин зүйлс хэрхэн нөлөөлдгийг ойлгодог байх.</li> </ol>
<b>Мэргэжлийн дадлага</b>	<ol style="list-style-type: none"> <li>4. Гарааны багш аюулгүй, өндөр чанартай сурах, сургах орчныг төлөвлөхөд мэргэжлийн мэдлэгээ хэрэглэдэг байх,</li> <li>5. Гарааны багш суралцахуйг дэмжихийн тулд нотлох баримтыг хэрэглэдэг байх.</li> </ol>
<b>Мэргэжлийн үнэ цэн ба харилцаа</b>	<ol style="list-style-type: none"> <li>6. Гарааны багш суралцагч болон нийгмийн бусад бүлэг, оролцогч талуудтай эерэг харилцааг хөгжүүлдэг байх,</li> <li>7. Сургуулиа төгсөх багш нар тухайн мэргэжилдээ бие сэтгэлээ зориулан ажилладаг гишүүд байх.</li> </ol>

Шинэ Зеландад багш бэлтгэх боловсролын 156 батлагдсан хөтөлбөрийг 80 мэргэшсэн чиглэлээр 25 сургалтын байгууллага хэрэгжүүлдэг байна. Багш нар суралцах чиглэлээс хамааран бакалаврын зэргийн (3 эсвэл 4 жилийн хугацаанд бага, дунд боловсрол), дипломын (3 жилийн хугацаанд сургуулийн өмнөх боловсрол), эсвэл нэг жилийн дипломын сургалтаас сонгох боломжтой. Сургуулийн өмнөх болон бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөр нь ихэвчлэн 3 жил байдаг. Ерөнхий боловсролын сургуулийн багш болох хүмүүс нь дунд боловсролын түвшинд судлах хичээл судлагдахууны чиглэлээр бакалаврын зэрэг эзэмшээд, нэг жилийн багшлах мэргэшлийн сургалтад хамрагддаг.

Шинэ Зеландын Боловсролын зөвлөлийн магадлан итгэмжлэлийн мэргэжлийн комисс нь их сургуулийн хөтөлбөрүүдийг баталгаажуулдаг бөгөөд шинэ хөтөлбөрүүдийг жил бүр в3, 4 жил хэрэгжсэний дараа хоёр жилд нэг удаа бичгээр ирүүлсэн тайлангийн хамт хянадаг. Хөтөлбөрийг зургаан жил хэрэгжүүлсний дараа бага зэрэг өөрчлөх, ирээдүйн төсөл гаргахад зориулж хянан дүгнэлт гаргадаг байна. Багш бэлтгэх боловсролын бүх хөтөлбөр сургууль төгсөх багшийн стандартад нийцсэн байх ёстой байдаг (ECNZ, 2015).

Багш бэлтгэх боловсролын хөтөлбөрөөр суралцан төгсөгч нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг хангалттай гүнзгийрүүлэн судалсан байх ёстой талаар багш бэлтгэх боловсролд тавих шаардлагад тусгадаг бөгөөд сургалтын байгууллагууд уг шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн зохион байгуулалтын асуудлаа шийддэг. Зарим хөтөлбөрүүд хэд хэдэн курсийн академик / судлагдахууны боловсролын агуулгыг сурган хүмүүжүүлэх заах арга зүйн сургалттай нэгтгэдэг бол зарим нь тодорхой судлагдахууныг онцолсон сургалт явуулдаг. Бага боловсролын багш бэлтгэх боловсролын хөтөлбөрт үндэсний сургалтын хөтөлбөрийн бүх хичээлийг хамруулдаг. Багшлах мэргэжлийн дадлагын хичээлийн үргэлжлэх хугацаа нь 1-2 жилийн хөтөлбөрт 80 хоног, 3 жилийн хөтөлбөрт 120 хоног байдаг.

### ***2.3.7. Финлянд улсын багш бэлтгэх туршлага***

Багш бэлтгэх боловсролын зохион байгуулалтын голлох загвар нь тодорхой чиглэлээр мэргэшсэн багшийг бэлтгэх бөгөөд сургалтын хэлбэрийн хувьд танхим, онлайн, холимог хэлбэртэй байдаг. Сургалтын болон дадлагын үргэлжлэх хугацааг багасгах боломжтой, багшлах дадлагын үргэлжлэх хугацааг хуульчлан заагаагүй байдаг учраас сургалтын байгууллагуудын хувьд харилцан адилгүй, ялгаатай байдаг.

Багш бэлтгэх боловсролд элсэгчдийн сонгон шалгаруулалтад ерөнхий боловсролыг дүүргэсэн голч оноо, бүрэн дунд боловсролын шалгалтын дүн, мөн мэргэжлийн онцлог бүхий элсэлтийн шалгалтыг өгч болно. Түүнчлэн ярилцлагыг оюутны ур чадварыг үнэлэх чухал хэсэг болгон зохион байгуулдаг бөгөөд үүнийг тухайн сургалтын байгууллага бие даан шийдэх боломжтой. Багш бэлтгэх сургалтын элсэлт нь ерөнхийдөө ур чадварын шалгалтыг багтаасан бөгөөд элсэгчийн тухайн мэргэжилд тохирох эсэх, ур чадвар, хүсэл эрмэлзэл, тууштай байдлыг мөн харгалзан үздэг. Харин мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нарыг элсүүлэн сургахдаа тэдний багшлахуйн туршлага, тасралтгүй мэргэжил дээшлүүлсэн байдал, судалгаа шинжилгээ, олон улсын туршлага гэх мэт давуу талыг харгалздаг байна. Зарим сургалтын байгууллагуудын хувьд ажиллаж байгаа багш нарт зөвлөн туслах чиглэлээр сургалт явуулдаг. Финлянд улсын хувьд багшийн мэргэжлээр ажиллах арга замуудыг санал болгодог. Тухайлбал, түр хугацаагаар багшлах боломж байдаг.

Тодорхой чиглэлээр мэргэшээгүй хүн ажиллангаа багшлах сургалтад хамрагдах боломжтой байдаг хэдий ч суралцах хугацаандаа зөвхөн түр зуурын ажлын байраар хангагддаг.

### *2.3.8. Шведийн багш бэлтгэх туршлага*

Багш бэлтгэх боловсролын зохион байгуулалтын загварыг дээд боловсролын сургалтын байгууллагууд бие даан шийддэг. Багш бэлтгэх сургалтын хугацаа нь мэргэшсэн чиглэлээс хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, бага боловсролын багшийг 3-4 жил, судлагдахууны чиглэлээс хамаарч суурь боловсролын түвшинд 4-4.5 жил, бүрэн дунд боловсролын түвшинд 5-5.5 жил хүртэл үргэлжилдэг байна.

Сургалтын агуулгын хувьд 1-3-р ангид багшлах суралцагч зургаан хичээл, 4-6-р ангид багшлах суралцагч дөрвөн хичээлийг заавал судлах шаардлагатай. Түүнээс гадна суралцагчид нэмэлтээр 3 хичээл эсвэл 1-2 практик, гоо зүйн хичээлийг сонгох боломжтой. Бага, суурь боловсролын багш болох суралцагч 2-3 хичээл, бүрэн дунд боловсролын багш болох суралцагч 2 хичээлийг сонгон судалдаг. Багшлах дадлагыг 1 семестрийн хугацаанд (дунджаар 20 долоо хоног) гүйцэтгэнэ.

Багш бэлтгэх боловсролд элсэн ороход шаардагдах БОУСА (ISCED)-ийн доод түвшний мэргэшлийн түвшинг хангах ёстой. Өөрөөр хэлбэл, бүрэн дунд боловсролын багш нарын хувьд өргөдөл гаргагчид элсэхдээ тухайн мэргэших чиглэлээр тодорхой мэдлэгийг аль хэдийн эзэмшсэн байна гэсэн үг. Элсэлтийн сонгон шалгаруулалтын хувьд өргөдөл гаргагч нь заавал өрсөлдөөнт шалгалт өгөх шаардлагагүй бөгөөд тухайн хөтөлбөрт өрсөлдөгч олон байгаа тохиолдолд нийт суудлын эхний гуравны нэгээс доошгүй нь Шведийн сургуульд элсэн суралцах чадварын шалгалтын (Swedish Scholastic Aptitude Test) онооны үндсэн дээр, дараагийн гуравны нэг хэсгийг сургуулийн эцсийн дүнгээр хуваарилдаг бол үлдсэн гуравны нэг хэсгийг дээд боловсролын сургалтын байгууллагаас шийдвэрлэж болох өөр сонголтын шалгуурыг үндэслэн хуваарилах боломжтой байдаг. Тухайлбал, дээд боловсролын сургалтын байгууллага (Jönköping University) голч онооны нэмэлт болгон стандарчилсан тестийг ашигладаг бөгөөд ярилцлага нэг хэсэг нь болдог. Элсэлтийн ерөнхий шаардлагуудаас гадна тухайн салбарт элсэлтийн тусгай шаардлагууд байдаг. Өргөдөл гаргагчийн тоо өндөр байгаа тохиолдолд сонгон шалгаруулалт явагдана. Өргөдөл гаргагчдыг суралцах чиглэлээр нь бүлэглээд тэднийг ур чадварын дагуу эрэмбэлдэг бөгөөд хамгийн өндөр эрэмбэлэгдсэн нэр дэвшигчдийг элсүүлнэ.

Багшийн мэргэжлийн мэргэшлийн тодорхойлолтыг Засгийн газар албан ёсоор шийдвэрлэдэг бөгөөд багш боловсролын чиглэлээр төгссөн даруйдаа багшлах боломжтой байдаг. Гэхдээ байнгын ажлын байраар хангагдахын тулд багш нар Боловсролын үндэсний газраас багшлах эрхийн гэрчилгээ авах хүсэлтийг гаргадаг бөгөөд ихэнх төгсөгчид багшилж эхлэхээсээ өмнө энэхүү гэрчилгээ авах хүсэлт гаргадаг. Багш боловсролын хөтөлбөрт хамрагдах өөр хэд хэдэн нөхцлүүд байдаг. Тухайлбал, Шведийн боловсролын тухай хуульд сургуулийн зохион байгуулагч, менежер нь багш боловсролын хөтөлбөрт хамрагдсан байх ёстой гэж заасан байдаг. Элсэлтийн хөтөлбөрүүдийн үргэлжлэх хугацаа нь нэг хичээлийн жил буюу хоёр улирал, нийтдээ арван сар байна. Сургуулийн зохион байгуулагч, менежер нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах үндсэн үүрэгтэй бөгөөд үндсэн багш нь зөвхөн Боловсролын үндэсний газраас олгосон багшлах эрхийн гэрчилгээтэй, бүрэн мэргэшсэн багш байх ёстой. Түүнээс гадна багшийн мэргэжилд хүрэх өөр арга замууд бий. Тухайлбал, тодорхой чиглэлээр суралцахын тулд тухайн чиглэлээр өмнө нь суралцсан, ажлын туршлагатай байх шаардлагатай. Жишээ нь, нэмэлт боловсролын хөтөлбөр (Kompletterande

pedagogisk utbildning; KPU), гадаад багш, судлаач, их, дээд сургуулийн төгсөгчдөд зориулсан нэмэлт боловсрол (Kompletterande utbildning för personer med utländsk lärarutbildning; ULV болон Professional QualificationäxautsakralVse avc. VAL) зэргийг нэрлэж болно. ULV болон VAL хөтөлбөрт хамрагдан суралцах хугацаа нь тухайн хүний өмнө эзэмшсэн мэдлэг, багшийн ажлын туршлага, судалсан академик курс, дүүргэсэн багц цагаас хамаарна.

### ***2.3.9. Нидерландын багш бэлтгэх туршлага***

Багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэх эрх нь их, дээд сургуулиудын хувьд чөлөөтэй байдаг. Ерөнхий боловсролын сургуулийн багш болох хүмүүс эхлээд тодорхой сэдвээр магистрын зэрэг хамгаалсан эсвэл тухайн чиглэлээр бакалаврын зэрэгтэй суралцдаг.

Багш боловсролын чиглэлээр элсэгчдийг сонгон шалгаруулахдаа урлаг, биеийн тамирын чиглэлээр суралцагчдыг мэргэжлийн авьяас, чадварыг үнэлдэг бол бага боловсролын багш болох суралцагчид зөвхөн ерөнхий боловсролын (HAVO) диплом эсвэл мэргэжлийн боловсролын эзэмшсэн оюутнуудад зориулсан стандарт тестүүдээр үнэлэгддэг. Сургуулийн өмнөх (4-өөс дээш насны) болон бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөрийн оюутнууд сургалтын эхний жил дуусахаас өмнө тооны шалгалт өгөх ёстой. Харин бүрэн дунд боловсролын багш бэлтгэх хөтөлбөрийн хувьд мэргэших хичээлийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх ёстой. Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд Фландерсийн магадлан итгэмжлэх байгууллагаар (The Accreditation Organization of the Netherlands and Flanders) баталгаажих ёстой.

Сургууль бүр элсэлтийн хөтөлбөрөө хэрхэн хөгжүүлэхийг сонгох эрх чөлөөтэй байдаг тул сургуулийн удирдлага уг хөтөлбөрийг хариуцдаг. Багшийн мэргэжлээр ажиллах боломжийг авч үзвэл 2020-2021 оны хичээлийн жилд 1800 орчим хүн суралцсан байна. Зарим хүмүүсийн хувьд багш боловсролын хөтөлбөрт хамрагдахгүйгээр багшлах боломжтой байдаг бөгөөд эдгээр элсэгчдэд тусгайлан бэлтгэсэн сургалтыг дүүргэж, зохих шалгалтыг өгдөг байна. Энэхүү шалгалтаар багшид байх ёстой шаардлагатай ур чадвар байгаа эсэхийг үнэлдэг бөгөөд хангалттай үнэлэгдсэн тохиолдолд багшлах бүрэн боломжтой болдог.

### ***2.3.10. Эстон улсын багш бэлтгэх туршлага***

Багш бэлтгэх боловсрол нь үндсэндээ Мэргэжлийн тухай хууль болон мэргэжлийн мэргэшлийн стандарт гэсэн хоёр баримт бичгээр зохицуулагддаг. Эдгээр баримт бичгүүд нь агуулга, хэрэгцээ, зохион байгуулалт болон бусад дүрэм журмын өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэж байдаг. Уг хууль, эрх зүйн актын дагуу мэргэжлийн стандартад заасан чадамжийн шаардлагыг сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тусгасан бол сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн стандартад нийцсэн гэж үздэг.

Одоогийн байдлаар ерөнхий боловсролын багш бэлтгэх сургалт нь 5 жилийн бакалаврын хөтөлбөрөөс 2 жилийн магистрын хөтөлбөрөөр хэрэгжүүлэхээр болсон нь багшийн хомсдолыг шийдвэрлэхэд тусална гэж үзжээ. Багш бэлтгэх хөтөлбөрийн хувьд ирээдүйн бүх багш нарын мэргэших чиглэлээс үл хамааран нийтлэг агуулгыг судлана гэж заасан. Үүнд, ерөнхий боловсролын судалгаа; тухайн судлагдахууны дагуу гүйцэтгэх эрдэм шинжилгээ, судалгааны ажил; дадлага (багшлах, дидактик судалгаа); сурган хүмүүжүүлэх судалгаа зэрэг юм. Багшлах дадлагын хувьд тухайн дээд боловсролын сургалтын байгууллагуудын эрдмийн эрх чөлөө, бие даасан байдалтай холбоотойгоор агуулга, багц цагийн хэмжээ, сургалтын ачааллын хувьд ялгаатай байдаг. Бага, суурь боловсролын багш бэлтгэх хөтөлбөр нь

магистрын түвшинд хэрэгждэг байна. Бакалаврын түвшинд судалсан байх ёстой хичээл, агуулга нь магистрын хөтөлбөрт элсэхэд хангалттай эсэх, эсвэл нэмэлтээр агуулга судлах шаардлагатай эсэхийг тодорхойлдог. Магистрын түвшинд сурган хүмүүжүүлэх чадвар, чадамжийг эзэмшдэг. Багш бэлтгэх хөтөлбөрөөр элсэгчдийг сонгон шалгаруулахдаа дээд боловсролын сургалтын байгууллагаас боловсруулан гаргасан дүрэм, журам, агуулгын дагуу шалгалтыг зохион байгуулдаг. Бага боловсролын багшийг 5 жилийн хөтөлбөрөөр бэлтгэж байна. Харин энэ тохиолдолд ямар төрлийн шалгалт шаардлагатай болох нь тухайн сургалтын байгууллагын шийдэх асуудал байдаг.

Эстон улсын боловсролын асуудал хариуцсан, төрийн бие даасан мэргэшлийн байгууллага (агентлаг) ажилладаг. Энэхүү байгууллага нь багш бэлтгэх шаардлага, багш боловсролын агуулгын хүрээг хоёуланг нь тогтоосон дээд боловсролын стандартыг тогтоох, мэргэжлийн ур чадварын стандартыг баталж, Эстонийн ур чадвар, хөдөлмөрийн зах зээлийн таамаглал, дүн шинжилгээ хийх системийг мөн хариуцдаг.

Багш нарын мэргэжлийн байгууллага, холбоод багшийн мэргэшлийн хүрээг тогтооход зөвлөн туслах, цаашлаад дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөтөлбөрийн хороонд төлөөлөн оролцож, сургалтын хөтөлбөр боловсруулахад идэвхтэй оролцдог. Харин багшийн мэргэжлээр ажиллах хүсэлтэй хүмүүс магистрын зэрэгтэй багшийн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах эсвэл тухайн хөтөлбөрт элсэхээсээ өмнө магистрын зэрэгтэй байсан бол мэргэжлийн шалгалт өгч, тухайн багшийн мэргэжлийн мэргэшлийн стандартад заасан ур чадвараа нотлох боломжтой.

### ***2.3.11. Бүгд Найрамдах Солонгос улсын багш бэлтгэх туршлага***

Багшийн мэргэжил нь тус улсад өндөр статустай мэргэжилд тооцогддог бөгөөд БНСУ-ын багш нар ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дунд харьцангуй өндөр орлоготойд тооцогдоог. (OECD, Indicator D3. How much are teachers paid, 2014). Багш бэлтгэх хөтөлбөрт элсэх элсэлтийн шалгалт маш өрсөлдөөнтэй бөгөөд ахлах сургууль төгсөгчдийн шилдэг 5хувь нь бага боловсролын багш бэлтгэх коллежид элсэх эрхтэй байдаг (NCEE).

Бага боловсролын багшийг багшийн коллежид, дунд боловсролын багшийг их сургуулиар 4 жилийн хугацаанд бэлтгэдэг. Багш хөтөлбөрөөр суралцагчдын мэргэшлийн чиглэл, ажиллах боловсролын түвшнээс үл хамааран мэргэжлийн хичээлийг 12 ба түүнээс дээш багц цагаар судалсан байх ёстой. Үүнд: Боловсролын удиртгал; Боловсролын философи ба түүх; Сургалтын хөтөлбөрийн онол; Боловсролын үнэлгээ; Сургалтын арга зүй, боловсролын технологи; Боловсролын сэтгэл зүй; Боловсролын социологи; Боловсролын удирдлага ба менежмент; Зөвлөн чиглүүлэх зэрэг агуулга ордог. Мэргэшлийн 3 хичээлийг 6 багц цагаар судална. Үүнд, Тусгай боловсролын удиртгал; Боловсрол судлалын дадлага; Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сурагчдыг ойлгох зэрэг агуулга багтана. Багшлах дадлагаар 4 ба түүнээс дээш багц цагийг дүүргэсэн байх бөгөөд багшлах дадлага (лекцийн хичээл, ажлын байран дээрх сургалт); Боловсролын чиглэлээр зөвлөн чиглүүлэх гэсэн агуулгыг багтаадаг.

Сургуулиа амжилттай төгссөн тохиолдолд бакалаврын зэрэг олгох бөгөөд төгсөгчид багшийн албан тушаалд томилогдохын өмнө үндэсний хөдөлмөрийн шалгалтанд тэнцсэн байх ёстой. Тус шалгалт нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд зөвхөн шилдэг төгсөгчид хоёрдугаар шатанд шилжинэ. Шалгалтын эхний бүрэлдэхүүн хэсэг нь боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан (30 хувь) болон тухайн судлагдахууны агуулга (70 хувь) зэргээс бүрдсэн бичгийн шалгалт юм. Хоёрдахь бүрэлдэхүүн хэсэг нь эссэ, богино хэмжээний

ярилцлага байдаг (KEDI, Country Background Report for Korea, 2010). Эдгээр үнэлгээний үр дүнг үндэсний болон орон нутгийн түвшинд багшийн сонгон шалгаруулалт, томилгоог тодорхойлоход ашигладаг (KEDI, Country Background Report for Korea -, 2010). Багшийн мэргэжлээр ажиллахдаа багшлах эрхийн гэрчилгээг шалгалтын болон шалгалтын бус хэлбэрээр авах боломжтой. Үүний тулд дараах 2 шалгуурын аль нэгийг хангасан байх ёстой. Үүнд, (а) Боловсролын чиглэлээр коллеж, их сургууль төгссөн байх: 50-аас доошгүй багц цагийг дүүргэсэн, тухайн мэргэшсэн чиглэлээр 22-оос доошгүй багц цагийн агуулгыг судалсан; (б) Магистрын зэрэгтэй төгсөх курсын оюутан байх: боловсролын чиглэлээр 50-аас доошгүй багц цагийн агуулга, мэргэшсэн чиглэлээр 22-оос доошгүй багц цагийн агуулгыг судалсан байх ёстой байдаг. Багшлах бүрэн эрхэд нэр дэвшигч нь юуны өмнө Солонгосын Боловсролын яамны дэргэдэх Солонгосын түүхийн үндэсний хүрээлэнгээс явуулдаг Солонгосын түүхийн түвшин тогтоох тестийн ахисан түвшний шалгалт өгөх ёстой байдаг.

### **2.3.12. Сингапур улсын багш бэлтгэх туршилага**

Боловсролын үндэсний хүрээлэн нь (National Institute of Education) нь багшлах хүний нөөцийг бэлтгэж буй цорын ганц сургалтын байгууллага бөгөөд бага, дунд, ахлах сургуулийн багшийг дараах хэлбэрээр бэлтгэдэг. Үүнд:

- Боловсролын диплом (2 жилийн хугацаанд бага болон дунд сургуулийн багш)
- Шинжлэх ухааны (боловсрол) бакалавр (4 жилийн хугацаанд бага болон дунд сургуулийн багш)
- Боловсролын чиглэлээр төгсөлтийн дараах диплом (1 жилийн хугацаанд бага, дунд, ахлах коллежийн багш)

Боловсролын бакалавр (3 жилийн хугацаандхагас цагаар+хагас жилийн хугацаанд бүтэн цагаар суралцах) хөтөлбөр нь мэргэших хүсэлтэй бага боловсролын багш нарт зориулагдсан. Сингапур улс нь ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн гуравны нэг хувиас чадварлаг төгсөгчдийг багшийн мэргэжлээр элсүүлдэг. Сингапурын Боловсролын яам багшийн мэргэжлээр суралцаж буй бүх оюутнуудыг сургалтын төлбөрөөс чөлөөлж, сарын цалин, тэтгэлэг олгодог. 2000 онд боловсролын салбарт хийсэн томоохон өөрчлөлтүүдийн үндсэн дээр Боловсролын үндэсний хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийг хянан сайжруулах санаачилгыг эхлүүлсэн. Энэхүү санаачилга нь 21-р зууны багшийн боловсролын загварыг (TE21) хөгжүүлэхэд томоохон нөлөөг үзүүлсэн. TE21 загвар нь Сингапурын багш боловсролд зургаан зөвлөмжийг санал болгосон (Education N. I., 2010).

1. Үнэт зүйл, ур чадвар, мэдлэг (Values, Skills, Knowledge Model (V3SK)) загварыг дахин төсөөлөх хүрээнд багш бэлтгэх боловсролын үндсийг 1. Суралцагч төвтэй; 2. Багшийн ялгарах байдал; 3. Мэргэжил, нийгэмд үйлчлэх үйлчилгээ, түүнчлэн багшийн мэргэжилтэй холбоотой чадамжаар тодорхойлсон бөгөөд эдгээр нь багш бэлтгэх сургалт хөтөлбөрүүдэд тусгагдсан байна.

2. Төгсөгч багшийн чадамж

3. Онол, практикийн уялдаа холбоог бэхжүүлэх

4. Сурган хүмүүжүүлэх чадвар

5. 21-р зууны багшлахуй, суралцахуйн үнэлгээний хүрээ

6. Хөтөлбөрийг хөгжүүлэх арга замыг сайжруулах (2 жилийн хугацааны магистрын хөтөлбөр; топ 10 хувьд зориулсан 4+1 жилийн бакалавр-магистрын түргэвчилсэн хөтөлбөр)

Боловсролын яам болон Боловсролын үндэсний хүрээлэн нь төгсөгч болон багшийн чадамжаар дамжуулан төгссөн багш нарт хүлээгдэж буй стандартуудыг тодорхойлсон. Эдгээр чадварууд нь гарааны болон одоо ажиллаж байгаа багш нарт хамаарах бөгөөд багшийн үнэлгээний журамд тусгагдсан байдаг. Сингапурт бэлтгэгдсэн мэргэжилтэн дараах чадамжтай байх ёстойг тэмдэглэжээ. Үүнд:

- Өөртөө итгэлтэй, зөв бурууг ялгах мэдрэмж өндөртэй, дасан зохицох чадвартай, тэсвэр хатуужилтай, өөрийгөө таньж мэдсэн, шүүн тунгаах чадвартай, бие даасан, шүүмжлэлтэй сэтгэдэг, үр дүнтэй харилцах чадвартай;
- Суралцахдаа өөрөө хариуцлага хүлээдэг, асуулт асууж, эргэцүүлэн бодож, суралцахын төлөө тууштай зүтгэдэг;
- Багаар үр дүнтэй ажиллах чадвартай, санаачлагатай, эрсдэлийг тооцоолсон, шинийг санаачлагч, өндөр амжилт гаргахыг эрмэлздэг идэвхтэй оролцогч; Сингапураас гаралтай, иргэний ухамсар өндөртэй, мэдээлэлтэй, эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралыг сайжруулахад идэвхтэй оролцдог санаа зовниж буй иргэн (МОЕ, 2016) байх ёстой.

### **2.3.13. Япон улсын багш бэлтгэх туршилага**

Дээд боловсролын түвшинд багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг ерөнхийдөө бакалаврын хөтөлбөр (сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх, ISCED 5) хэлбэрээр зохион байгуулдаг. Багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг их сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага болон тэдгээртэй ижил түвшин, сургалтын хөтөлбөртэй, багш бэлтгэх чиглэлийн сургалтын байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг.

Багш бэлтгэх боловсролын хөтөлбөрт хамрагдах бол дээд боловсролын сургалтын байгууллагаас зохион байгуулдаг элсэлтийн сонгон шалгаруулалтад орох бөгөөд элсэлтийн шалгуур, үйл явц нь тухайн сургалтын байгууллагаас хамаарч харилцан адилгүй байна. Түүнчлэн багш бэлтгэх хөтөлбөрүүдээр судлах агуулга харилцан адилгүй. Тухайлбал, бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөр дэх математикийн агуулгын хүрээ, судлах хэмжээ нь дунд ангийн багш бэлтгэх математикийн агуулгаас ялгаатай. Боловсролын ямар түвшинд заахаас үл хамааран багш бэлтгэх хөтөлбөрөөр судалдаг 180 цагийн ерөнхий агуулга байдаг. Үүнд: боловсролын философи, боловсролын түүх; багш мэргэжлийн ач холбогдол, багшийн чиг үүрэг (сургуулийн багийн удирдлага зохион байгуулалтад хүлээх үүрэг гэх мэт); боловсролтой холбоотой нийгэм, байгууллага, удирдлага зохион байгуулалтын асуудал (сургууль, олон нийтийн хамтын ажиллагаа, сургуулийн аюулгүй байдал гэх мэт); бага насны сурагчдын бие бялдар, сэтгэцийн хөгжил, суралцах үйл явц; тусгай хэрэгцээт сурагчдын талаарх мэдлэг ойлголт; сургалтын хөтөлбөрийн мөн чанар, зохион байгуулах арга (сургалтын хөтөлбөрийн менежмент гэх мэт); боловсрол сургалтын арга, техник (мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ гэх мэт); боловсролын зөвлөгөө, үйлчилгээ зэрэг юм. Сургуулийн өмнөх, бага, суурь боловсролын багшаар бэлтгэгдэж буй оюутнууд 3-4 долоо хоног, бүрэн дунд боловсролын багш болох оюутнууд 2-3 долоо хоногийн хугацаанд багшлах дадлага хийдэг.

Япон улсад багшлах эрхийн гурван төрлийн гэрчилгээ байдаг: (1) Багшлах эрхийн гэрчилгээ, (2) Багшлах тусгай гэрчилгээ, (3) Багшлах түр гэрчилгээ (Багшлах эрхийн гэрчилгээтэй хүмүүсийг ажилд авах боломжгүй тохиолдолд л боловсролын ажилтнуудын шалгалт авч олгоно). Японд багшлах эрхийн гэрчилгээ авахад шаардагдах гурван төрлийн

ангилал байдаг: (1) II ангиллын гэрчилгээ ISCED 5 (2 жил), (2) I ангиллын гэрчилгээ ISCED 6 (4 жил), (3) Мэргэжлийн гэрчилгээ ISCED 7 (6 жил).

### 2.3.14. Испани улсын багш бэлтгэх туршилага

Дунд боловсролын багш болоход их сургуулийн бакалаврын зэргээс гадна 60 ECTS (Европын кредит шилжүүлэх, хуримтлуулах систем)-ын боловсролын магистрын зэрэгтэй байх шаардлагатай.

Их сургууль бүр сургуулийн өмнөх болон бага боловсролын багш бэлтгэх сургалтад тодорхой хяналтын тоонд оюутныг элсүүлдэг. Их сургуулийн элсэлтийн босго оноог улсын их сургууль бүр тодорхой зэрэг олгох сургалтад элсүүлэх шаардлагын нэг хэлбэр болгож, эрэмбэлэн оюутнуудыг элсүүлдэг. Бүрэн дунд боловсролын үнэлгээний дундаж нь их, дээд сургуульд элсэх ерөнхий үнэлгээний 60 хувийг эзэлдэг. Хувийн их, дээд сургуулиуд өөрсдийн гэсэн элсэлтийн шаардлагатай байдаг тул тэдэнд босго оноо байдаггүй. Чанарын үнэлгээ, магадлан итгэмжлэлийн үндэсний агентлаг (National Agency for Quality Assessment and Accreditation of Spain) нь багш бэлтгэх боловсролын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэдэг.

Их, дээд сургуулиудын бие даан төлөвлөдөг багш бэлтгэх боловсролын хөтөлбөрөөр багш болох оюутнууд сурган хүмүүжүүлэх хичээлүүдийг судалдаг. Сургуулийн өмнөх болон бага ангийн багш бэлтгэх бакалаврын сургалтын хүрээнд оюутнууд үндэсний хууль тогтоомжоор заасан 50 кредитийн багшлах дадлагыг гүйцэтгэдэг. Дунд сургуулийн багш болох оюутнууд магистрын сургалтын хүрээнд 16 кредиттэй дүйцэх багшлах дадлага хийж гүйцэтгэнэ.

### Улс орнуудын багш бэлтгэх үйл явцын тойм

Хүснэгт 42. Улс орнууд дахь багшийн стандарт, багш бэлтгэл, багшлах эрх

		Австрали	Шинэ Зеланд	Их британи	Канад, Онтарио муж
СТАНДАРТ	Стандартыг тогтоодог газар	Үндэсний–Боловсрол, сургалтын газар (Department of Education and Training) нь Австралийн Багшлахуйн болон сургуулийн удирдлагын хүрээлэн (AITSL)-тай хамтардаг.	Үндэсний – Шинэ Зеландын Боловсролын Зөвлөл (Education Council of New Zealand -ECNZ) хариуцан, Боловсролын яам баталгаажуулдаг.	Үндэсний – Боловсролын газар (Department for Education)	Онтариогийн Боловсролын яам, Онтариогийн Багшийн коллеж
	Ажил мэргэжлийн ялгаатай түвшинд стандарт өөр байдаг эсэх	Тийм	Зөвхөн дадлагажигч багш нарыг бүртгэнэ.	Үгүй	Энэ талаарх мэдээлэл сонгосон эх сурвалжид байгаагүй.


	Багшийн стандартын тулгуурладаг онол	Бүх муж/ орон нутагт Жон Хатти (John Hattie)-ийн онол, Австралийн багшийн мэргэжлийн стандарт (APST) нөлөөлдөг.	Дадлагажигч багшийн шалгуур болон ECNZ-ээс боловсруулсан мэргэжлийн ур чадварын бусад домэйн	Майкл Барберын (Michael Barber) онол, мэргэжлийн хяналт шүүмж нөлөөлдөг.	Улс орнуудын багшийн стандартыг хоёр жил судлан, шинэ сэдэв тусгасан стандартууд
<b>БАГШ БЭЛТГЭЛ</b>	Багш бэлтгэх боловсрол олгох сургалтын магадлан итгэмжлэл	Муж/ орон нутгийн түвшний удирдлага, AITSL стандартын хурал	Үндэсний - Шинэ Зеландын Боловсролын Зөвлөл (ECNZ)	Үндэсний – Боловсролын газар	
	Туршилт / Түр хугацаанд багшлах байдал (дадлагажигч багш)	Тийм – Түр багшлах хугацаа муж/ орон нутагт ялгаатай. APST стандартын дагуу шалгадаг.	Тийм - Дадлагажигч багшийн шалгуурыг хангах чадвараас хамааран 2-6 жил үргэлжилдэг.	Тийм - Багш нар нэг жилийн туршилтын хугацаанд багшилсны дараа шалгалт өгч тэнцвэл бүртгэлд хамрагдана.	Мэргэшлийн болон бүртгэлийн түр гэрчилгээг боловсролын хөтөлбөрөө бүрэн дүүргээгүй байгаа багш нар авах боломжтой.

Хүснэгт 43. Улс орнууд дахь багшийн стандарт, багш бэлтгэл, багшлах эрх

		<b>Ану, Калифорни муж</b>	<b>Ану, Вашингтон муж</b>	<b>Сингапур</b>	<b>Өмнөд Солонгос</b>
<b>СТАНДАРТ</b>	Стандартыг тогтоодог газар	Муж – Боловсролын газар	Муж – Боловсролын газар	Сингапурын Боловсролын яам	Стандарт байхгүй
	Ажил мэргэжлийн ялгаатай түвшинд стандарт өөр байдаг эсэх	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй, гэхдээ чадамж нь хичээл судлагдахуун, суралцах жил-түвшнээс хамаарч өөр өөр байдаг.
	Багшийн стандартын тулгуурладаг онол	Энэ талаарх мэдээлэл сонгосон эх сурвалжид байгаагүй.	Энэ талаарх мэдээлэл сонгосон эх сурвалжид байгаагүй.	Шинэ хүрээ бий болгохын тулд зөвлөх, багш, сургуулийн удирдлагын санал шүүмжийн 2000 оны тойм	Англи хэлээр материал олоогүй.
<b>БАГШ БЭЛТГЭЛ</b>	Багш бэлтгэх боловсрол олгох сургалтын магадлан итгэмжлэл	Муж - Боловсролын газар, Калифорнийн Багшийн итгэмжлэлийн комисс (California Commission on Teacher Credentialing)	Муж - Вашингтон мужийн Сурлагын ахиц амжилтын зөвлөл (Achievement Council)	Байхгүй	Багшлах сургалтын бүх хөтөлбөр Солонгосын Боловсролын хөгжлийн хүрээлэнгээс магадлан итгэмжлэгдсэн байх ёстой.
	Туршилт / Түр хугацаанд багшлах байдал (дадлагажигч багш)	Тийм - Урьдчилсан итгэмжлэл (Preliminary Credential) нь таван жил үргэлжилдэг бөгөөд үүний дараа	Тийм - багшлах эхний гурван жилд эсвэл шинэ дүүрэгт, мөн багш Вашингтон мужид 2-оос дээш жил	Үгүй	Туршилтын хугацаа байхгүй; гэхдээ бүртгэлийг 2 үе шаттай хийдэг.


		багш нар түвшнээ ахиулах хэрэгтэй (Clear Credential).	ажилласан бол эхний жилдээ түршилтын байдлаар ажиллана.		
--	--	---	---	--	--

Улс орнуудын сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын багш бэлтгэх боловсрол эзэмших хугацааг боловсролын түвшин бүрээр дараах диаграммаар харуулахдаа бага боловсролын багш бэлтгэх хугацааг багнанан диаграммаар илэрхийлсэн болно.




Эх сурвалж: OECD, 2021

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын судалгаанд улс орнуудын бага, суурь боловсролын багш бэлтгэх тогтолцоонд тулгуурлан багш боловсрол эзэмших үйл явцыг зураглан харуулсан байна. Үүнээс бидний судалгаанд сонгосон зарим улс орны зураглалыг авч үзэв.




Эх сурвалж: OECD, 2019

Figure A B.2. Teacher Education Pathway in Japan




Эх сурвалж: OECD, 2019

Figure A B.3. Teacher Education Pathway in Korea



Эх сурвалж: OECD, 2019

Figure A B.5. Teacher Education Pathway – Netherlands




\*Teacher candidates entering initial teacher education for primary education (ISCED1) are required to have taken history, geography and nature and science in secondary education. Those who have not been examined in these subjects must take entry tests prior to starting the initial teacher education.

\*\*There are no central guidelines on initial teacher education content. There is a general competence regulation for working as a teacher and teacher education institutions must integrate this into their programmes. ITP's have jointly made their own guidelines on what substantive knowledge minimal should be addressed in the different ITP's. These guidelines are called "knowledge bases". Many ITP's work with a central final test, also made together, to control this substantive knowledge. Every six years, ITE programme quality is checked by an independent accreditation organisation (NVAO).

Эх сурвалж: OECD, 2019

Figure A B.6. Teacher Education Pathway in United States




Activate Windows  
Go to Settings to activate Windows.

Эх сурвалж: OECD, 2019

Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2022 онд гаргасан судалгааны хүрээнд улс орнууд, бусад төлөөлөл бүхий нийт 40 оролцогчийн өгөгдөлд тулгуурлан төрийн өмчийн сургалтын байгууллагын суурь боловсролын түвшний багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах, магадлан итгэмжлэх, үнэлж дүгнэх, санал зөвлөмж өгөхөд оролцогч талуудын үүрэг, оролцоог диаграммаар харуулсан байна.

Зураг 25. Багш бэлтгэх боловсролын талаар шийдвэр гаргахад талуудын үүрэг, оролцоо




Эх сурвалж: OECD, 2021

Энэхүү судалгаанд оролцогчдын 90 хувь нь багш бэлтгэх боловсролын сургалтын хөтөлбөрийн дизайныг дээд боловсролын сургалтын байгууллага гаргадаг бол, 62.5 хувь нь багш боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээг улс эсвэл мужийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагаас тогтоодог болохыг илэрхийлсэн байна. Багш боловсролын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үүргийг улс, мужийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага (45 хувь), эсвэл тэднийг төлөөлөх бие даасан байгууллага, агентлаг (35 хувь) хэрэгжүүлдэг байна. Харин хөтөлбөрийг үнэлж дүгнэхэд бие даасан байгууллага, агентлаг, эсвэл дээд боловсролын байгууллага нь илүү үүрэг оролцоотой байгаа бол багш боловсролын хөтөлбөрийн агуулгын талаар зөвлөгөө өгөх, санал зөвлөмж гаргахад багш нарын мэргэжлийн байгууллага, холбоод бусад талуудаас илүү үүрэгтэй оролцдог болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дэлхий даяар тогтвортой хөгжил, энх тайвныг чухалчилж байгаа өнөө үед улс орнууд боловсролын үндэсний бодлого, сургалтын хөтөлбөр, багш боловсрол, суралцагчийн үнэлгээнд дэлхийн иргэний боловсрол (ДИБ), тогтвортой хөгжлийн т боловсролыг (ТХБ) хэрхэн тусгаж байгааг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (ЭЗХАХБ) гарсан судалгааны үр дүнд харуулсан байна. Зурагт индексийн оноог 0-ээс 1-ийн хооронд авч үзсэн бөгөөд утга нь 1-д ойр байх тусам ДИБ, ТХБ-ыг боловсролын бодлого, сургалтын хөтөлбөр, багш боловсрол, үнэлгээнд илүүтэй тусгасан (буюу ДИБ, ТХБ, эсвэл эдгээрт хамаарах сэдвийг илэрхий дурдсан) болохыг илэрхийлнэ. Улс орнуудын нэрийн ард 1-ийг бичсэн нь тухайн улсын боловсролын бодлогод оноосон утга 1 болохыг илэрхийлнэ (OECD, 2022).

Зураг 26. Дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн төлөөх боловсролыг бодлого, сургалтын хөтөлбөр, багш боловсрол, үнэлгээнд тусгах байдал (2020)



ЭЗХАХБ-ын судалгааны тайланд ДИБ, ТХБ-ыг зөвхөн Бразил, Франц, Испани улсууд багадунд боловсролын бүх дөрвөн бүрдэлд тусгасан байгаа бол улс орнуудын хагас нь багадунд боловсролын бодлогод тусгасан болохыг, харин мэдээлэл өгсөн 23 улсын 3 нь (Бразил, Франц, Өмнөд Солонгос) багш боловсролд тусгасан болохыг дурдсан байна (ЭЗХАХБ, 2022).

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Шинжилгээний үр дүнгээс дараах дүгнэлтийг гаргаж болохоор байна.

*Монгол Улсын багш боловсролын бодлого, эрх зүйн хувьд:*

- Монгол Улсын боловсролын тухай хууль тогтоомжид зааснаар багш мэргэжлээр багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежид буюу бакалаврын болон дипломын сургалтаар бэлдэх боломжтой ч багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулиуд багшийг 4 жилийн хугацаанд бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэж байна.
- Багш мэргэжилд суралцахаар элсэхийн тулд иргэд бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх бөгөөд бусад мэргэжлээр элсэгчийн нэгэн адил элсэлтийн ерөнхий шалгалт өгч тэнцсэн байх шаардлагатай.
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд (2018) багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байхаар, харин багш бус мэргэжил эзэмшсэн иргэн багш мэргэжлээр суралцах бол Бага, дунд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу заах арга зүйн сургалтад хамрагдаж, шалгалт өгсний дараа багшлах эрхтэй болохоор тусгасан байна.
- Багш мэргэжлээр төгсөгч нь ажлын байранд гарсны дараа түүний мэргэжлийн тасралтгүй хөгжилд төрөөс дэмжлэг үзүүлэхээр хууль тогтоомжид зохицуулсан байна. Тухайлбал:

Боловсролын тухай хуулийн 40.8-д “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ” гэж заасан байна.

- Багш бэлтгэх сургалттай холбоотой авч хэрэгжүүлэх хэд хэдэн үйл ажиллагааг бодлогын баримт бичигт тусгасан байна. Тухайлбал: Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “2.1.37. Багш бэлтгэх сургалтын чанарын баталгаажуулалтын тусгай шалгуур үзүүлэлт бий болгож, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, сургалтын байгууллагад багшлах эрхийн баталгаажуулалтыг үе шаттай хийдэг тогтолцоог бэхжүүлнэ”, “2.1.34. Багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа, холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана” зэргээр тусгасан байна.

*Гадаадын улс орнуудын бага боловсролын багш бэлтгэх туршлагын хувьд:*

- Судалгаанд хамруулсан улс орнуудын гуравны хоёрт бага ангийн багш бэлтгэх бакалаврын боловсролын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 4 жил бөгөөд танхим болон холимог хэлбэрээр сургалтыг зохион байгуулдаг байна. Харин багш бэлтгэх боловсролын хөтөлбөр нь 5-аас дээш жил үргэлжилж буй улс оронд уг хөтөлбөрөөр суралцан төгсөгчдөд магистрын зэрэг олгож байна.
- 
- Улс орнуудад багш бэлтгэх хөтөлбөрийн агуулгад судлагдахууны агуулгаас гадна багшлахуй, сурган хүмүүжүүлэх дидактик, хүүхдийн хөгжил, сэтгэл зүй, дадлагын хичээл зэргийг авч үзэхээс гадна багшаар бэлтгэгдэж буй оюутнуудын судалгаа шинжилгээний чадварыг хөгжүүлэхийг чухалчлан авч үзэж байна.
- Судалгаанд сонгогдсон улс орнуудын бага боловсролын багш бэлтгэж буй хөтөлбөрийн багшлах дадлага багтаж байгаа бөгөөд агуулгын цөм хүрээ нь сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалт, сургалтын хөтөлбөрийн мэдлэг, ангийн менежментийн агуулгыг хамарч байна. Дадлагын үргэлжлэх хугацаа улс орнуудад харилцан адилгүй байна.
- Улс орнуудад багш бэлтгэх боловсролын сургалтад элсэгчдэд тавих шаардлага дахь нийтлэг зүйл нь бүрэн дунд боловсролтой байх, тухайн түвшний үнэлгээний дундаж оноог харгалзах тухай байна.
- ЭЗХАХБ-аас 2022 онд хийсэн судалгаанд оролцогч улс орнуудын 90 хувь нь багш бэлтгэх боловсролын сургалтын хөтөлбөрөө төлөвлөн зохион байгуулах дизайныг дээд боловсролын сургалтын байгууллага, харин 62.5 хувь нь багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээг улс эсвэл мужийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагаас тогтоодог болохыг илэрхийлсэн байна.

- Aghion, Philippe, Mathias Dewatripont, Caroline Hoxby, Andreu Mas-Colell, and Andru Sapir. (2010). *The governance and performance of universities: evidence from Europe and the US*. dash.harvard.edu:  
<https://dash.harvard.edu/bitstream/handle/1/12502061/Governance%20and%20Performance%20of%20Universities.pdf>
- AITSL. (2013). *Australian Professional standards for teachers*. www.aitsl.edu.au:  
<https://www.aitsl.edu.au/standards>
- Commission, E. (2013). *Study on Policy Measures to improve the Attractiveness of the Teaching Profession in Europe*. Luxemburg: European Union.
